



*Эдийн засгийн
бодлогын шинэтгал,
өрсөлдөх чадвар төсөл*



Нээлттэй Нийгэм Форум

МОНГОЛ УЛСАД ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, 2-Р ҮЕ ШАТ

Энэхүү тайланд илэрхийлэгдсэн зохиогчийн үзэл бодол нь АНУ-ын Засгийн газар эсвэл АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн үзэл бодлыг тусгасан байх албагүй.

Энэхүү тайланг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаар хянуулахаар туурвисан болно.

2005 оны 4 дүгээр сар



USAID
FROM THE AMERICAN PEOPLE

USAID Contract No. 438-C-00-03-00021-00

Төсөл: Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ)
Тайлангийн нэр: *Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох судалгаа - 2-р үе шат – Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниудын ижэ бүрэн судалгаа*

Тайлан бичсэн: Брюс Норланд
Гэрээний дугаар: 438-С-00-03-00021-00
Байгууллага: ЭЗБШӨЧ Төсөл/Кемоникс Интернэйшнл Инк., Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж, Таван Богд Плаза

Утас, факс: (976) 11 32 13 75 Факс: (976) 11 32 78 25
Холбоо барих хүн: Фернандо Бертоли, Төслийн удирдагч
И-мэйл хаяг: fbertoli@eprc-chemonics.biz

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ

АХБ	Азийн хөгжлийн банк
МБ	Монголбанк
ГЗ	Гүйцэтгэх захирал
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЭЗШӨЧТ	Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕТ	Ерөнхий түнш
GTZ	Германы техникийн хамтын ажиллагааны агентлаг
НББСТОУС	Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн олон улсын стандартууд
ОУСК	Олон улсын санхүүгийн корпорац
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
НАСБ	Нийтэд анх санал болгох
ӨХХ	Өгөөжийн хувь хэмжээ
ЖАЙКА	Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны агентлаг
ХК	Хувьцаат компани
KfW	ХБНГУ-ын сэргээн босголтын банк
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХТ	Хязгаарлагдмал хариуцлагатай түнш
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
Т	Монгол төгрөг
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МҮЦХ	Монголын үнэт цаасны хороо
МЦХ	Монголын цахилгаан холбоо компани
ЭЗСҮТ	Эдийн засгийн судалгааны үндэсний төв
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
КТТТ	Компанийн тухай товч танилцуулга
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
Ам. доллар	АНУ-ын доллар
НӨТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ	i
ГАРЧИГ	i
ЕРӨНХИЙ ТОЙМ.....	i
ХЭСЭГ I: ОРШИЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	1
ХЭСЭГ II: ИЖ БҮРЭН СУДАЛГАА.....	5
А. Аргачлал.....	5
А1. Хөрөнгө оруулагчдын зүгээс тавих шаардлага.....	5
А2. Компаниудых сонгон шалгаруулсан үзүүлэлт	8
Б. Мэдээллийн эх үүсвэр	8
В. Иж бүрэн судалгаа хийх явц	8
В1. Анхны уулзалт	8
В2. Судалгааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаарх шийдвэр	10
В3. Мэдээлэл оруулах ба санхүүгийн тайлан бэлтгэх.....	11
В4. Санхүүгийн дүн шинжилгээ	11
В5. Компанийн тухай товч танилцуулга (КТТТ)-ыг боловсруулах	12
Г. Нууц хадгалалт.....	12
Д. Тулгарч буй хүндрэлүүд	13
Е. Ашигласан баримт бичиг.....	13
ХЭСЭГ III: ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ	15
А. Үр дүн	15
Б. Зөвлөмж.....	17
ХАВСРАЛТ А: ЭЗБШӨЧТ-ИЙН АЖИЛЧИДТАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ	25
ХАВСРАЛТ Б: САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВАХ БОЛОМЖТОЙ КОМПАНИТАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ	29
ХАВСРАЛТ В: ИЖ БҮРЭН СУДАЛГААГ ТОВЧИЛСОН ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	35
ХАВСРАЛТ Г: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАГВАР	45
ХАВСРАЛТ Д: КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГЫГ ГАРГАХ ЗАГВАР.....	53
ХАВСРАЛТ Е: ХУВИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ - СЕМИНАР – ХӨНДСӨН АСУУДЛУУД.....	75
ХАВСРАЛТ Ё: ХУВИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ - СЕМИНАР – ИЛТГЭЛ	83
ХАВСРАЛТ Ж: ҮГСИЙН ТҮҮВЭР	117

ЕРӨНХИЙ ТОЙМ

Хоёр дахь шатны энэхүү дүн шинжилгээний зорилго нь Монгол Улсад компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх аз турших капиталын сан байгуулах боломжийг судлах техник эдийн засгийн үндэслэлийн нэгдүгээр үе шатны судалгааны урьдчилсан дүгнэлтэд үндэслэн хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хөрөнгө оруулалтын боломжийг олгож буй Монголын компаниудын иж бүрэн судалгаа явуулахад оршсон болно. Анхан шатны судалгаагаар ирээдүйд сан байгуулах нөхцлийг бүрдүүлэх шагчилсан хандлагыг санал болгосон юм. Үүнд:

1. Улс орны нөхцөл байдал, эрсдэл, цаашид өсөх ирээдүйтэй буюу "дил флоу" гэж нэрлэгдэх компани болон хөрөнгө оруулагчдын сонирхлын талаарх анхан шатны дүн шинжилгээ,
2. Цаашид өсөх ирээдүйтэй буюу "дил флоу" гэж нэрлэгдэх компани, эрх зүйн болон зохицуулалтын орчны нарийвчилсан дүн шинжилгээ,
3. Санг удирдах компани болон буцалтгүй тусламжаар санхүүжих техникийн туслалцааны бүтэц зохион байгуулалт болон Санг танилцуулах меморандумын бэлтгэл ажил
4. Санд хөрөнгө оруулалт хийх болон эрх зүйн ба зохицуулалтын орчны шинэтгэл эдгээр болно.

Анхан шатны судалгаагаар нэгдүгээр үе шатанд нааштай үр дүн гарсан тул энэхүү хоёрдугаар үе шатны дүн шинжилгээний хүрээнд хувийн хөрөнгө оруулалтын уламжлалт сангаас санхүүжүүлэх боломжтой цаашид өсөх ирээдүйтэй компанийн чанар, хэмжээг тодорхойлохыг зорьсон болно.

Бид "сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компани" буюу хөрөнгө оруулалт хийхэд нэлээд боломжийн, дараахь үндсэн шалгуур үзүүлэлтуудийг хангасан компаниудыг эрэн хайсан юм. Үүнд:

1. Менежментийн хүчирхэг баг
2. Хөрөнгө оруулагчид шаардагдах өгөөжийн хувь хэмжээг олгож чадах бүтээгдэхүүн ба үйлчилгээний том бөгөөд өсч буй зах зээл
3. Төлөвлөсөн (тодорхой) "гарц"
4. Үйл ажиллагаанд оролцох ба удирдах зөвлөлийн гишүүн байх боломж
5. Үүсгэн байгуулагчийн зүгээс үргэлжлүүлэн үзүүлэх дэмжлэг
6. Сайтар бэлдсэн баримт бичгүүд ба санхүүгийн тайлан.

Бид 24 компанийг судалж үзсэн бөгөөд эдгээрийн 8 нь илүү өргөн хүрээтэй иж бүрэн судалгаа явуулахад хангалттай үндэслэлийг олгож байв. Судалгаанд хамрагдсан ихэнх компани 1 сая ам. долларын орлоготой, 500 000 ам. долларын хөрөнгийн хэрэгцээтэй байсан. Энэ нь бидний зүгээс компанийн хэмжээний хувьд тавьсан шаардлагад нийцэж байв. Зарим компани энэ хязгаараас доогур үзүүлэлттэй байсан ч бид тэдгээрийг цаашид тогтнох чадвартай хөрөнгө оруулалтын боломжуудыг олгож буй компани гэж үзэн иж бүрэн судалгаандаа хамруулав.

Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх нь Монголын зах зээлд үр ашигтай байх эсэх талаар эцсийн тодорхой дүгнэлт гаргахад хангалттай олон тооны компанийг судлаагүй гэж зарим нэг нь үзэж байж болох юм. Энэ нь ч үнэн

оруулалт хийдэг хөрөнгө оруулагчдийн анхаарлыг татах илүү олон компани гарч ирэх боломжтой байсан байж магадгүй боловч энэ нь баталгаатай бус юм.

Бидний судалсан компаниуд өнөөдрийн байдлаар Монголд байгаа "дээд давхарга"-ын компаниудыг төлөөлж байгаа гэдэгт бид итгэлтэй байна. Найман компаниас дөрвөн компанийн таамаглан тооцоолсон өгөөжийн хувь хэмжээ нь 25 хувь буюу түүнээс дээш гарсан байв.

3. *Áàðð.* Хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэхийн тулд хөрөнгө оруулалтаас гарах арга зам буюу гарцын асуудал нь Монгол Улс шиг хөгжиж буй зах зээлийн нөхцөлд компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийхэд тавигддаг гол шаардлага болдог. Хөрөнгийн зах зээлээр дамжих гарц нь өнөөгийн байдлаар Монгол Улсад амьдрал дээр хэрэгжих боломжгүй байна. Энэ нь хэдэн жилийн дараа хэрэгжих боломжтой хувилбар болох эсэх нь тодорхойгүй бөгөөд нялх нярай хөрөнгийн зах зээлийн хөгжлөөс хамааралтай байна. Энэ нөхцөл байдалд компанийн эзэмшигчийн өмчид хийсэн хөрөнгө оруулалтаас гарах хувилбарууд хязгаарлагдмал, компанийн удирдлага өөрсдөө худалдан авах, стратегийн хөрөнгө оруулагч олох, зээлээр худалдан авах зэргээс шалтгаалдаг. Гарцтай холбоотой эдгээр хязгаарлалт эрсдлийг нэмэгдүүлдэг.
4. *Õõð¹íã° îðòóëãã-ëéí îðíëõîî áà òãèðäããð ç°ãë°ëëéí ãèøççí-ëýë.* Компанийн удирдлага болон эдийн хандлагыг дүгнэж байхад хөрөнгө оруулагчийн зүгээс компанийн хөгжлийн асуудалд оролцож, удирдах зөвлөлийн гишүүн байх шаардлагын талаар янз бүрийн санал сэтгэгдэл илэрхийлж байсан. Хувийн хөрөнгө оруулагчийн зүгээс удирдлага зааварчилгаа авах асуудлыг бидэнтэй уулзсан компаниудын тал орчим нь хүлээн зөвшөөрч байсан. Зарим нь техникийн ба санхүүгийн талаас туслалцаа авах нилээд сонирхолтой байсан. Гэхдээ зарим компаниуд хөрөнгө оруулагчийн оролцоог компанийн хэрэгт дайран орох явдал хэмээн үзэж, хөрөнгө оруулагчийн хөрөнгөөс гадна тэднийг авчрах үнэ цэнийг бүрэн ойлгохгүйтэй холбоотой байсан байж магадгүй юм.
5. *çñãýí áãëãòóëãã-ëéí äýì æëýã.* Бидэнтэй уулзсан компаниудын ихэнх нь бүлэг компаниудын нэг хэсэг байсан. Хувийн хөрөнгө оруулагчид бүлэгт багтдаг компанид хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг. Тухайн бизнест өөрийнхөө хөрөнгийн ихэнхийг зориулсан үүсгэн байгуулагчтай шууд ажиллахыг илүү сонирхдог юм.
6. *Áèçíãñëéí áàððè ò áè-ëã.* Зарим компани бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг баримт бичгийг өгсөн боловч нэг нь ч хувийн хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцэхээргүй байсан. Зах зээл хөгжиж буй Монгол Улс шиг оронд ийм зүйл гарч болох талтай.

Энэхүү үе шатны судалгааны үр дүнгээс үзэхэд хэдийгээр Монгол Улсад өсөх ирээдүйтэй компаниуд байгаа ч эдгээр нарийвчлан судлагдсан компаниудын нэг нь ч компанийн эзэмшигчийн өмчид уламжлалт аргаар хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчдын хатуу шалгуурыг давах компани байгаагүй болно. Иймд компанийн эзэмшигчийн өмчид хийх уламжлалт хөрөнгө оруулалтаас өөр хувилбарыг хайх нь зүйтэй гэж бид зөвлөж байна. Ийм төрлийн хөрөнгө оруулалттай адилтгах хөрөнгө

оруулалт буюу "хувьцаа эзэмшигчийн зээлийн сан" нь Монголын нөхцөл байдалд хамгийн тохиромжтой байж болох юм.

Бидний гаргасан тодорхой зөвлөмжүүд дараахь зүйлүүдээс бүрдэж байгаа юм. Үүнд:

1. *Үгүй өө-еэй 'и -еэ өеөб ооаеэй д'д'иā° ідбөөәөдūā пайō;æеөдеей аопаа ойеаүддөүе дīпёбөёпай пайāеэй дәәаад сәд сүүеёей пбәәеәаа үабөёәб.* Судалгааны үр дүнд цэвэр эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сан байгуулах асуудал дэмжлэг авахгүй бол эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан сан байгуулах боломж, зах зээлийг судлах нь зүйтэй. Энэхүү хоёрдугаар үе шатны техник эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар зөвхөн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх уламжлалт санд тохирох хэлцлүүдийн чанар, хэмжээг судалсан болно. Харин хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан, жижиг дунд үйлдвэрүүд (ЖДҮ)-эд чиглэгдсэн сангийн зах зээлийг судлаагүй болно. Компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан сан нь үйл ажиллагааны зардал багатай, бүтцийн хувьд зохион байгуулж хэрэгжүүлэхэд илүү хялбар, хөрөнгө оруулалтынх нь дундаж хэмжээ доогуур байх зэрэг нь түүнийг жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэх хамгийн тохиромжтой хэлбэр болгож байгаа юм. Мөн "Хувьцаа эзэмшигчийн зээлийн сан" гэж өөрөөр нэрлэгдэх энэхүү сан нь бага хүүтэй зээлийг эзэмшигчийн өмчийн цөөн хувийг эзэмших хэлбэрээр оролцох, "роялти" буюу хөрөнгө оруулагчид арилжааны өгөөж авчрахын тулд борлуулалтын хувийг төлөх зэрэгтэй хослуулсан сан юм. Зээлийн хугацаа 3-6 жилийн хооронд хэлбэлздэг, хүүгийн хувь хэмжээ нь зах зээлийн хувьтай тэнцдэг эсхүл түүнээс доогуур байдаг. Зээлийн барьцааны нөхцлийн хувьд 100 хувийн барьцаа шаардагдахгүй боловч ихэвчлэн 25-аас доошгүй хувийг бизнес, хувийн эд хөрөнгө эсвэл хувьцаагаар барьцаалдаг. "Роялти" буюу борлуулалтын хувь нь 1-5 хувьтай тэнцдэг. Компанийн эзэмшигчийн өмчид оролцох хувь нь 15-49 хувийн хооронд хэлбэлздэг бөгөөд түүнд шинэ хувьцаа гарган харин ногдол ашиг төлдөггүй. Хөрөнгө оруулалтаас гарах гарцын хувьд компанийн эзэн хувьцаагаа худалдан авах үнээр эсвэл урьд өмнө тохиролцсон борлуулалтын урьдчилан тодорхойлсон коэффициентээр эргүүлж худалдаж авдаг. Ингэснээр хөрөнгө оруулалтаас гарах гарцтай холбогдолтой хүндрэлтэй асуудал болон эзэмшигч компанийхаа эрх мэдлийг алдах явдал гардаггүй. Сан буюу гуравдагч этгээдээс буцалтгүй тусламжаар санхүүжих техникийн туслалцааны хэсэг нь шаардлагын дагуу хөрөнгө оруулалт авах компанид санхүүгийн хяналт, стратегийн төлөвлөлт, зах зээлийн дүн шинжилгээ, өртөг зардлын бүртгэл болон үнэ тогтоох журам зэргийг нэвтрүүлэх талаар санхүүгийн бус туслалцаа үзүүлнэ. ЭЗБШӨЧ төсөл Монгол Улсад компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сан байгуулах техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа явуулахад бусад байгууллагуудтай түншийн хэлбэрээр амжилттай хамтран ажиллаж ирсэн туршлагадаа үндэслэн цаашид компанийн эзэмшигчийн өмчид санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулан хувийн хөрөнгө оруулалт хийх сан байгуулах зах зээлийн судалгаа явуулах талаар Нээлттэй нийгэм форум болон бусад байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж болох юм.

ийг төлөөлж болох юм. Энэ хоёр талын хоорондох зуучлал Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Чуулга уулзалт бизнес эрхлэгч болон хөрөнгө оруулагчийг нээлттэй ярилцлага хийх замаар хооронд нь холбож, хоёр талыг зах зээлд болон бие биед нь танилцуулах газар байж болох юм. Ялангуяа ивээн тэтгэгчдийг олж бизнес эрхлэгчидтэй холбох үр ашигтай арга зам болно. Чуулга уулзалтыг зочид буудлын уулзалтын танхимд хуваарийн дагуу цугларч бизнес эрхлэгчид компанийнхаа товч танилцуулгыг хийж, хөрөнгө оруулагчид мөн өөрсдийгөө танилцуулах хэлбэрээр явуулж болох юм. Хоёр тал хоорондоо албан бусаар холбоо тогтоох боломж олгох зорилгоор чуулга уулзалтын дараа жижиг хүлээн авалт зохион байгуулж болох юм. Мөн хувийн хөрөнгө оруулалтын зах зээлээс хөрөнгө татах эсвэл хувийн хөрөнгө оруулалт хийх талаар хөрөнгө оруулагчдад сургалт зохион байгуулах зэрэг семинар эсвэл яриа хийх хэлбэрээр сургалт явуулах нь чуулга уулзалтын чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

ЭЗБШӨЧ төсөлтэй ижил төстэй төслүүд зуучлалын төлбөр хуваалцах, хэлцлийг амжилттай дуусгасны дараа гүйцэтгэлийн шимтгэлийн тодорхой хувийг төсөлд төлөх зэрэг хэлбэрийг ашиглан зуучлалын үйлчилгээг илүү идэвхтэй дэмжиж болох юм.

5. *Ас оодөөд аорбó үдлэйеодүе еёсёлíаеёлí оүйеаудеёлí лóаёлæ çсүб.* Аз турших буюу эрсдэлтэй лизинг гэдэг нь шинээр үүсгэн байгуулагдаж буй эсвэл хөгжлийн эхний шатанд байгаа компаниудад тодорхой дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн хэрэгцээг санхүүжүүлэх бололцоо олгодог арга юм.

Аз турших лизинг нь залуу компаниудад бэлэн мөнгөний зарцуулалтыг хэмнэж, хөрөнгөө бизнесийнхээ гол хэрэгцээ (жишээлбэл, эргэлтийн хөрөнгө)-нд төвлөрүүлэхэд тусладаг.

Энэ нь уламжлалт лизинг ба аз туршсан буюу эрслэлтэй хөрөнгийн хослол бөгөөд зах зээлийн тодорхой давхрагуудад хэрэгждэг. Тухайлбал: дөнгөж байгуулагдсан компаниудад хөрөнгөө дэд бүтэц болон тоног төхөөрөмжид зарцуулалгүйгээр, мөн хувийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулж өмчийнхөө хувийг бусадтай хуваалцахгүйгээр хөрөнгөө хуримтлуулахад нь туслах зорилготой. Аз турших буюу эрсдэлтэй лизингийн явцад зээлдүүлэгч нь өсч буй компанид компьютер, офисын хэрэгцээний бусад зүйлс гэх мэт тоног төхөөрөмжийг тодорхой хүүтэйгээр 3-4 жилийн хугацаанд түрээслүүлдэг. Ингэхдээ зээлдүүлэгчид түрээсийн төлбөрөөс гадна тухайн компанийн хувьцааг тодорхой үнээр худалдан авах баталгаа (варрант) шаарддаг бөгөөд энэ нь банкаас ердийн зээл эсвэл лизингийн компаниас санхүүжилт авах боломжгүй шинэ компанид лизингээр зээлдэж байгаатай холбоотой нэмэлт эрсдлийг нөхөх нөхөн олговор юм. Шинээр байгуулагдаж буй компаниудад лизингийн энэхүү хэлбэр нь олон талын ашигтай.

Нэгдүгээрт, түрээслэж буй хөрөнгийг худалдан авахын тулд зарцуулах байсан их хэмжээний бэлэн мөнгө хэмнэгдэнэ. Бэлэн мөнгийг эрдэм шинжилгээ, судалгаа, борлуулалт, маркетинг зэрэг үндсэн үйл ажиллагаанд зарцуулах боломжийг компанид олгодог.

- viii. Тогтмол үйлчлүүлэгчид
 - ix. Менежментийн баг
 - x. Зах зээлд нэвтрэхтэй холбоотой хүндрэлүүд
 - xi. Эрсдэлийн хүчин зүйлс
 - xii. Хэлцэл хийх шалтгаан ба түүний хүлээгдэж буй хэлбэр
- V. Санхүүгийн зарим мэдээлэл - Санхүүгийн загвараас гаргаж авсан
- VI. Дүн шинжилгээ
- а. Чөлөөт мөнгөн урсгал ба ӨХХ
 - б. Санхүүгийн харьцааны дүн шинжилгээ
 - в. Үндэслэл
- VII. Дүгнэлт

Нууцыг хадгалах нь хамгийн чухал асуудал байв. Энэ тайланд ямар ч Компанийн тухай товч танилцуулгыг хавсаргаагүйгээс гадна судалгааны явцад уулзаж байсан ямар ч компанийн нууц мэдээллийг энд оруулаагүй. Компанийн тухай нууц мэдээллийг хэн үзэж болох талаар одоо ч, ирээдүйд ч хатуу хязгаарлалт тавих нь зүйтэй. Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниудтай холбоотой мэдээллийн нууцыг хадгалах нь нэн чухал ач холбогдолтойг харгалзан, компани тус бүрийн Компанийн тухай товч танилцуулга болон түүнийг бэлтгэхэд ашигласан аливаа туслах баримт бичгийг зөвхөн ЭЗБШӨЧТ-ийн энэхүү судалгаанд оролцсон, нууцыг хадгалах тухай гэрээнд гарын үсэг зурсан судалгааны багийн гишүүд үзэж болно.

ЭЗБШӨЧТ нь энэхүү нууц мэдээллийг сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компани болон компаниудтай ирээдүйд хэлцэл хийх магадлалтай холбогдох талуудад зөвхөн сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниас бичгээр үйлдсэн зөвшөөрөл авч, нууцыг хадгалах тухай гэрээнд гарын үсэг зурсны дараагаар олгоно.

- *Nāiā ōōōīā° îđđōēāēō ðēēō*. Боломжит хөрөнгө оруулагчид (хувь хүн болон байгууллага)-ын санд хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нарийвчлан судалж, хөрөнгө оруулалтаасаа олохоор төлөвлөж буй өгөөжийн хувь хэмжээ, эрсдлийн төсөөлөл, эрсдлийг бууруулах арга хэмжээ, сонирхож буй салбар, хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, хөрөнгө оруулалтаа худалдах буюу "гарц"-ын стратегийн талаар дүн шинжилгээ хийх;
- *Áóóäēōāē é òóñēāì æāāð ñāíōēæēō òāōīēēēēí òóñēāēōāāí ū ñāí (ÒÒÑ) áāēāóóēāð*. Хандивлагч болон олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ)-ын компаниудыг сангаас хөрөнгө оруулалт авахад бэлтгэх, хэлцлийн бүтцийг тодорхойлоход туслалцаа үзүүлэх, сангийн хөрөнгө оруулалтад хяналт тавих, хөрөнгө оруулалт хийгдсэн компаниудад хэрэгжилт ба "гарц"-ын стратеги боловсруулахад туслалцаа үзүүлэх зорилгоор буцалтгүй тусламжаар санхүүжих техникийн туслалцааны дагалдах сан байгуулахад хувь нэмэр оруулах сонирхол ба төсөөллийг судлах;
- *Ýđō çēí áíēíí çíðēōóōēāēōūí îð-ēí, ñāíāēēí áēōēēí øāāðāēāūí òāēāāð óđūā-ēēñāí āēí øēíæēēāyú ðēēō*. Эхний гурван зорилт сэтгэл хангахуйц, боломжийн үр дүнд хүргэх тохиолдолд эрх зүйн болон зохицуулалтын орчин, сангийн бүтцийн шаардлагын талаар анхан шатны судалгаа явуулах эдгээр болно.

Анхан шатны судалгаанаас гаргасан урьдчилсан дүнд үндэслэн компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх этгээдүүдийн сонирхлыг татахуйц хөрөнгө оруулалтын нөхцөл боломж Монголд байгаа эсэхийг тодорхойлох ажлыг цаашид үргэлжлүүлэхээр тохирсон бөгөөд энэхүү судалгааны зөвлөмж нь хоёрдугаар шатны судалгааны гол тулгуур болсон юм (График I-1-ийг үзнэ үү). Анхан шатны судалгааны үеэр боловсруулсан График I-1-д компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтын санг Монголд байгуулах боломжийг судлах шатчилсан хандлагыг харуулав. Энэхүү хандлагаар сан байгуулахад өргөн хүрээтэй дараах дөрвөн үе шат буюу алхам байна. Үүнд:


1. Улс орны нөхцөл байдал, эрсдэл, цаашид өсөх ирээдүйтэй буюу "дил флоу" гэж нэрлэгдэх компани болон хөрөнгө оруулагчдын сонирхлын анхан шатны дүн шинжилгээ,
2. Цаашид өсөх ирээдүйтэй буюу "дил флоу" гэж нэрлэгдэх компани, эрх зүйн болон зохицуулалтын орчны нарийвчилсан дүн шинжилгээ,
3. Санг удирдах компани болон буцалтгүй тусламжаар санхүүжих техникийн туслалцааны бүтэц зохион байгуулалт болон Санг танилцуулах меморандумын бэлтгэл ажил
4. Санд хөрөнгө оруулалт хийх болон эрх зүйн ба зохицуулалтын орчны шинэтгэл эдгээр болно.

Сан байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох судалгааны хоёрдугаар үе шатны зорилго нь компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц хөрөнгө оруулалтын нөхцөл боломжийг олгож буй, сангаас хөрөнгө оруулалт авах сонирхолтой компаниудын иж бүрэн судалгаа хийхэд оршиж байв. График I-1-д харуулсан үйл

явцын хоёрдугаар үе шатны (улаан өнгөөр харуулав) чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг болох өсөх ирээдүйтэй компаниудад судалгаа чиглүүлсэн болно.

Тайлангийн хоёрдугаар хэсэгт иж бүрэн судалгааны явц, хэрэглэсэн аргачлалыг тайлбарлав. Гуравдугаар хэсэгт гарсан үр дүн, зөвлөмжийг нэгтгэсэн болно.

График I-1: Монгол Улсад хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх аз турших капиталын сан байгуулах шяатчилсан хандлага



ХЭСЭГ II: ИЖ БҮРЭН СУДАЛГАА

А. Аргачлал

Бид иж бүрэн судалгааны явцад "хөрөнгө оруулагчийн байр сууринаас" хандаж, энэ үүргийг сан байгуулах нөхцөл байдлыг судлаж, нотолгоо бий болгож буй Ерөнхий түнш ("ЕТ") шиг гүйцэтгэлээ. Бид "сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компани" гэж нэрлэгдэх компаниудаас таамагласан багц бүрдүүлж, түүнд 10-аас доошгүй компанийг сонгон авч оруулах оролдлого хийсэн болно. Компани тус бүр нь Монгол Улс шиг хөгжиж буй зах зээлтэй улс оронд хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг аливаа болгоомжтой хөрөнгө оруулагчийн зүгээс хөрөнгө оруулалтын багц дахь компаниас шаардах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байх ёстой.

Бид хөрөнгө оруулалтын багцын онолын дагуу эрсдлийг бууруулах зорилгоор үйл ажиллагаа нь хоорондоо аль болох урвуу хамааралтай компаниудыг сонгохыг хичээсэн юм. Гэвч Монголын зах зээл жижиг учраас энэ зорилтыг хэрэгжүүлэхэд зарим бэрхшээл гарч байв. Иймд судалгааны явцад бид "дээрээс доошоо" бус "доороос дээшээ" гэсэн зарчмыг баримтлаж Монгол Улс шиг жижиг зах зээлтэй улс оронд цаашид хөгжих ирээдүйтэй бизнес буюу компаниудад нэн түрүүнд анхаарлаа хандуулж дараа нь нь салбаруудыг авч үзэх нь зүйтэй гэж үзсэнийг тэмдэглэх нь чухал юм.

А1. Хөрөнгө оруулагчдын зүгээс тавих шаардлага

"Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниудыг" сонгон шалгаруулахдаа дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан компаниудыг судлаж үзсэн болно (Хавсралт Ё: Хувийн компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэх явц) Үүнд:

1. *ᠨᠠᠭᠡᠢ ᠢ ᠠᠶᠢᠭᠡᠢ ᠠᠶᠢ ᠳᠡᠭᠡᠢ ᠠᠶᠢᠭᠡᠢ*. Бид тухайн компанийн менежментийн туршлагыг дүгнэхдээ зөвхөн бизнесийн үйл ажиллагааг ашигтай явуулж буйг харгалзаад зогсохгүй тухайн салбарт хуримтлуулсан туршлагыг мөн харгалзсан болно. Ялангуяа компанийн удирдлага хэр зэрэг ил тод, шударга гэдгийг тогтоох нь маш чухал байлаа. Үүнээс гадна тухайн баг хөрөнгө оруулагчтай хамтарч ажиллаж чадах эсэх талыг харгалзаж үзэв. Бизнес эрхлэгчид хувийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө авах сонирхолтой хэдий ч бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад хөрөнгө оруулагчийн туслалцаа авах төдийлэн сонирхолтой биш байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Иймэрхүү дүгнэлтийг нэг, хоёр, гурван удаагийн уулзалтаар хийж болохгүй учраас менежментийн талаарх бидний дүгнэлт цөөхөн хэдэн уулзалт болон "албан бус ярианаас" хийгдсэн гэдгийг тэмдэглэх нь чухал юм. Бидэнд нааштай сэтгэгдэл төрүүлсэн удирдлагын багын хувьд ч гэсэн иймэрхүү дүгнэлт хэтэрхий эрт байж болзошгүй бөгөөд аливаа хөрөнгө оруулалт хийхээс өмнө компаниудын менежментийг дахин нарийвчлан судлах нь зүйтэй.
2. *ᠠᠳᠠᠳᠠᠠ ᠠᠶᠢᠭᠡᠢ ᠵᠡᠭᠡᠭᠡᠶᠢᠭᠡᠶᠡ ᠣᠨᠡ ᠠᠳᠡ ᠳᠢᠨ ᠴᠠᠳ ᠴᠢᠶᠡ* - ӨНДӨР ӨГӨӨЖ. Судалгааны багцад хамрагдах аливаа компани цаашид өсч хөгжих ирээдүйтэй байх шаардлагатай юм. Үүнээс гадна сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниудын удирдлага нь зах зээлийн боломжийг ашиглан зах зээлийн

A2. Компаниудых сонгон шалгаруулсан үзүүлэлт

Бид судалгаанд хамрагдах компаниудыг хэтэрхий хатуу шалгуураар сонгохыг хүссэнгүй. Тодорхой хэмжээгээр хөл дээрээ босоод үйл ажиллагаагаа явуулж буй компаниудыг сонгохыг хичээсэн. Ерөнхийдөө бид нэг сая ам. доллараас доошгүй орлоготой, 500000 ам. доллараас доошгүй хөрөнгийн эрэлт хэрэгцээтэй компаниудад анхаарлаа төвлөрүүлэв. Дараагийн 3 шалтгааны улмаас ашгийн үзүүлэлтийг оруулаагүй болно. Үүнд: 1/ Ихэнх тохиолдолд бид НББСТОУС-ын дагуу хийгдээгүй санхүүгийн тайлан тэнцэл дээр ажилласан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн мэдээг хөрвүүлэх цаг хугацаа бидэнд олдоогүй; 2/ Монголын өнөөгийн татварын байдал; 3/ Монголын олон компани гаднаас хөрөнгө татан төвлөрүүлсэн байдаг.

Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хийх хөрөнгө оруулалтын хэлцлийн зардал их өндөр байдаг тул бага хэмжээний хэлцлүүдэд ийм их өртөг зардал гаргах нь тохиромжгүй учраас дээрх шалгуур үзүүлэлтийг сонгож тавьсан гол шалтгаан юм.

Бид конгломератын нэг хэсэг болох компаниудыг сонгохгүй байхыг хичээсэн боловч бодит байдал дээр ингэх нь хэцүү байв. Энэ нь одоогийн татварын тогтолцоотой холбоотой юм. Өнөөгийн мөрдөгдөж буй татварын хувь хэмжээнээс шалтгаалан татварын өмнөх ашиг 100000000 төгрөг буюу ойролцоогоор 83000 ам.долларт хүрэхэд компаниуд олон жижиг хэсэгт хуваагдаж үйл ажиллагаагаа явуулах болдог. Учир нь тухайн компанийн татварын өмнөх ашиг цаашид өсвөл татварын дарамт хоёр дахин нэмэгддэг. Дөнгөж байгуулагдсан компанийг бид сонгохыг хүсээгүй хэдий ч нэг ийм компанийн үйл ажиллагааг иж бүрэн судалгаандаа хамруулаа.

Дээрх шалгуур үзүүлэлтүүд хэдийгээр тийм өндөр шалгуур биш байсан боловч бидний судласан зарим компани энэ шалгуурыг хангаж чадахгүй байв.

Б. Мэдээллийн эх үүсвэр

Мэдээллийн эх үүсвэр болох банкирууд, хуульчид, нягтлан бодогчид, зөвлөхүүд болон зуучлагч зэрэг бусад хүмүүстэй уулзлаа. Компаниудыг урьдчилан сонгоход эдгээр мэдээллийн эх үүсвэрүүд чухал үүрэг гүйцэтгэсэн. Хугацааны хувьд их давчуу байсан тул маш богино хугацаанд мэдээллийг цуглуулж хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө хийдэг шиг тийм их нарийвчилсан бус хэдий ч "боломжийн" судалгаа хийхийг оролдов.

Бидний ажлын гарааг эхлүүлэхэд тус дөхөм болсон эдгээр хүмүүст бид талархлаа илэрхийлж байна. Бидэнд нийт 24 компанийг санал болгосноос 8 компанийн үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж судаллаа.

В. Иж бүрэн судалгаа хийх явц

В1. Анхны уулзалт

Мэдээллийн эх үүсвэрүүдийн санал болон бидний өөрсдийн хийсэн судалгааны дагуу олж авсан компаниуд бидний гаргасан үндсэн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг харгалзаж (аль болох бүрэн) үзсэний дараа тэдэнтэй хийх уулзалтын хувиарыг гаргав. Ингэхдээ компанийн удирдлага, шийдвэр гаргагч хүмүүстэй эсвэл санхүүгийн болон менежментийн хүмүүстэй уулзахыг зорив. Анхны уулзалт нь тухайн компанийн

бизнес, олгож буй боломжуудын талаар ерөнхий төсөөлөлтэй болох зорилготой байсан бөгөөд ихэнх уулзалтыг компаниудаас гадуур хийв.

Уулзалтын явцад хөрөнгийн эх үүсвэр болох компанийн эзэмшигчийн өмчид хийх хөрөнгө оруулалтын сангийн талаар тайлбарлахад их цаг зарцуулах хэрэг гарч байлаа. Цөөхөн хэдэн компанийн хүмүүс хөрөнгө оруулалтын энэ хэлбэрийн талаар ойлголттой байлаа. Энэ сангийн ерөнхий концепц, механизмыг ойлгуулахгүйгээр судалгаа хийх бололцоогүй байсан тул бизнес эрхлэгчид их богино хугацаанд маш их мэдээллийг хүлээн авч ойлгох хэрэгтэй байлаа. Ийм нөхцөл байдлын улмаас бид компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтын санг хэрхэн байгуулах талаар сонгогдсон бүх компаниудад зориулан 4 цагийн семинарыг зохион байгуулахаар шийдэв (Хавсралт Ё, Ж: Хувийн компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэх явц). Хөрөнгийн эх үүсвэр болох энэхүү сангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь чухал байсан гэж бид үзэв.

Хувийн хөрөнгө оруулалтын талаарх анхан шатны мэдээллийг өгсний дараа компани болон бидний хувьд ч чухал болох нууцлалын асуудлаар ярилцлаа.

Тухайн компани нууцлалын гэрээний өөрийн загваргүй байх тохиолдолд бид ЭЗБШӨЧ төслөөс боловсруулсан (Хавсралт Б: Нууцыг хадгалах тухай гэрээ) гэрээний төслийг өгч, компаниудын бидэнд өгч буй мэдээллийн нууцлалыг чанд сахин хамгаалж, мэдээлийг ашиглахдаа нууцыг задруулахгүй байх талаар нууцлалын гэрээ байгуулав. Хэдийгээр хууль эрх зүйн энэхүү баримт бичигт гарын үсэг зурсан ч ЭЗБШӨЧ төсөл болон оролцогч талуудын нэр хүндийн асуудал хөндөгдөх тул нууцлалыг хоёр талаас чанд сахихын чухлыг компаниудын хүмүүст анхааруулан тайлбарлаж эс тэгвээс учрах хор уршигын талаар харилцан тохиролцов. Компаниуд өөрсдийн мэдээллийг их илэн далангүй өгч байсан нь хөрөнгийн эх үүсвэрийн бусад хувилбаруудыг олох тэдний сонирхол их буйг харуулж байлаа.

Компаниудын өгөх мэдээлэл нь Монголд компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжийг дэмжихийн тулд хангалттай олон хөрөнгө оруулалтын боломж байгааг харуулахад чухал ач холбогдолтойг мөн тайлбарлав. Уулзалтын үед бид ширээний ард хөрөнгө оруулагчтай бус харин зөвхөн тэрхүү санг байгуулах боломжийн талаар судлаж буй зөвлөхүүдийн үүрэг гүйцэтгэн сууж байсан учраас зарим бэрхшээлтэй тулгарч байв. Бид жинхэнэ хөрөнгө оруулагч биш байсан учраас тухайн компанийн талаар нарийн ширийн зүйлийг асуух амаргүй байв. Иймд энэхүү судалгаанд сайн дураар хамрагдсан компаниудад дахин талархал илэрхийлэхийг хүсч байна.

Монголд компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтын санг байгуулах боломжийг судлах энэхүү судалгааны үр дүн ямар ч гарсан тохиолдолд сонгогдсон компаниудад ЭЗБШӨЧ төсөл ба бусад газраас өөр хэлбэрээр (зуучлах, бизнесийн хөгжлийн үйлчилгээ, санхүүжилтийн бусад арга г.м.) туслалцаа дэмжлэг үзүүлэх боломж буйг компаниудад дахин тайлбарлав.

Компанийн эзэн / үүсгэн байгуулагч компанийнхаа түүх, үйл ажиллагаа, мөн өөрийнхөө намтраас (боловсрол, ажлын туршлага, амжилт зэрэг) танилцуулсаны дараа тухайн компанийг цаашид иж бүрэн судалгаанд хамруулах эсэхийг тодорхойлохын тулд зарим үндсэн асуултуудыг асууж тодруулав. Ингэхдээ компанийн хөрөнгийн бүтэц, орлогын хэмжээ, ажилтнуудын тоо, өөрийн байртай эсхүл байр түрээслэж буй эсэх, санхүүгийн холбогдолтой ерөнхий мэдээллийг

(борлуулалтын өсөлт, нийт ашиг г.м.) авч компанийн цаашдын хөгжил, төсөвлөж буй борлуулалтын өсөлт, нийт ашиг болон зах зээлийг эзлэх талаар дэвшүүлж буй ерөнхий төлөвлөгөөний талаар ойлголттой болохыг зорив. Үүнээс гадна үйл ажиллагаагаа явуулж буй салбарын хөгжил, ирээдүй болон зах зээлийн талаар компанийн хүмүүсийн саналыг сонсов.

В2. Судалгааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаарх шийдвэр

Хэрэв анхны уулзалт ярилцлагын явцад тухайн компани хөрөнгө оруулагчийн зүгээс шаардлагад нийцэх боломжтой гэж үзсэн тохиолдолд судалгаагаа үргэлжлүүлэхийн тулд дахин уулзахыг санал болгож байлаа.

Хэрэв тухайн компанийг судалгаанд үргэлжлүүлэн хамруулахгүйгээр шийдсэн бол компанийн үйл ажиллагааны талаар таагүй сэтгэгдэл төрсний улмаас бус харин одоогийн байдлаар тус компани нь хувийн хөрөнгө оруулагчийг татах шатандаа хүрээгүй байна гэж ойлгох нь зүйтэй гэдгийг компанийн хүмүүст тайлбарлав. Магадгүй ЭЗБШӨЧ төслөөс тэдэнд өөр аргаар туслах боломж байж болох талаар онцлон тэмдэглэв. Иймд хувийн хөрөнгө оруулалтыг татахгүй боловч цаашид өсөх ирээдүйтэй хэд хэдэн компани байсан тул тэдэнд санхүүгийн болон өөр хэлбэрийн туслалцаа үзүүлж болох юм.

Хэрэв тухайн компанитай дахин уулзахаар тохирсон бол Нууцлалын гэрээтэй (англи, монгол хоёр хэл дээр; маргаан гарах тохиолдолд англи хэл дээрх гэрээ хүчинтэй гэсэн нөхцлөөр) урьдчилан танилцаж, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт хийх боломж олгох үүднээс гэрээг дараагийн уулзалтын өмнө компани руу явуулж байв. Ер нь компани өөрийнхөө хуулийн зөвлөхийн боловсруулсан нууцлалын гэрээг бидэнд өгөх ёстой юм. Монголд нууцлалын гэрээ байгуулах нь шинэ зүйл байсан тул ихэнх компанид өөрийн нууцлалын гэрээ гэж байхгүй байлаа. Иймд нууцлалын талаар бидний санал болгож байсан хууль эрх зүйн баримт нь компаниудад цаашид өөрсдийн иймэрхүү гэрээг боловсруулахад ач холбогдолтой зүйл болсон гэж үзэж байна. Компаниуд хөрөнгө оруулагчтай ажиллахдаа хичнээн ухаалаг санаа гаргаж чадна төдий чинээ хөрөнгө оруулалт авах боломж нэмэгдэх тухай семинарын явцад онцлон тэмдэглэв.

Хоёр тал Нууцлалын гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсаны дараа бидний боловсруулсан иж бүрэн судалгааг товчилсон хэлбэрээр явуулахад шаардагдах мэдээллийн жагсаалтыг компаниудад илгээв (Хавсралт В: Иж бүрэн судалгааг товчилсон хэлбэрээр явуулахад шаардагдах мэдээллийн жагсаалт). Асуултыг боловсруулахдаа хөрөнгө оруулагч компанийг сонирхох тохиолдолд сонирхдог бүх асуултыг багтаахыг зорьсонгүй (хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулсан тохиолдолд хөрөнгө оруулагч эдгээр асуултын хариуг заавал шаарддаг). Асуултын уг жагсаалт нь хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар дүн шинжилгээ гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулахад тус дөхөм боллоо. Цаг хугацаа богино байсны улмаас бид мэдээллийг аль болох багасгаж, дүн шинжилгээ хийх явцыг аль болох үр дүнтэй явуулахыг хичээлээ.

Бидний тавьсан бүх асуултанд компаниуд хариулна гэж бид найдсангүй. Асуултын жагсаалтыг компанийхантай дахин уулзахаас өмнө хүргүүлсэн тул бид ямар асуулт тавьж болзошгүй талаар тэд бэлтгэлтэй байлаа. Дүн шинжилгээ гаргах явцад асуулт,

хариултыг дахин дахин тавьж тодруулах явдал түгээмэл байдаг тул нэг, хоёр удаагийн уулзалтаар хэрэгцээтэй бүх мэдээллийг авна гэдэг боломжгүй юм.

Хоёр дахь уулзалтыг компанийн байранд очиж хийсэн бөгөөд судалгааны багын ахлагч бүх уулзалтад байлцав. Энэхүү хоёр дахь уулзалтын гол зорилго эхний уулзалтаас авсан зарим мэдээллийг тодруулах, дүн шинжилгээ хийх ажлын дараагийн шатны суурийг тавихад оршиж байлаа. Мөн үүнээс гадна компанийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж тухайн компанийн эзэмшиж буй хөрөнгө, байр, тоног төхөөрөмжийн талаар дүгнэлт хийх бололцоотой байв. Хэрэв хоёр дахь уулзалтын явцад хувийн хөрөнгө оруулагчийн дүн шинжилгээ хийхэд эргэлзээ төрүүлэхэд хүргэхүйц ямарваа "нэгэн улаан туг" гарах тохиолдолд цаашид уулзалтыг дуусгаж байсан болно. Хэрэв эхний байдлаар компанийн өгсөн мэдээлэл хангалтай, үйл ажиллагаа явуулж буй байр, нөхцөл шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд багын нэг шинжээчийг тус компанийн удирдлага болон санхүү, нягтлан бодох зэрэг бусад холбогдох хүмүүстэй хамтран ажиллаж судалгааг үргэжлүүлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахаар томилж.

Дахин мэдээлэл цуглуулах ажил хэдэн долоо хоногийн туршид үргэлжилж компанийн хүмүүстэй дахин хэд хэдэн удаа уулзах шаардлага гарч байв.

V3. Мэдээлэл оруулах ба санхүүгийн тайлан бэлтгэх

Манай шинжээчид компани тус бүрийн санхүүгийн мэдээллийг авч компанийн үйл ажиллагааны түүхийг дүгнэн шинжлэхийн тулд санхүүгийн тайлан тэнцлийг (аль болох НББСТОУС-ад нийцүүлж) гаргах ажлыг хариуцаж гүйцэтгэсэн болно. Үүний дараа зөвхөн компаниас өгсөн мэдээлэлд эсвэл компанийн удирдлага, шинжээч хоёрын хамтын хүч чармайлтанд тулгуурлан тухайн компанийн санхүүгийн цаашдын урьдчилсан тооцоог гаргалаа.

V4. Санхүүгийн дүн шинжилгээ

Энэхүү судалгааг хийхдээ бид санхүүгийн хамгийн хялбар загварыг ашиглав (Хавсралт Г: Санхүүгийн тайлангийн дүн шинжилгээний загвар). Үүнээс хүнд загварыг ашиглах нь утгагүй байв. Санхүүгийн дүн шинжилгээний явцад ирээдүйн ба түүхэн борлуулалтын өсөлт, нийт ашиг, үйл ажиллагааны ашиг, цэвэр ашгийн хэмжээ, зээл болон өөрийн хөрөнгийн харьцаа, нийт хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж, хөрөнгийн эргэлт, зээл ба татварын дарамт, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон зээлийн хүүг төлөх чадвар зэргийг судалж үзсэн болно.

Санхүүгийн харьцааг ашиглах нь (стандарт болон харьцуулах үзүүлэлт нь цөөн бөгөөд тоо баримт буруу байх магадлалтай тул) тийм ч их үр дүн авчрахааргүй байлаа. Бид компанийн өсөлтийн "түүх"-ийг тогтоох мөн энэ түүх нь ямар хэмжээний чөлөөт мөнгөн урсгал болохыг тодорхойлж, үүнээс ӨХХ-г тооцоолж гаргасан юм.

Нөхцөл байдлыг хэд хэдэн хувилбараар нарийн шинжлэх хангалттай цаг хугацаа бидэнд байсангүй. Олон хувилбараар дүн шинжилгээ (энэ нь өгөөжийн хэд хэдэн үзүүлэлтийг гаргахад хамгийн тохиромжтой) хийхийн оронд төсөөлөлд хамгийн багаар авсан тооцоог ашигласан болно.

Аливаа компанийн өсөлтийн түүх дээр үндэслэн тооцоо хийхэд энэ нь их хэмжээний өгөөж авчрахааргүй тохиолдолд тус компани компанийн эзэмшигчийн өмчид

хөрөнгө оруулалт хийх хувийн хөрөнгө оруулагчийн сонирхлыг татахгүйд тооцогдож цаашид иж бүрэн судалгаанаас хасагдана.

В5. Компанийн тухай товч танилцуулга (КТТТ)-ыг боловсруулах

Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компани мэдээлэл, санхүүгийн тоо баримтаа ирүүлсний дараа Компанийн тухай товч танилцуулга ("КТТТ")-ыг боловсруулна (Хавсралт Д: Компанийн тухай товч танилцуулгын загварыг үзнэ үү). Дүн шинжилгээнд хамрагдсан компаниудын талаарх эдгээр мэдээлэл нь дараах зүйлүүдийг агуулсан болно. Үүнд:

- I. Нууцыг хадгалах тухай гэрээ - Нууц мэдээлэлтэй танилцсан аливаа уншигч гарын үсэг зурж үйлдэх гэрээ.
- II. Чухал тэмдэглэл - Энд хууль эрх зүйн чухал асуудлууд, анхаарах зүйлүүдийг хөндсөн.
- III. Компанийн тухай товч танилцуулга - Компанийн тухай мэдээллийг нэг хуудсанд багтаасан "зураглал".
- IV. Хураангуй
 - а. Ерөнхий байдал
 - б. Тусгайлан авч үзэх асуудлууд
 - i. Өсөлтийн түүхэн замнал
 - ii. Эрэлт хэрэгцээ
 - iii. Бизнесийн хамгийн гол боломж
 - iv. Ашиг олох боломж
 - v. Олон төрлийн бүтээгдэхүүн санал болгох боломж
 - vi. Зах зээлийн санхүүжилтийн нөхцөл
 - vii. Зах зээл дэх нэр хүнд
 - viii. Тогтмол үйлчлүүлэгчид
 - ix. Менежментийн баг
 - x. Зах зээлд нэвтрэх хүндрэлүүд
 - xi. Эрсдэлийн хүчин зүйлс
 - xii. Хэлцэл хийх шалтгаан ба түүний хүлээгдэж буй хэлбэр
- V. Санхүүгийн зарим мэдээлэл - Санхүүгийн загвараас гаргаж авсан
- VI. Дүн шинжилгээ
 - а. Чөлөөт мөнгөн урсгал ба ӨХХ
 - б. Санхүүгийн харьцааны дүн шинжилгээ
 - в. Үндэслэл
- VII. Дүгнэлт

Судалгааны баг тухайн компани эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хувийн хөрөнгө оруулагчийн сонирхлыг их хэмжээгээр татаж чадах эсэх талаарх санал бодлоо КТТТ-ын дүгнэлтийн хэсэгт дүгнэж нэгтгэсэн болно.

Г. Нууц хадгалалт

Нууцыг хадгалах нь хамгийн чухал асуудал байв. Компанийн тухай нууц мэдээллийг хэн үзэж болох талаар одоо ч, ирээдүйд ч хатуу хязгаарлалт тавьсан байх ёстой. Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компанийн мэдээллийн нууцыг хадгалах энэхүү гэрээний ач холбогдлыг харгалзан, компани тус бүрийн товч танилцуулга

болон түүний аливаа туслах баримт бичгийг олон нийт болон ЭЗБШӨЧТ-ийн судалгаанд шууд оролцсон багаас гадна аливаа бусад талуудад олгож болохгүй бөгөөд ирээдүйд ч олгохгүй. Нууц хадгалалтыг бага зэргээр ч зөрчсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах хор уршиг нь сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компани, ЭЗБШӨЧТ, АНУ-ын ОУХА болон энэхүү дүн шинжилгээнд оролцогч (буюу сонирхогч) бусад талуудад сөргөөр нөлөөлөх болно. Энэ тайланд ямар ч компанийн товч танилцуулгад хавсрахгүйгээс гадна судалгааны явцад уулзаж байсан ямар ч компанийн ямар ч нууц мэдээллийг энд оруулахгүй.

Нууцыг хадгалах тухай гэрээг ЭЗБШӨЧТ болон сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компанийн хооронд байгуулахаас гадна тус гэрээг ЭЗБШӨЧТ-ийн ажилтан нар болон энэхүү дүн шинжилгээнд оролцож буй холбогдох талууд, мөн сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компанийн аливаа нууц мэдээллийг хүлээн авагчтай байгуулсан болно.

Д. Тулгарч буй хүндрэлүүд

Аливаа дүн шинжилгээ хийх явцад цаг хугацааг бодолцох нь чухал асуудал болдог. Шаардлагатай мэдээллийг олж авахад тэр болгон амаргүй байдаг бөгөөд ихэнх тохиолдолд олж авсан мэдээллийг дахин боловсруулах буюу ямар нэгэн байдлаар өөрчилж, хөрвүүлэх шаардлагатай байдаг бөгөөд энэ нь цаг хугацаа алдагдуулдаг. Ихэнх компаниуд урьд өмнө өөрсдийгөө хөрөнгө оруулагчдад хэзээ ч танилцуулж байгаагүй, иймээс эдгээрийн олонхид шаардлага хангасан бизнесийн төлөвлөгөө болон санхүүгийн тайлан гаргах туршлага буюу ноу-хау байхгүй байгаа нь ойлгомжтой юм.

Е. Ашигласан баримт бичиг

- I. Нууцыг хадгалах тухай гэрээ (Хавсралт А, Б)
- II. Иж бүрэн судалгааг товчилсон хэлбэрээр явуулахад шаардагдах мэдээллийн жагсаалт (Хавсралт В)
- III. Санхүүгийн тайлангийн дүн шинжилгээний загвар (Хавсралт Г)
- IV. Компанийн тухай товч танилцуулга (Хавсралт Д-гээс загварыг үзнэ үү)

ХЭСЭГ III: ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ

А. Үр дүн

Судалгаанд хамрагдсан ихэнх компани 1 сая ам. долларын орлоготой, 500 000 ам. долларын хөрөнгийн хэрэгцээтэй байсан. Энэ нь бидний зүгээс компанийн хэмжээний хувьд тавьсан шаардлагад нийцж байв. Зарим компани энэ хязгаараас доогуур үзүүлэлттэй байсан ч бид тэдгээрийг цаашид тогтнох чадвартай хөрөнгө оруулалтын боломжуудыг олгож буй компани гэж үзэн иж бүрэн судалгаандаа хамруулав.

Хувийн компанийн эзэмшигчийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь Монголын зах зээлд үр ашигтай байх эсэхийн талаар эцсийн тодорхой дүгнэлт гаргахад хангалттай олон тооны компанийг судлаагүй гэж зарим нэг нь үзэж байж болох юм. Энэ нь үнэн ч байж болох юм. Гэвч сонгон шалгаруулах явцад бид ихээхэн чармайлт гаргаснаас гадна бидэнд санал болгосон ба бидний өөрсдийн олж авсан компаниуд нь өнөөгийн зах зээлийн санал болгож чадах хамгийн сайн үлгэр жишээ болон төлөөлөл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх этгээдийн үндсэн шалгуурыг хангахаар компани байсан байж болох юм. Бидэнтэй хийсэн анхны уулзалтын үеэр олгосон мэдээллээс үзэхэд бид хөрөнгө оруулалт хийхэд нилээд боломжтой харагдаж байсан компаниудтай уулзсан хэдий ч тэд иж бүрэн судалгаанд цаашид хамрагдах хүсэлт илэрхийлээгүй болно. Хөрөнгө оруулалтыг татаж болохуйц хамгийн их ирээдүйтэй олон компани (эдгээрийн олонхи нь гадаадын хөрөнгө оруулалттай) хөрөнгийн өөр эх үүсвэртэй байгаа бөгөөд тэдэнд хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх дотоодын сангаас хөрөнгө оруулалт хайх шаардлага байхгүй байлаа.

Компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчийн зүгээс зөвхөн авч үзвэл бид судалгааныхаа үр дүнг дараах байдлаар дүгнэсэн болно. Үүнд:

1. *ᠡᠯᠢ ᠶ᠋ᠠᠢᠳᠡᠢ ᠪᠠᠳᠡᠳᠠᠭᠠᠭᠠᠨ*. Зах зээл, бизнесүүд нь дөнгөж эхлэлийн үе шатанд байгаа хэдий ч бидэнтэй уулзсан олон компанийн удирдлагын баг болон компанийн эзэд сайхан сэтгэгдэл төрүүлсэн. Гэхдээ компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчид илүү баялаг туршлагатай, илүү олон удаа амжилтанд хүрч байсан удирдлагын багтай ажиллах эрмэлзэлтэй байдаг. Төрөл бүрийн сорилт бүхий ийм орчинд маш их хүчин чармайлт, ахиц гаргасан тул бидний судласан компаниудын удирдлагыг сайшааж алга таших хэрэгтэй. Хөгжиж буй зах зээлд туршлагагүй байх нь тийм ч нэг ер бусын зүйл биш юм. Хөгжиж буй зах зээлийн чиглэлээр мэргэжсэн хувийн хөрөнгө оруулалтын сангууд энэ асуудлыг сайн ойлгодог бөгөөд зарим нь хөрөнгө оруулалт авсан компанийн туршлагыг нэмэгдүүлэх чадвартай байдаг. Гэхдээ ихэнх сан хөрөнгө оруулагчийн зүгээс шаардах бусад шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд л энэ асуудлыг харгалзаж үздэг. Бидний уулзаж ярилцсан ихэнх компанийн удирдлага, эзэд мэдээлэл өгөх талаар бидэнтэй хамтран ажиллах хүсэл байсан хэдий ч компанийн ил тод байдал, итгэл хүлээх

Компани	ӨХХ
А	25%
Б	3%
В	41%
Г	байхгүй*
Д	36%
Е	47%
Ж	21%
З	-2%

хөрөнгийн ихэнхийг зориулсан үүсгэн байгуулагчтай шууд ажиллахыг илүү сонирхдог юм.

6. *Áèçíàñèéí áàðèì ò áè-èã.* Зарим компани бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн тайлан тэнцэл зэрэг баримт бичгийг өгсөн боловч нэг нь ч хувийн хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцхээргүй байсан. Зах зээл хөгжиж буй Монгол Улс шиг оронд ийм зүйл гарч болох юм.

Б. Зөвлөмж

Бидний гаргасан тодорхой зөвлөмжүүд дараахь зүйлүүдээс бүрдэж байгаа юм. Үүнд:

1. *Ýçýì øèà-èéí °ì -èã ðèéò ðáàèéí ð°ð°íã° îðóóèäèòóñ ñàíòççæèèðèéí áóñàä òýéáýðòýé ðìñèóóèñàí ñàí àèéí òàèààð çàò çýýèèéí ñóààèãàà ýáóóèä.* Судалгааны үр дүнд цэвэр эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сан байгуулах асуудал дэмжлэг авахгүй бол эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан сан байгуулах боломж, зах зээлийг судлах нь зүйтэй. Энэхүү хоёрдугаар үе шатны техник эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар зөвхөн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх уламжлалт санд тохирох хэлцлүүдийн чанар, хэмжээг судалсан болно. Харин хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан, жижиг дунд үйлдвэрүүд (ЖДҮ)-эд чиглэгдсэн сангийн зах зээлийг судлаагүй болно. Компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтыг санхүүжилтийн бусад хэлбэртэй хослуулсан сан нь үйл ажиллагааны зардал багатай, бүтцийн хувьд зохион байгуулж хэрэгжүүлэхэд илүү хялбар, хөрөнгө оруулалтынх нь дундаж хэмжээ доогуур байх зэрэг нь түүнийг жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэх хамгийн тохиромжтой хэлбэр болгож байгаа юм. Мөн "Хувьцаа эзэмшигчийн зээлийн сан" гэж өөрөөр нэрлэгдэх энэхүү сан нь бага хүүтэй зээлийг эзэмшигчийн өмчийн цөөн хувийг эзэмших хэлбэрээр оролцох, "роялти" буюу хөрөнгө оруулагчид арилжааны өгөөж авчрахын тулд борлуулалтын хувийг төлөх зэрэгтэй хослуулсан сан юм. Зээлийн хугацаа 3-6 жилийн хооронд хэлбэлздэг, хүүгийн хувь хэмжээ нь зах зээлийн хувьтай тэнцдэг эсхүл түүнээс доогуур байдаг. Зээлийн барьцааны нөхцлийн хувьд 100 хувийн барьцаа шаардагдахгүй боловч ихэвчлэн 25-аас доошгүй хувийг бизнес, хувийн эд хөрөнгө эсвэл хувьцаагаар барьцаалдаг. "Роялти" буюу борлуулалтын хувь нь 1-5 хувьтай тэнцдэг. Компанийн эзэмшигчийн өмчид оролцох хувь нь 15-49 хувийн хооронд хэлбэлздэг бөгөөд түүнд шинэ хувьцаа гарган харин ногдол ашиг төлдөггүй. Хөрөнгө оруулалтаас гарах гарцын хувьд компанийн эзэн хувьцаагаа худалдан авах үнээр эсвэл урьд өмнө тохиролцсон борлуулалтын урьдчилан тодорхойлсон коэффициентээр эргүүлж худалдаж авдаг. Ингэснээр хөрөнгө оруулалтаас гарах гарцтай холбогдолтой хүндрэлтэй асуудал болон эзэмшигч компанийхаа эрх мэдлийг алдах явдал гардаггүй. Сан буюу гуравдагч этгээдээс буцалтгүй тусламжаар санхүүжих техникийн туслалцааны хэсэг нь шаардлагын дагуу хөрөнгө оруулалт авах компанид санхүүгийн хяналт, стратегийн төлөвлөлт, зах зээлийн дүн шинжилгээ, өртөг зардлын бүртгэл болон үнэ тогтоох журам зэргийг нэвтрүүлэх талаар санхүүгийн бус туслалцаа үзүүлнэ. ЭЗБШӨЧ төсөл Монгол Улсад компанийн эзэмшигчийн

боломжуудад сангийн механизмаар бус харин хувиараа эсвэл тухайн компанийн онцлогт тохируулсан бусад аргаар хөрөнгө олж өгч чадах Монголын ивээн тэтгэгчид байна. Энэ үйл ажиллагаанд гүүр шаардагдаж байна. Хөрөнгө оруулалтын буюу худалдааны банк хөрөнгө оруулалтын боломж ("худалдах тал")-ийг эсвэл хөрөнгө оруулагч ("худалдан авах тал")-ийг төлөөлж болох юм. Энэ хоёр талын хоорондох зуучлал Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Чуулга уулзалт бизнес эрхлэгч болон хөрөнгө оруулагчийг нээлттэй ярилцлага хийх замаар хооронд нь холбож, хоёр талыг зах зээлд болон бие биед нь танилцуулах газар байж болох юм. Ялангуяа ивээн тэтгэгчдийг олж бизнес эрхлэгчидтэй холбох үр ашигтай арга зам болно. Чуулга уулзалтыг зочид буудлын уулзалтын танхимд хуваарийн дагуу цугларч бизнес эрхлэгчид компанийнхаа товч танилцуулгыг хийж, хөрөнгө оруулагчид мөн өөрсдийгөө танилцуулах хэлбэрээр явуулж болох юм. Хоёр тал хоорондоо албан бусаар холбоо тогтоох боломж олгох зорилгоор чуулга уулзалтын дараа жижиг хүлээн авалт зохион байгуулж болох юм. Мөн хувийн хөрөнгө оруулалтын зах зээлээс хөрөнгө татах эсвэл хувийн хөрөнгө оруулалт хийх талаар хөрөнгө оруулагчдад сургалт зохион байгуулах зэрэг семинар эсвэл яриа хийх хэлбэрээр сургалт явуулах нь чуулга уулзалтын чухал бүрэлдэхүүн хэсэг болно.

ЭЗБШӨЧ төсөлтэй ижил төстэй төслүүд зуучлалын төлбөр хуваалцах, хэлцлийг амжилттай дуусгасны дараа гүйцэтгэлийн шимтгэлийн тодорхой хувийг төсөлд төлөх зэрэг хэлбэрийг ашиглан зуучлалын үйлчилгээг илүү идэвхтэй дэмжиж болох юм.

5. *Аз турших буюу эрсдэлтэй лизинг гэдэг нь шинээр үүсгэн байгуулагдаж буй эсвэл хөгжлийн эхний шатанд байгаа компаниудад тодорхой дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн хэрэгцээг санхүүжүүлэх бололцоо олгодог арга юм.*

Аз турших лизинг нь залуу компаниудад бэлэн мөнгөний зарцуулалтыг хэмнэж, хөрөнгөө бизнесийнхээ гол хэрэгцээ (жишээлбэл, эргэлтийн хөрөнгө)-нд төвлөрүүлэхэд тусладаг.

Энэ нь уламжлалт лизинг ба аз туршсан буюу эрслэлтэй хөрөнгийн хослол бөгөөд зах зээлийн тодорхой давхрагуудад хэрэгждэг. Тухайлбал: дөнгөж байгуулагдсан компаниудад хөрөнгөө дэд бүтэц болон тоног төхөөрөмжид зарцуулалгүйгээр, мөн хувийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулж өмчийнхөө хувийг бусадтай хуваалцахгүйгээр хөрөнгөө хуримтлуулахад нь туслах зорилготой. Аз турших буюу эрсдэлтэй лизингийн явцад зээлдүүлэгч нь өсч буй компанид компьютер, офисын хэрэгцээний бусад зүйлс гэх мэт тоног төхөөрөмжийг тодорхой хүүтэйгээр 3-4 жилийн хугацаанд түрээслүүлдэг. Ингэхдээ зээлдүүлэгчид түрээсийн төлбөрөөс гадна тухайн компанийн хувьцааг тодорхой үнээр худалдан авах баталгаа (варрант) шаарддаг бөгөөд энэ нь банкнаас ердийн зээл эсвэл лизингийн компаниас санхүүжилт авах боломжгүй шинэ компанид лизингээр зээлдэж байгаатай холбоотой нэмэлт эрсдлийг нөхөх нөхөн олговор юм. Шинээр байгуулагдаж буй компаниудад лизингийн энэхүү хэлбэр нь олон талын ашигтай.

**ХАВСРАЛТ А: ЭЗБШӨЧТ-ИЙН АЖИЛЧИДТАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ
ТУХАЙ ГЭРЭЭ**

ХАВСРАЛТ А: ЭЗБШӨЧТ-ИЙН АЖИЛЧИДАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ



Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл



Кемоникс Интернэйшнл ХХК (цаашид "Кемоникс" гэж нэрлэх) буюу Кемоникстай дэд гүйцэтгэгчийн гэрээтэй компани (мөн "Кемоникс" гэж үзэх)-ийн ажилтан болон зөвлөхтэй байгуулах

НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Кемоникстай байгуулах хөдөлмөрийн гэрээг харгалзан миний бие Кемоникс, түүний харилцагч болон үйлчлүүлэгчийн эдийн засгийн байдал, нэр хүндэд нэн чухал ач холбогдолтой нууц ба Кемониксын өмч болох мэдээлэл ба баримт бичигтэй харьцах болно. Миний бие хөдөлмөрийн гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсны дараа хөдөлмөр эрхлэлтийнхээ үеэр авах эсвэл боловсруулах Кемониксын өмч болох эсвэл нууц гэж тооцогдох аливаа мэдээлэл, мэдлэг буюу баримтыг ашиглахгүй, бусад дэлгэн тавихгүй болно. Үүнд Кемоникст түүний одоогийн ба ирээдүйн харилцагч, хамтрагч ба Кемониксын үйлчилгээг авч буй бусад үйлчлүүлэгчдийн өгсөн мэдээлэл багтана. Жишээ дурьдвал дээрх мэдээлэл, мэдлэг, баримтанд үйлдвэрлэлийн арга, ноу хау, зураг төсөл, зураг, диаграм, томъёо, туршилтын мэдээ, нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн мэдээ, үнэ буюу цалингийн мэдээ, маркетингийн мэдээ, бизнесийн төлөвлөгөө ба стратеги, гэрээ хэлэлцээр, эрдэм шинжилгээний ажил, харилцагч ба худалдагчийн жагсаалт, зохион бүтээл, ба ["худалдааны нууц"] нээлт зэрэг багтана.

Үүнээс гадна Кемоникстай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсны дараа дээрх мэдээлэл, мэдлэг, баримтыг агуулсан ба тэдгээртэй холбоотой бүх баримт бичгийг Кемоникст нэн даруй буцааж өгнө гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энэхүү гэрээ нь миний үйл ажиллагааг үргэлжлүүлэх этгээд, үс залгамжлагч, эрх хүлээн авагч болон төлөөлөгчдийн хувьд заавал биелэгдэх хүчинтэй байх бөгөөд Кемониксын үйл ажиллагааг үргэлжлүүлэх этгээд ба эрх хүлээн авагчийн ашиг сонирхолд нийцсэн байна.

Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарч, шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд давамгайлах тал нь тодорхой хэмжээний хуульчийн шимтгэл, зардлыг төлүүлэх эрхтэй байна. Кемониксээс нилээд их хэмжээний өртөг зардал гаргаж өмч болох мэдээлэл болон худалдааны нууцыг бүтээсэн бөгөөд эдгээрийг зөвшөөрөлгүйгээр ашиглах эсвэл дэлгэн тавих явдал нь Кемоникст нөхөн залруулашгүй хохирол учруулна гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Энэхүү заалтыг зөрчсөнтэй холбоотойгоор гаргасан аливаа шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

Миний Кемоникстэй цаашид хамтран ажиллах эсэх нь энэхүү гэрээний заалтыг даган мөрдөхөөс хамаарна гэдгийг ойлгож байна.

Зохицуулах хууль

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль журамд захирагдан, тэдгээрийн дагуу тайлбарлагдана.

Ажилтан (зөвлөх)-ийн гарын үсэг

Ажилтан (зөвлөх)-ийн нэр

Огноо

**ХАВСРАЛТ Б: САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВАХ БОЛОМЖТОЙ
КОМПАНИТАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

ХАВСРАЛТ Б: САНГААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВАХ БОЛОМЖТОЙ КОМПАНИТАЙ БАЙГУУЛАХ НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ



*Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх
чадвар төсөл*



НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Нууцыг хадгалах тухай энэхүү гэрээг /цаашид "Гэрээ" гэх/ нэг талаас _____ /цаашид "Өмчлөгч" гэх/, нөгөө талаас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-аас санхүүжиж буй Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл (ЭЗБШӨЧТ)-ийг төлөөлж буй Кемоникс Интернэшнэл корпораци /цаашид "Хүлээн авагч" гэх/-ийн хооронд оны ...-р сарын ...-ний өдөр байгуулсан болно.

Өмчлөгч болон Хүлээн авагчийн хооронд Хүлээн авагчаас үзүүлж болох бизнесийн хөгжлийн үйлчилгээ, үйл ажиллагааны дэмжлэгийн асуудлаар хийсэн уулзалт, ярилцлагын үеэр Өмчлөгч нь өөрийн бизнесийн төлөвлөгөө, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид, санхүүгийн болон үйл ажиллагаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөө зэрэг асуудалтай холбоотой зарим нууцлалтай мэдээллийг Хүлээн авагчид өгөх тохиолдол гарч болох **НӨХЦЛИЙГ ХАРГАЛЗАН**;

Өмчлөгч нь зарим мэдээллийн нууцлалыг хадгалж, дээр дурдсан мэдээллийг албан ёсны зөвшөөрөлгүйгээр түгээх явдлаас зайлсхийхийг эрмэлзэж буйг **ХАРГАЛЗАН ҮЗЭЖ**;

Энэхүү гэрээний хүрээнд дор тодорхойлсон "нууцлалтай мэдээллийг" албан ёсны зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд задруулахаас сэргийлэхээ хоёр тал илэрхийлж буйг **ХАРГАЛЗАН**

Энэ асуудлыг хууль ёсны болгох үүднээс хоёр тал дараах зүйлийг тохиролцов:

1. Нууцлалтай мэдээллийн тодорхойлолт

Өмчлөгч нь өөрийн өмчлөлийн, нууцлалтай мэдээллийн тодорхой хэсгийг (цаашид "Нууцлалтай мэдээлэл" гэх) Хүлээн авагчид өгөхийг санал болгож байна. Нууцлалтай мэдээлэл гэдэг нь бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, материал, технологи, компьютерийн программ, техникийн үзүүлэлт, гарын авлага, бизнес төлөвлөгөө, программ хангамж, маркетингийн төлөвлөгөө, санхүүгийн мэдээлэл, арилжааны үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг хэлэх бөгөөд үүний дотор электроник буюу хэвлэмэл хэлбэрийн судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэл, худалдан авалт, нягтлан бодох бүртгэл, техник-инженерийн шийдэл, маркетинг, сурталчилгаа, үнийн бодлого, борлуулалт, түүнчлэн одоогийн болоод хэтийн үйлчлүүлэгчид, гол ажилтнууд, болох гэж буй тендер болон саналуудын талаарх мэдээлэл, одоогийн үйлдвэрлэж буй болон үйлдвэрлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүний төрөл, хөтөлбөр, тэмдэглэлүүд, баримт материал, мэдээлэл зэрэг багтана. Нууцлалтай бүх мэдээллийг "Нууцлалтай" гэж тодорхой тэмдэглэнэ. Амаар мэдэгдсэн нууцлалтай мэдээлэл нь нэн даруй нууцлалтай мэдээлэлд тооцогдоно. Эдгээр заалт нь Өмчлөгчид өөрийн нууц мэдээллийг задлах үүрэг хүлээлгээгүй болно.

Хүлээн авагч нь уг гэрээг зөрчилгүйгээр, эсвэл нууцлалыг хадгалах үүрэг хүлээлгүйгээр зохих ёсоор авсан мэдээлэл, эсвэл энэхүү гэрээг зөрчихгүйгээр боловсруулсан нууцлалтай мэдээллийг олны хүртээл болгосонтой холбогдолтой аливаа үүрэг хариуцлагыг энэхүү гэрээ ёсоор хүлээхгүй болно.

2. Нууцлалтай мэдээллийг ашиглах нь

Хүлээн авагч нь Өмчлөгчөөс олгосон нууцлалтай мэдээллийг Өмчлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу сонирхсон гуравдагч талтай хамтран бизнесийн хөгжил, үйл ажиллагааны туслалцаа дэмжлэг үзүүлэх бололцоог үнэлэн тооцоолох онцгой бөгөөд цорын ганц зорилгоор ашиглана. Хүлээн авагч нь эдгээр мэдээллийг Өмчлөгчийн бизнес үйл ажиллагаанд шууд буюу шууд бус байдлаар харшлан өрсөлдөхөд ашиглуулахгүй бөгөөд ашиглах боломжийг гаргахгүй. Хүлээн авагч нь эдгээр нууцлалтай мэдээллийг өөрийн мэдээлэлтэй адилтган үзэж, тэдгээрийг хулгайлах, Өмчлөгчийн итгэмжилсэн талуудтай хамтран ажиллах үйл ажиллагаанд шууд оролцоогүй ажилтнуудад ашиглуулах, хуулуулахаас хамгаалах үүргийг хүлээнэ.

3. Онцгой эрх

Өмчлөгчөөс Хүлээн авагчид олгосон бүх нууцлалтай мэдээлэл нь Өмчлөгчийн онцгой өмчлөлд байх цорын ганц мэдээлэл бөгөөд Хүлээн авагч уг мэдээллийг Өмчлөгчийн хүсэлтийн дагуу буцаан олгох буюу устгах үүргийг хүлээнэ. Энэхүү гэрээний заалтууд аливаа нууцлалтай мэдээллийг лицензээр буюу өөр ямарваа хэлбэрээр шилжүүлж буюу олгож буй утгыг агуулаагүй болно.

4. Мэдээллийг хууль ёсны дагуу олгох нь

Засгийн газрын агентлагаас хууль зүйн эрхийн дагуу хүсэлт тавьсан тохиолдолд Хүлээн авагч нь Өмчлөгчөөс олгосон нууцлалтай мэдээллийг задруулах шаардлага гарч болно. Хүлээн авагч нь тийнхүү мэдээлэл олгох хүсэлт авсан тухайгаа Өмчлөгчид бичгээр мэдэгдэх үүргийг хүлээнэ.

5. Гэрээний хүчинтэй байх хугацаа

Талууд уг гэрээний хугацаа дуусахаас өмнө бичгээр мэдэгдэн дуусгавар болгохоос бусад тохиолдолд энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

6. Эцсийн зөвшилцөл

Энэхүү гэрээ нь үүнд дурдагдсан асуудлаар Өмчлөгч болон Хүлээн авагчийн хооронд урьд өмнө байгуулсан ямарваа гэрээ, ойлголцлыг дуусгавар болгох ба тэдгээрийг цуцалсанд тооцно. Хоёр тал бичгээр зөвшилцсөний дагуу энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7. Бусад этгээдэд шилжүүлэхгүй байх

Хүлээн авагч нь Өмчлөгчөөс бичгээр урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд энэхүү гэрээ болон түүнд тусгагдсан аливаа ашиг сонирхлыг бусад этгээдэд шилжүүлэх эрх эдлэхгүй.

8. Тусгайлан үзэх нь

Энэхүү гэрээний ямарваа заалт тодорхойлолтыг шүүх буюу хууль зүйн эрх бүхий байгууллага хүчингүй, эсвэл хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд энэхүү гэрээ болон бусад заалтууд нь үүнийг үл харгалзан хүчин төгөлдөр хэвээр байна.

9. Зохицуулах хууль

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль журамд захирагдан, тэдгээрийн дагуу тайлбарлагдана.

Талууд энэхүү гэрээг дээр дурдсан он, сар, өдөр байгуулсныг **ҮҮГЭЭР ГЭРЧИЛНЭ**.

“ХҮЛЭЭН АВАГЧ”, Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төслийг төлөөлөн, CHEMONICS INTERNATIONAL INC.,

Нэр: Фернандо Бертоли
Төслийн удирдагч
Хаяг: Кемоникс Интернэйшнл корпораци
Таван богд плаза, 2-р давхар
Ерөнхий сайд Амарын гудамж-2
Улаанбаатар, Монгол Улс
Утас: (976) 11 32 13 75
Факс: (976) 11 32 78 25
Электрон хаяг: fbertoli@chemonics.net

ХҮЛЭЭН АВАГЧ-ийн итгэмжлэгдсэн
төлөөлөгчийн гарын үсэг:

Өмчлөгчийн нэр:
Хаяг:

Утас:
Факс:
Электрон хаяг:

ӨМЧЛӨГЧ-ийн итгэмжлэгдсэн
төлөөлөгчийн гарын үсэг:

**ХАВСРАЛТ В: ИЖ БҮРЭН СУДАЛГААГ ТОВЧИЛСОН ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХАД
ШААРДАГДАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

ХАВСРАЛТ В: ИЖ БҮРЭН СУДАЛГААГ ТОВЧИЛСОН ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ГАРЧИГ

<u>Ерөнхий зүйл</u>	36
<u>Бүтээгдэхүүний нэр төрөл</u>	36
<u>Зах зээл</u>	37
<u>Үйлдвэр, хэрэгсэл хангамж</u>	37
<u>Үйлдвэрлэл</u>	38
<u>Бэлтгэн нийлүүлэлт</u>	38
<u>Бараа материал ба өртөг</u>	38
<u>Хөдөлмөрийн асуудлууд</u>	38
<u>Санхүүгийн тоо баримт</u>	39
<u>Тайлан балансын дүн шинжилгээ</u>	39
<u>Санхүүжилт, хөрөнгийн бүтэц</u>	40
<u>Санхүүгийн таамаглал, тооцоо</u>	40
<u>Санхүүгийн менежмент</u>	40
<u>Мэдээллийн технологи</u>	41
<u>Даатгал</u>	41
<u>Татварын асуудал</u>	41
<u>Гааль</u>	41
<u>Төлөвлөлт</u>	41
<u>Дотоод хяналт</u>	42
<u>Эрдэм шинжилгээ, судалгаа, инженер-техникийн шийдэл</u>	42
<u>Хууль эрх зүйн асуудлууд</u>	42

Ерөнхий зүйл
1. Компанийн бүтээгдэхүүний зах зээл дэх нэр хүнд?
2. Зах зээлд эзлэх хувь хэмжээний өсөлт, бууралтын хандлага?
3. Өрсөлдөгчдийн хувьд сүүлийн үед ажиглагдсан гол өөрчлөлтүүд?
4. Компанийн үйл ажиллагаанд төрийн зохицуулалтын хэр нөлөөлж байгаа байдал, түүний цар хүрээ?
5. Компанид нөлөө үзүүлж буй бусад гадаад хүчин зүйлс?
6. Төлөвлөж байгаа буюу одоо гарч байгаа шинэ өөрчлөлт. Үүнд:
- Компанийн тухайн салбарт эзлэх байр суурьтай холбоотой хөтөлбөрүүд
- Тоног төхөөрөмжид хийхээр төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт
7. Өвөрмөц ур чадвар болон давуу талууд. Үүнд:
- Технологи
- Эзэлж буй зах зээл
- Зах зээлд амжилт олсон шинэ бүтээгдэхүүн
- Томоохон хямралыг гэтлэн давсан туршлага
- Сайн хөгжсөн дотоод мэдээллийн систем
8. Компанийн эсрэг хийхээр зэхэж байгаа буюу гарч болзошгүй шүүхийн томоохон нэхэмжлэл
9. Компанийн үйл ажиллагаа явуулдаг салбарт нөлөөлдөг улирлын шинж чанартай хүчин зүйлс
10. Сүүлийн хэдэн жилд зогсоосон буюу ойрын үед зогсоох магадлалтай байгаа үйл ажиллагаа?
11. Хугацаа нь дуусах гэж буй гэрээ хэлэлцээр ба түрээс?
12. Санхүүжилт олох болон хөрөнгөө өсгөх оролдлого бүтэлгүй болсоны шалтгаан
13. Тухайн салбарын компаниудтай харьцуулахад эсрэгээр нөлөөлж буй хүчин зүйлс?
Бүтээгдэхүүний нэр төрөл
1. Гол бүтээгдэхүүн ба үйлчилгээ
2. Тухайн салбарын бүтээгдэхүүн болон үйлчилгээний хэв маягт гарсан буюу гарах магадлалтай өөрчлөлтүүд
3. Танай бүтээгдэхүүн/үйлчилгээний зах зээлд оршин тогтнож байгаа үе шат
4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжил, бүтээгдэхүүний шинэ хэрэглээ
5. Компанийн одоогийн байдлаар үзүүлээгүй үйлчилгээ буюу салбарын

бүтээгдэхүүний сегмент
6. Зохиогчийн эрх, патент ба худалдааны тэмдгийн хамгаалалт
Зах зээл
1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоод болон экспортын эрэлт
2. Бүтээгдэхүүний эрэлт, түүний өсөлтөнд нөлөөлдөг хүчин зүйлс (бизнесийн ерөнхий нөхцөл байдал, хүн амын өөрчлөлт, засгийн газрын бодлого, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний өөрчлөлт буюу технологийн шинэчлэл)
3. Дотоодын болон гадаадын хэрэглэгчдийн тоо ба төрөл (хувь хүмүүс, төмөр зам, дэд бүтцийн үйлдвэр аж ахуйн газрууд, аж үйлдвэрийн компани, арилжааны буюу санхүүгийн бизнесийн байгууллага, төв буюу орон нутгийн засаг захиргаа, үйлчилгээний байгууллага), хэрэглэгчидтэй байгуулсан гэрээт харилцаа, чухал худалдан авагчдад олгосон тусгай хөнгөлөлт болон зээлийн нөхцөл/хугацаа, нэг буюу олон худалдан авагчдаас хамааралтай байдал
4. Хэрэглэгчдийн төрөл, газар зүйн байршил, бүтээгдэхүүн, түүний хуваарилалт, үнээр ангилсан зах зээлийн сегментацчилал
5. Зах зээлийн сегментацчилалд хандах компанийн хандлага
6. Борлуулалтын улирлын чанартай хэлбэлзэл ба тогтсон хэв загварт гарч байгаа өөрчлөлт
7. Компани "төлөвшсөн" зах зээлд үйл ажиллагаа явуулж буй эсэх
8. Бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэнээс хойшхи үеийн борлуулалтын үр дүн, гадаад хүчин зүйлс болон компаниас авсан арга хэмжээний үр дүнд гарсан аливаа ноцтой өөрчлөлт шинэчлэл
9. Зах зээлд эзлэх хувь хэмжээ болон компаниас гаргасан хичээл зүтгэлийн үр дүнд зах зээлээ өргөтгөх боломж
10. Борлуулалтын хүлээгдэж буй гүйцэтгэлийн төсөөлөл болон зах зээлд эзлэх хувийн тооцоо, тухайн салбарын төлөвлөгөөтэй харьцуулсан байдал
11. Хамгийн гол өрсөлдөгчид ба өрсөлдөхүйц практик, өрсөлдөгчидтэй харьцуулсан аливаа давуу тал
12. Бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлт, зар сурталчилгаа болон борлуулалтыг нэмэгдүүлэхэд хэрэглэдэг тогтсон зарчим/үйл ажиллагаа
Үйлдвэр, хэрэгсэл хангамж
1. Үйлдвэр, өмч хөрөнгийн байршил ба тэдгээрийн тодорхойлолт (тээврийн хэрэгсэлд ойр эсэх, материал болон ажиллах хүчний хангамж, шаардлагатай хэрэгсэл хангамж байгаа эсэх, тэдгээрийн ашиглалт, өмч хөрөнгө эзэмших эрх, даатгуулсан байдал)
2. Газрын талаарх мэдээлэл (хэмжээ, зах зээлийн (үнэлгээ хийсний дараахь) үнэ)
3. Гол машин тоног төхөөрөмж (нас, нөхцөл байдал, технологи хуучирсан

байдал, элэгдэл хорогдол, байршил ба тасгийн ашиглалт)
4. Аливаа илүүдэл болон ашиглагдаагүй байшин барилга, тоног төхөөрөмж
5. Ирээдүйд шаардлагатай үйлдвэр, машин, тоног төхөөрөмжийн тооцоо?
Үйлдвэрлэл
1. Үйлдвэрлэлийн явцын шинж чанар (жишээ нь угсралт, механикийн цех, олборлолт, метал хийц зэрэг)
2. Үйлдвэрлэлийн явцын чухал хэсэг (жишээ нь капитал хөрөнгө оруулалт, ноу-хау, үйлдвэрийн зохион байгуулалт, ур чадвартай ажиллах хүч, ажиллах хүчин байгаа г.м.)?
3. Үйлдвэрлэлийн арга барил, бүтээмж ба зохион байгуулалт, хадгалалт болон бараа материалын шаардлага, агуулахын хэрэгцээ, гол ба чухал түүхий эд, эдгээрийн олдоц ба үнийн хандлага, худалдан авалтад тогтсон практик, хангамжийн болон бараа материалын хяналт, бусдаар гүйцэтгүүлэх гэрээт ажил
4. Үйлдвэрлэлийн зардлын гол бүрэлдэхүүн хэсгүүд (материал түүхий эд, шууд болон шууд бус хөдөлмөр, үйлдвэрлэлийн зардал)
5. Үйлдвэрлэлийн зардал өсөхөд нөлөөлж болох хүчин зүйлс
6. Салбартай харьцуулахад компанийн үйлдвэрлэлийн бүтээмж
Бэлтгэн нийлүүлэлт
1. Шаардлагатай гол түүхий эд буюу бүтээгдэхүүн, ирээдүйн үнийн хандлага, зах зээлийн нөхцөл байдал, түүхий эдийн хангамж, өрсөлдөгчдийн үйл ажиллагаа болон бэлтгэн нийлүүлэгчийн салбарын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал
2. Гол түүхий эд, материалын эх үүсвэр (олон буюу монопольт нийлүүлэгч)
3. Худалдан авалтад тогтсон практик (удаан хугацаат гэрээ, наймаалцаж авах зэрэг)
Бараа материал ба өртөг
1. Бараа материалын төвшний хандлага, улирлын хэлбэлзэл
2. Бараа материалд нөлөөлөх хүчин зүйлс болон холбогдох эрсдэл (баталгаа, даатгал)
3. Бараа материалын бүртгэл хөтлөх журам
Хөдөлмөрийн асуудлууд
1. Үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт, техникийн болон захиргааны хэсгүүдэд хуваагдсан ажилчдын тоо
2. Хөдөлмөрийн гэрээ, боловсон хүчин шалгаруулах авах, боловсон хүчний бодлого, журам
3. Цалин, урамшууллын бодлого, журам
4. Хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, мэргэжилтэй ажиллах

хүчний олдоц, ажиллах хүчний эргэлт
5. Удирдах ажилтан нарын талаарх мэдээлэл:
А. Удирдлагын үүрэг хариуцлагын хуваарилалт, зохион байгуулалт
Б. Удирдлага ба гол ажилтан нар, тэдгээрийн албан тушаал, ажлын туршлага, нас, цалин хөлс, тэдгээрийг цаашид ажиллуулах болон менежментийн сургалтанд хамрагдсан байдал
В. Аливаа хөдөлмөрийн гэрээ буюу амаар тохиролцсон зүйл
Г. Гол ажилтнуудыг удаан хугацаагаар ажиллуулах бодлого
Д. Гол ажилтнуудын зан авир, харьцаа
6. Шагнал, урамшууллын хөтөлбөр (хувьцаа эзэмших буюу хувьцаагаар шагнах төлөвлөгөө)
Санхүүгийн тоо баримт
1. Дараах тоо баримтыг авсан эсэх:
А. Гол газар, хэлтсээр задлан гаргаж харьцуулсан санхүүгийн үр дүнгийн мэдээ
Б. Хамгийн сүүлийн үеийн санхүүгийн тайлан тэнцэл
В. Тооцоолж гаргасан үйл ажиллагааны ба санхүүгийн тайлан тэнцэл
2. Үйл ажиллагааны үр дүнг судлахдаа дараах зүйлд дүн шинжилгээ хийсэн эсэх:
А. Өсөлтийн хувь
Б. Борлуулалтын өртөг, ерөнхий ба борлуулалт, үйл ажиллагааны зардал
В. Судалгаанд хамрагдаж буй хугацаанд гарсан онцгой шинж чанартай буюу нэг удаагийн зардлууд. Үндсэн үйл ажиллагааны бус орлого, зардлыг гол зүйлээр задлах.
Г. Жилийн хүүгийн зардал болон бусад тогтмол төлбөр
Тайлан балансын дүн шинжилгээ
1. Судалгаанд хамрагдаж буй хугацааны бэлэн мөнгөний үлдэгдэл ба тооцоолж гаргасан ирээдүйн бэлэн мөнгөний хэмжээг судалсан эсэх:
А. Үлдэгдлийн тэнцлийн өдрийн байдлаар компанийн харилцаж буй банкны жагсаалтыг гаргах
Б. Бэлэн мөнгөний сарын үлдэгдлийг судалж, энгийн бус хэлбэлзлийг судлах
В. Банкнаас улирлын чанартай зээл авах шаардлагатай эсэхийг тодруулах
2. Авлагын хувьд дараах зүйлийг судалсан эсэх:
А. Харилцагч, ажилтан албан хаагч болон бусдаас авах авлагын дүн болон авлагын нийт дүнг судалсан эсэх
Б. Авлагын насжилт, ерөнхий түүх

В. Харилцагчдаас авах авлагын талаар дараах зүйлийг судалсан эсэх:
- Борлуулалтын нөхцөл
- Харилцагчдын тоо
- Томоохон харилцагчдын жагсаалт, жилийн борлуулалтын хэмжээг харилцагч ба бүтээгдэхүүний нэр төрлөөр гаргах. Эдгээр харилцагчийн аль нэгт онцгой нөхцөл олгосон эсэх.
Г. Компанийн ажилтан, албан хаагчдад олгосон зээлийн (жижиг хэмжээний зээлээс бусад) зорилго, эргэн төлөгдөх нөхцлийг судалсан эсэх.
Д. Өр, авлага барагдуулах ажлыг судалж, үнэлсэн эсэх
3. Байгаль орчинтой холбоотой дүрэм журмын хувьд дараах зүйлийг судалсан эсэх:
А. Байгаль орчинтой холбоотой аливаа асуудал, өр төлбөр байгаа эсэх
Б. Аливаа бусад өр төлбөр
Санхүүжилт, хөрөнгийн бүтэц
1. Нийт санхүүгийн өр төлбөр /богино ба урт хугацаат зээл, барьцааны нөхцөл, баталгаа)
2. Урьд өмнө авсан зээлээ хэрхэн барагдуулсан байдал, зээлийг төлөх чадваргүй болж байсан эсэх
3. Энгийн хувьцаа эзэмшигчдийн өмч, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, ногдол ашиг төлөх бодлого
4. Ашгаар буцааж компанид хөрөнгө оруулалт хийх бодлого, компанийн өсөлтийг компанийн дотоодын мөнгөн урсгалаар санхүүжүүлж байгаа эсэх
5. Санхүүгийн хэрэгцээ (капитал зардал, эргэлтийн хөрөнгө)
6. Компанийн хөрөнгийн төсөв, зарцуулалтын журам, хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөгөө
7. Өр төлбөр барагдуулах хуваарийг үйл ажиллагааны мөнгөн урсгалтай харьцуулах, мөнгөн урсгал хангалттай эсэх
Санхүүгийн таамаглал, тооцоо
1. Компани санхүүгийн таамаглал, тооцоог тогтмол хийдэг эсэх
2. Компани санхүүгийн таамаглалд үндэслэн ирээдүйн ашиг, мөнгөн урсгалын тооцоог муу, сайн, хамгийн магадлалтай хувилбараар гаргадаг эсэх
3. Компанийн санхүүгийн таамаглалыг гаргахад ашигладаг гол үндэслэл
4. Инфляци, салбар, бизнесийн орчны судалгаа, өсөлтийн чиг хандлага, салбарын нөхцөл байдал болон бусад хүчин зүйл
5. Мөнгөн урсгалын тооцоо
Санхүүгийн менежмент
1. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан

2. Компанийн үйл ажиллагаанд бие даасан аудитын пүүс хөндлөнгийн хяналт хийсэн эсэх
3. Компанийн хяналт, шалгалтын дотоод журам
4. Завсрын тайлан / санхүүгийн тайланг нэгтгэсэн байдлаар гаргадаг эсвэл аж ахуйн нэгж тус бүрээр гаргадаг эсэх
Мэдээллийн технологи
1. Нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагааг компьютержуулсан эсэх
2. Үйлдвэрийн нөөцийн менежмент (Enterprise Resource Management)-ийг боловсруулж, нэвтрүүлсэн эсэх
Даатгал
1. Зохих даатгал байгаа эсэх
2. Алдагдал, нэхэмжлэлийн талаарх мэдээлэл, туршлага
Татварын асуудал
1. Гол татварууд
2. Сүүлийн 3-5 жилийн компанийн татварын бодит хувь хэмжээ
3. Бизнесийн зарим зардлыг татвар ногдуулах ашгаас хасахтай холбоотой асуудал, хүндрэл (тухайлбал хөрөнгө оруулалтын зардал)
4. Компанийн татвартай холбоотой аливаа хүндрэлтэй асуудлууд (тухайлбал эд хөрөнгийн татвар, онцгой татвар, НӨАТ)
5. Элэгдэл тооцох хөрөнгө, охин компани, хуримтлагдсан ашгийн татвар тооцох суурь, татварын өглөг зэргийг татварын зорилгоор бүртгэх
Гааль
1. Гаалийн бодлого, журам компанийн үйл ажиллагаанд нөлөөлдөг эсэх
2. Гаалийн байгууллагуудтай холбоотой хүндрэл, асуудал, компанийн үйл ажиллагаа, үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эсэх
Төлөвлөлт
1. Компани жилийн ба урт хугацааны төлөвлөгөө гаргадаг эсэх
2. Богино ба урт хугацааны төлөвлөлтийг хэн хариуцдаг вэ
3. Төлөвлөгөөг баримтжуулж, хэрэгжүүлэх хүмүүст танилцуулдаг эсэх
4. Урт хугацааны төлөвлөгөөнд өрсөлдөөнийг тусгадаг эсэх
5. Төлөвлөгөөнд стратегийн өөр бусад хувилбарыг тусгадаг эсэх
6. Компани төлөвлөгөөний зорилтуудыг хэрхэн биелүүлж ирсэн
7. Гүйцэтгэлийг төсөвтэй харьцуулж, зөрүүг баримтжуулах албан ёсны журам байдаг эсэх
8. Төсвийг байнга шинэчилдэг эсэх
9. Зах зээлийг хянахдаа дараах зүйлийг анхаардаг эсэх:

А. Зах зээлд эзлэх хувь?
Б. Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа?
В. Харилцагч үйлчлүүлэгчдийн хандлага?
Дотоод хяналт
1. Дотоод хяналтын бодлого, журам
2. Өртгийг бууруулах, ашгийг нэмэгдүүлэх хөтөлбөр
Эрдэм шинжилгээ, судалгаа, инженер-техникийн шийдэл
1. Компанийн эрдэм шинжилгээ, судалгааны бодлого, борлуулалтын ямар хувийг эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулдаг, бүтээл зохион байгуулалтын шатанд байгаа шинэ бүтээгдэхүүн, өрсөлдөгч компаниудын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа
2. Шинээр бий болгож бүтээгдэхүүний өмчлөлийн эрхийг зохих ёсоор баталгаажуулсан эсэх
3. Эзэмшиж буй зохиогчийн эрх, патент, худалдааны тэмдэг, эдгээрийг авахаар өргөдөл гаргасан эсэх
Хууль эрх зүйн асуудлууд
1. Компанийн үйл ажиллагаагаа явуулж буй эрх зүйн ба зохицуулалтын орчин (салбарыг зохицуулдаг эсэх, лицензи, зөвшөөрөл, сертификат авах шаардлага)
2. Компанийн эсрэг аливаа нэхэмжлэл гаргасан эсэх, шүүхийн ажиллагаа явагдаж байгаа эсэх
3. Компани хуульч ажиллуулдаг эсэх
4. Байгаль орчин, аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал зэрэг зохицуулалтын шаардлагыг хангадаг эсэх
5. Хувьцаа эзэмшигч, бүртгэл, өмчлөлтэй холбоотой шийдвэрлэгдээгүй байгаа аливаа эрх зүйн асуудлууд

ХАВСРАЛТ Г: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАГВАР

ХАВСРАЛТ Г: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Дор дурьдсан хүснэгтүүдэд санхүүгийн тайлангийн хялбарчилсан загварыг харуулав. Энэ нь зөвхөн загвар бөгөөд тоо баримт нь зохиомол болно.

	B	C	D	E	F	G
1	ХЯНАЛТЫН САМБАР					
2						
3						
4	Компани					
5	КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бичнэ үү)					
6	Салбар (дээрээс нь бичнэ үү)					
7						
8	Үндэслэл					
9						
10	Орлого, үр дүнгийн тайлан:					
11						
12	Борлуулалтын өсөлт	20%	2005 оноос хойш			
13	Борлуулалтын өртгийн өсөлт	17%				
14	Борл., ерөнхий ба захиргааны зардал	17%				
15	Үйл ажиллагааны бусад зардлын өсөлт	17%				
16						
17	Хүүгийн зардал (Жилийн хүү% x өрийн хэмжээ)		(Жилээр тооцсон-төсөөлөхөд тун хэцүү)			
18	Үйл ажиллагааны бус орлогын өсөлтийн хувь					
19	Үйл ажиллагааны бус зардлын өсөлтийн хувь					
20						
21	Орлогын татвар		Мөрдөж буй хувь хэмжээ			
22						
23	Хуримтлагдсан ашиг					
24						
25						
26	Тайлан тэнцэл					
27						
28	Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө					
29	Авлага, цэвэр					
30	Бараа материал					
31	Эргэлтийн бусад хөрөнгө					
32						
33	Эд хөрөнгө, барилга, тоног төхөөрөмж					
34	Эргэлтийн бус бусад хөрөнгө					
35						
36	Худалдааны ба бусад өр төлбөр					
37	Эргэлтийн ба хуримтлагдсан бусад өр төлбөр					
38	Богино хугацаат өр					
39	Өр төлбөр, төлбөрийн нөөцийн сан					
40						
41	Урт хугацаат өр					
42						
43	Ноогдол ашгийн төлбөр	0%				

Хувилбарууд: Хувилбаруудыг энд тайлбарла

Хамгийн муу

Суурь

Хамгийн сайн

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L
1	Санхүүгийн зарим мэдээлэл										
2		КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)									
3		<i>Төсөвлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан</i>									
4											
5		оны 12-р сарын 31-ний байдлаар									
6		Бүх дүн мянган ам. доллараар									
7	ОРЛОГЫН ТАЙЛАН:	2002	2003	2004	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П	
8											
9	Орлого	10,000	20,000	40,000	10,000	12,000	14,400	17,280	20,736	24,883	
10	Борлуулалтын өртөг	5,000	10,000	20,000	5,000	5,850	6,845	8,008	9,369	10,962	
11	Нийт ашиг	5,000	10,000	20,000	5,000	6,150	7,556	9,272	11,367	13,921	
12											
13	Борл., ерөнхий ба захиргааны зардал	1,000	1,100	1,200	1,400	1,638	1,916	2,242	2,623	3,069	
14	Үйл ажиллагааны бусад зардал	30	40	60	70	82	82	82	82	82	
15	ХТЭХӨА	3,970	8,860	18,740	3,530	4,430	5,557	6,948	8,661	10,770	
16											
17	Элэгдэл ба хорогдол	500	500	500	500	500	500	500	500	500	
18	ХТӨА	3,470	8,360	18,240	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270	
19											
20	Хүүгийн зардал	700	700	700	700	700	700	700	700	700	
21	Үйл ажиллагааны бус орлого (зардал)	50	50	50	50	50	50	50	50	50	
22	ТӨА	2,720	7,610	17,490	2,280	3,180	4,307	5,698	7,411	9,520	
23											
24	Орлогын татвар	200	200	200	1,280	200	200	200	200	300	
25	Цэвэр ашиг/(алдагдал)	2,520	7,410	17,290	1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	

A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L
1		оны 12-р сарын 31-ний байдлаар									
2		Бүх дүн мянган ам. доллараар									
3	ТАЙЛАН ТЭНЦЭЛ	2002	2003	2004	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П	
4	ХӨРӨНГӨ										
5	Эргэлтийн хөрөнгө										
6	Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө										
7	Авлага, цэвэр										
8	Бараа материал										
9	Эргэлтийн бусад хөрөнгө										
10	Нийт эргэлтийн хөрөнгө										
11											
12	Үндсэн хөрөнгө										
13	Эд хөрөнгө, барилга, тоног төхөөрөмж					300,000	300,000	300,000	300,000	300,000	
14	Эргэлтийн бус бусад хөрөнгө										
15	Нийт үндсэн хөрөнгө					300,000	300,000	300,000	300,000	300,000	
16											
17	НИЙТ ХӨРӨНГӨ					300,000	300,000	300,000	300,000	300,000	
18											
19	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ										
20											
21	Богино хугацаат өр төлбөр										
22	Худалдааны ба бусад өр төлбөр										
23	Эргэлтийн ба бусад хуримтлагдсан өр төлбөр										
24	Богино хугацаат зээл										
25	Өр төлбөр, төлбөрийн нөөцийн сан										
26	Нийт богино хугацаат өр төлбөр										

Хавсралт Г Хуудас 46

Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох судалгаа - 2-р үе шат – Сангаас хөрөнгө оруулалт авах боломжтой компаниудын иж бүрэн судалгаа

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

27												
28	Урт хугацаат өр төлбөр											
29	Урт хугацаат өр											
30	Нийт урт хугацаат өр төлбөр											
31												
32	Нийт өр төлбөр											
33												
34	Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц											
35	Энгийн хувьцаа											
36	Нөөц ба сангууд											
37	Хуримтлагдсан ашиг					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
38	Нийт эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
39												
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШ. ХӨРӨНГӨ					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
41												
42	Тайлбар:											
43	1 Түүхэн тоо баримтын жилийн өсөлтийн нийлмэл хувь (ЖӨНХ)											
44	Т - төсөвлөсөн											
45	П - прогноз											

A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L	M
1	КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)											
2	<i>Урьдчилан тооцоолсон а санхүүгийн аудитлагдаагүй тайлан</i>											
3												
4												
5												
6	ОРЛОГЫН ТАЙЛАН:	2002	2003	2004	ЖӨНХ¹	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П	
7												
8	Орлого	10,000	20,000	40,000	100%	10,000	12,000	14,400	17,280	20,736	24,883	
9	Борлуулалтын зардал	5,000	10,000	20,000	100%	5,000	5,850	6,845	8,008	9,369	10,962	
10	Нийт ашиг	5,000	10,000	20,000	100%	5,000	6,150	7,556	9,272	11,367	13,921	
11												
12	Борл., срөнхий ба захирг зардал	1,000	1,100	1,200	10%	1,400	1,638	1,916	2,242	2,623	3,069	
13	Үйл ажиллагааны бусад зардал	30	40	60	41%	70	82	82	82	82	82	
14	ХТЭХӨА	3,970	8,860	18,740	117%	3,530	4,430	5,557	6,948	8,661	10,770	
15												
16	Элэгдэл ба хорогдол	500	500	500	0%	500	500	500	500	500	500	
17	ХТӨА	3,470	8,360	18,240	129%	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270	
18												
19	Хүүгийн зардал	700	700	700	0%	700	700	700	700	700	700	
20	Үйл ажиллаг.бус орлого (зардал)	50	50	50	0%	50	50	50	50	50	50	
21	ТӨА	2,720	7,610	17,490	154%	2,280	3,180	4,307	5,698	7,411	9,520	
22												
23	Орлогын татвар	200	200	200	0%	1,280	200	200	200	200	300	
24	Цэвэр ашиг/(алдагдал)	2,520	7,410	17,290	162%	1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
25	Тайлбар											

¹Түүхэн тоо баримтын ЖӨНХ

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L	M
1		КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)										
2		Төсөвлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан										
3		оны 12-р сарын 31-ний байдлаар										
4		Бүх дүн мянган ам. доллараар										
5		2002	2003	2004	ЖӨНХ ¹	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П	
6	ТАЙЛАН ТЭНЦЭЛ											
7	ХӨРӨНГӨ											
8	Эргэлтийн хөрөнгө											
9	Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө											
10	Авлага, цэвэр											
11	Бараа материал											
12	Эргэлтийн бусад хөрөнгө											
13	Нийт эргэлтийн хөрөнгө											
14												
15	Эргэлтийн бус хөрөнгө											
16	Эд хөрөнгө, барилга, тоног төхөөрөмж					300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	
17	Эргэлтийн бус бусад хөр.											
18	Нийт эргэлтийн бус хөр.					300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	
19												
20	НИЙТ ХӨРӨНГӨ					300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	
21												
22	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ											
23												
24	Богино хугацаат өр төлбөр											
25	Худалдаа, бусад өр төлбөр											
26	Эргэлтийн ба бусад хуримтлагдсан өр төлбөр											
27	Богино хугацаат зээл											
28	Өр төлбөр, төлбөрийн нөөц. сан											
29	Нийт богино хугацаат өр төл.											
30												
31	Урт хугацаат өр төлбөр											
32	Урт хугацаат өр											
33	Нийт урт хугацаат өр төлбөр											
34												
35	Нийт өр төлбөр											
36												
37	Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц											
38	Энгийн хувьцаа											
39	Нөөц ба сангууд											
40	Хуримтлагдсан ашиг					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
41	Нийт эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
42												
43	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШ. ХӨРӨНГӨ					1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220	
44	Тайлбар											
	¹ Түүхэн тоо баримтын ЖӨНХ											

A	B	C	D	E	F	G	H
1							
2		КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)					
3		Төсөөлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан					
4							
5							
6							
7	Мөнгөн урсгалын тайлан						
8							
9	Цэвэр ашиг	1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220
10	Нэмэх нь: Орлогын тайлангийн мөнгөн бус төлбөр						
11							
12	Элэгдэл	500	500	500	500	500	500
13	Хойшлуулсан татвар	0	0	0	0	0	0
14							
15	Нийт мөнгөн урсгал	1,500	3,480	4,607	5,998	7,711	9,720
16							
17	Эргэлтийн хөрөнгийн (ашигласан) бэлэн мөнгө						
18							
19	Авлага	0	0	0	0	0	0
20	Бараа материал	0	0	0	0	0	0
21	Эргэлтийн бусад хөрөнгө	0	0	0	0	0	0
22	Өр төлбөр	0	0	0	0	0	0
23	Төлбөл зохих хуримтлагдсан татвар ба бусад өр төлбөр	0	0	0	0	0	0
24							
25	Эргэлтийн хөрөнгийн (ашигласан) нийт бэлэн мөнгө	0	0	0	0	0	0
26							
27	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны бэлэн мөнгө						
28							
29	Капитал зардал	-300,000	0	0	0	0	0
30	Эргэлтийн бус бусад хөрөнгийн өөрчлөлт	0	0	0	0	0	0
31							
32	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны нийт бэлэн мөнгө	-300,000	0	0	0	0	0
33							
34	Санхүүгийн үйл ажиллагааны бэлэн мөнгө						
35							
36	Богино хугацаат өр	0	0	0	0	0	0
37	Өр төлбөр, хураамжийн нөөцийн сан	0	0	0	0	0	0
38	Урт хугацаат өр	0	0	0	0	0	0
39							
40	Санхүүгийн үйл ажиллагааны нийт бэлэн мөнгө						
41							
42	Олгосон/ашигласан цэвэр мөнгөн урсгал	-298,500	3,480	4,607	5,998	7,711	9,720
43							
44	Эхэн үеийн бэлэн мөнгө	0	0	0	0	0	0
45							
46	Эцсийн үеийн бэлэн мөнгө	-298,500	3,480	4,607	5,998	7,711	9,720

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

A	B	C	D	E	F	G	H
1	Зээлгүй компанийн чөлөөт мөнгөн урсгалыг ХТӨА аргачлалыг ашиглан тооцоолох нь	КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)					
2		Төсөвлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан					
3							
4		_____ оны 12-р сарын 31-ний байдлаар					
5		Бүх дүн мянган ам. доллараар					
6		2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П
7							
8	ХТӨА	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270
9	Нэмэх нь: Элэгдэл	500	500	500	500	500	500
10	Бэлнээр төлсөн татварын төлбөрийг хасах	1,280	200	200	200	200	300
11	Капиталын цэвэр зардлыг хасах	-300,000	0	0	0	0	0
12	Шаардлагатай цэвэр эргэлтийн хөрөнгийн өсөлтийг хасах (бууралтыг нэмэх)	0	0	0	0	0	0
13	Зээлгүй компанийн чөлөөт мөнгөн урсгал	-295,190	4,630	5,757	7,148	8,861	11,070
	ӨХХ						

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L
1	Хувилбар-суурь										
2	Харьцаанууд:	2002	2003	2004ЖӨНХ1	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П	
3	Ашгийн										
4	Нийт ашгийн	50%	50%	50%	100%	50%	51%	52%	54%	55%	56%
5											
6	Үйл ажиллагааны ашгийн	35%	42%	46%		30%	33%	35%	37%	39%	41%
7											
8	Цэвэр ашгийн	25%	37%	43%		10%	25%	29%	32%	35%	37%
9											
10											
11											
12	Дюпоны дүн шинжилгээ										
13	Үйл ажиллагааны ашгийн	35%	42%	46%		30%	33%	35%	37%	39%	41%
14	Хөрөнгийн эргэлтийн	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0.03	0.04	0.048	0.0576	0.0691	0.0829
15	Зээлжилт	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		300	100.67	73.044	54.568	41.602	32.539
16	Хуугийн ачаалал	0.78	0.91	0.96		0.75	0.81	0.85	0.88	0.91	0.93
17	Татварын ачаалал	0.93	0.97	0.99		0.44	0.94	0.95	0.96	0.97	0.97
18											
19	ХӨ	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0.01	0.01	0.0169	0.0215	0.0272	0.0342
20	ӨХӨ	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		1	1	1	1	1	1
21											
22											
23											
24											
25											
26											
27											
28											
29											
30											
31											
32											
33											
34											
35											
36	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар										
37	Эргэлтийн харьцаа (эргэлт.хөрөнгө/богино хуг.өр төлбөрийн харьцаа)	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!
38											
39	Зээлжилт										
40	Хүүгийн төлбөр хийх чадвар	5	11.9	26.1		4.3	5.6	7.2	9.2	11.7	14.7
41	Өр/нийт хөрөнгө	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0	0	0	0	0	0
42	Өр/өөрийн хөрөнгө	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0	0	0	0	0	0

Татварын ачаалал
Хүүгийн ачаалал
Борлуулалтын ашиг
Нийт хөрөнгийн эргэлт
Зээлжилт

Цэвэр ашиг ашиг
Татварын өмнөх
ХТӨА
Борлуулалт
Хөрөнгө

$$\text{ӨХӨ} = \frac{\text{Цэвэр ашиг ашиг}}{\text{Татварын өмнөх ашиг}} \times \frac{\text{Татварын өмнөх}}{\text{ХТӨА}} \times \frac{\text{ХТӨА}}{\text{Борлуулалт}} \times \frac{\text{Борлуулалт}}{\text{Хөрөнгө}} \times \frac{\text{Хөрөнгө}}{\text{Өөрийн хөрөнгө}}$$

ХӨ

ХАВСРАЛТ Д: КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГЫГ ГАРГАХ ЗАГВАР



*Эдийн засгийн бодлогын шинэтгэл,
өрсөлдөх чадвар төсөл*



Нээлттэй Нийгэм Форум

КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГЫН

НУУЦ

МЕМОРАНДУМ

ЗАГВАР

Компани No. xx

(ЗӨВХӨН ТАЙЛБАРЛАХ ЗОРИЛГООР ЗОХИОМОЛ КОМПАНИЙГ АШИГЛАВ)

**Эдийн засгийн бодлогын шинэтгэл,
өрсөлдөх чадвар төсөл
Кемоникс**

Улаанбаатар хот, Монгол улс
2005 оны 4 сарын 28



АНУ-ын ОУХА-ийн гэрээ No. 438-C-00-03-00021-00



CHEMONICS

ГАРЧИГ

<u>I. НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ</u>	57
<u>II. ЧУХАЛ МЭДЭГДЭЛ</u>	60
<u>III. КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</u>	62
<u>IV. ХУРААНГУЙ</u>	64
<u>A. Ерөнхий байдал</u>	64
<u>B. Тусгайлан авч үзэх асуудлууд</u>	64
<u>Өсөлтийн тоо баримт</u>	64
<u>Эрэлт хэрэгцээ</u>	65
<u>Бизнесийн хамгийн гол боломж</u>	65
<u>Ашиг олох боломж</u>	65
<u>Олон төрлийн бүтээгдэхүүн санал болгох нь</u>	65
<u>Зах зээлийн санхүүжилтийн таатай нөхцөл</u>	65
<u>Зах зээл дэх нэр хүнд</u>	65
<u>Тогтмол үйлчлүүлэгчид</u>	65
<u>Менежментийн баг</u>	66
<u>Зах зээлд нэвтрэхтэй холбоотой хүндрэлүүд</u>	66
<u>Эрсдэлийн хүчин зүйлс</u>	66
<u>B. Хэлэлцээр хийх шалтгаан ба түүний хүлээгдэж буй хэлбэр</u>	66
<u>V. САНХҮҮГИЙН ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ</u>	67
<u>VI. ДҮН ШИНЖИЛГЭЭ</u>	69
<u>A. ЧӨЛӨӨТ МӨНГӨН УРСГАЛ БА ӨХХ</u>	69
<u>B. САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ</u>	70
<u>VII. ТӨСӨӨЛӨЛ</u>	70
<u>VIII. ДҮГНЭЛТ</u>	71

I. НУУЦЫГ ХАДГАЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Нууцыг хадгалах тухай энэхүү гэрээг /цаашид "Гэрээ" гэх/ нэг талаас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-аас санхүүжиж буй Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл (ЭЗБШӨЧТ)-ийг төлөөлж буй Кемоникс Интернэйшнл корпораци /цаашид "Өмчлөгч" гэх/, нөгөө талаас _____ /цаашид "Хүлээн авагч" гэх/ -ийн хооронд ... оны ...-р сарын ...-ний өдөр байгуулсан болно.

Өмчлөгчийн хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар хийсэн судалгааны асуудлаар Өмчлөгч болон Хүлээн авагчийн хооронд хийсэн уулзалт, ярилцлага, мөн эдгээрийн хооронд бичгээр солилцсон мэдээлэл нь Өмчлөгчийн судалгаатай холбоотой зарим нууцлалтай мэдээлэл, хөрөнгө оруулалтын боломжийн талаар бичсэн Компанийн тухай товч танилцуулга болон Өмчлөгчийн хувийн хөрөнгө оруулалтын сангийн асуудлаар хөрөнгө оруулалт хийх боломжит компанитай хийсэн ярилцлагаас олж авсан аливаа мэдээллийг Хүлээн авагчид илчлэх **НӨХЦӨЛИЙГ ХАРГАЛЗАН;**

Өмчлөгч нь зарим мэдээллийг өмчлөх онцгой эрхээ хадгалж, тус мэдээллийг албан ёсны зөвшөөрөлгүйгээр түгээх явдлаас зайлсхийхийг эрмэлзэж буйг **ХАРГАЛЗАН ҮЗЭЖ;**

Энэхүү гэрээний хүрээнд дор тодорхойлсон "нууцлалтай мэдээллийг" албан ёсны зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд задруулахаас сэргийлэхээ хоёр тал илэрхийлж буйг **ХАРГАЛЗАН**

Энэ асуудлыг хууль ёсны болгох үүднээс хоёр тал дараах зүйлийг тохиролцов:

1. Нууцлалтай мэдээллийн тодорхойлолт

Өмчлөгч нь өөрийн өмчлөлийн, нууцлалтай мэдээллийн тодорхой хэсгийг (цаашид "Нууцлалтай мэдээлэл" гэх) Хүлээн авагчид өгөхийг санал болгож байна. Нууцлалтай мэдээлэл гэдэг нь бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, материал, технологи, компьютерийн программ, техникийн үзүүлэлт, гарын авлага, бизнес төлөвлөгөө, программ хангамж, маркетингийн төлөвлөгөө, санхүүгийн мэдээлэл, арилжааны үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг хэлэх бөгөөд үүний дотор электроник буюу хэвлэмэл хэлбэрийн судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэл, худалдан авалт, нягтлан бодох бүртгэл, техник-инженерийн шийдэл, маркетинг, сурталчилгаа, үнийн бодлого, борлуулалт, түүнчлэн одоогийн болоод хэтийн үйлчлүүлэгчид, гол ажилтнууд, болох гэж буй тендер болон саналуудын талаарх мэдээлэл, одоогийн үйлдвэрлэж буй болон үйлдвэрлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүний төрөл, хөтөлбөр, тэмдэглэлүүд, баримт материал, мэдээлэл зэрэг багтана. Нууцлалтай бүх мэдээллийг "Нууцлалтай" гэж тодорхой тэмдэглэнэ. Амаар мэдэгдсэн нууцлалтай мэдээлэл нь нэн даруй нууцлалтай мэдээлэлд тооцогдоно. Эдгээр заалт нь Өмчлөгчид өөрийн нууц мэдээллийг задлах үүрэг хүлээлгээгүй болно.

Хүлээн авагч нь уг гэрээг зөрчилгүйгээр, эсвэл нууцлалыг хадгалах үүрэг хүлээлгүүгээр зохих ёсоор авсан мэдээлэл, эсвэл энэхүү гэрээг зөрчихгүйгээр боловсруулсан нууцлалтай мэдээллийг олны хүртээл болгосонтой холбогдолтой аливаа үүрэг хариуцлагыг энэхүү гэрээ ёсоор хүлээхгүй болно.

2. Нууцлалтай мэдээллийг ашиглах нь

Хүлээн авагч нь Өмчлөгчөөс олгосон нууцлалтай мэдээллийг Өмчлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу сонирхсон гуравдагч талтай хамтран бизнесийн хөгжил, үйл ажиллагааны туслалцаа дэмжлэг үзүүлэх бололцоог үнэлэн тооцоолох онцгой бөгөөд цорын ганц зорилгоор ашиглана. Хүлээн авагч нь эдгээр мэдээллийг Өмчлөгчийн бизнес үйл ажиллагаанд шууд буюу шууд бус байдлаар харшлан өрсөлдөхөд ашиглуулахгүй бөгөөд ашиглах боломжийг гаргахгүй. Хүлээн авагч нь эдгээр нууцлалтай мэдээллийг өөрийн мэдээлэлтэй адилтган үзэж, тэдгээрийг хулгайлах, Өмчлөгчийн итгэмжилсэн талуудтай хамтран ажиллах үйл ажиллагаанд шууд оролцоогүй ажилтнуудад ашиглуулах, хуулуулахаас хамгаалах үүргийг хүлээнэ.

3. Онцгой эрх

Өмчлөгчөөс Хүлээн авагчид олгосон бүх нууцлалтай мэдээлэл нь Өмчлөгчийн онцгой өмчлөлд байх цорын ганц мэдээлэл бөгөөд Хүлээн авагч уг мэдээллийг Өмчлөгчийн хүсэлтийн дагуу буцаан олгох буюу устгах үүргийг хүлээнэ. Энэхүү гэрээний заалтууд аливаа нууцлалтай мэдээллийг лицензээр буюу өөр ямарваа хэлбэрээр шилжүүлж буюу олгож буй утгыг агуулаагүй болно.

4. Мэдээллийг хууль ёсны дагуу олгох нь

Засгийн газрын агентлагаас хууль зүйн эрхийн дагуу хүсэлт тавьсан тохиолдолд Хүлээн авагч нь Өмчлөгчөөс олгосон нууцлалтай мэдээллийг задруулах шаардлага гарч болно. Хүлээн авагч нь тийнхүү мэдээлэл олгох хүсэлт авсан тухайгаа Өмчлөгчид бичгээр мэдэгдэх үүргийг хүлээнэ.

5. Гэрээний хүчинтэй байх хугацаа

Талууд уг гэрээний хугацаа дуусахаас өмнө бичгээр мэдэгдэн дуусгавар болгохоос бусад тохиолдолд энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

6. Эцсийн зөвшилцөл

Энэхүү гэрээ нь үүнд дурдагдсан асуудлаар Өмчлөгч болон Хүлээн авагчийн хооронд урьд өмнө байгуулсан ямарваа гэрээ, ойлголцлыг дуусгавар болгох ба тэдгээрийг цуцалсанд тооцно. Хоёр тал бичгээр зөвшилцсөний дагуу энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

7. Бусад этгээдэд шилжүүлэхгүй байх

Хүлээн авагч нь Өмчлөгчөөс бичгээр урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд энэхүү гэрээ болон түүнд тусгагдсан аливаа ашиг сонирхлыг бусад этгээдэд шилжүүлэх эрх эдлэхгүй.

8. Тусгайлан үзэх нь

Энэхүү гэрээний ямарваа заалт тодорхойлолтыг шүүх буюу хууль зүйн эрх бүхий байгууллага хүчингүй, эсвэл хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд энэхүү гэрээ болон бусад заалтууд нь үүнийг үл харгалзан хүчин төгөлдөр хэвээр байна.

9. Зохицуулах хууль

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль журамд захирагдан, тэдгээрийн дагуу тайлбарлагдана.

Талууд энэхүү гэрээг дээр дурдсан он, сар, өдөр байгуулсныг **ҮҮГЭЭР ГЭРЧИЛНЭ**.

“ХҮЛЭЭН АВАГЧ”:

Нэр:

Хаяг:

Утас:

Факс:

ХҮЛЭЭН АВАГЧ-ийн итгэмжлэгдсэн
төлөөлөгчийн гарын үсэг:

“Өмчлөгч”-ийн нэр:

Хаяг:

Кемоникс Интернэйшнл корпораци
Таван богд плаза, 2-р давхар
Ерөнхий сайд Амарын гудамж-2
Улаанбаатар, Монгол Улс

Утас:

239-3439

Факс:

239-4188

ӨМЧЛӨГЧИЙН итгэмжлэгдсэн
төлөөлөгчийн гарын үсэг:

II. ЧУХАЛ МЭДЭГДЭЛ

Энэхүү Компанийн тухай нууц товч танилцуулгыг түүнд хавсаргасан аливаа хавсралт буюу түүнийг дагалдах аливаа электрон мэдээлэл (эдгээрийг хамтад нь "Меморандум" гэнэ)-ийн хамт ХХ компани ("ХХ компани" буюу "Компани" гэх) болон Компанийн удирдлага ("Удирдлага")-ын гаргаж өгсөн ба бэлдсэн мэдээллийн үндсэн дээр Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл ("ЭЗБШӨЧТ") бэлдсэн болно.

Энд агуулсан мэдээллийг зөвхөн ЭЗБШӨЧТ-д Компанийн эдийн засгийн ач холбогдол болон түүний хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх боломжийг ирээдүйд хэмжих зорилгоор Компани дээр илүү нарийвчилсан, цогц дүн шинжилгээний судалгаа хийх шаардлага байгаа эсэх талаар шийдэхэд нь туслах зорилгоор бэлдсэн болно. Энэхүү Меморандум нь ЭЗБШӨЧТ буюу аливаа нарийн няхуур ханддаг хөрөнгө оруулагч жирийн нөхцөлд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах явцад шаарддаг бүх мэдээллийг агуулахыг зориогүй болно. Харин энэхүү Компанийн тухай товч танилцуулга нь Компанийн санхүүгийн байдал болон Компанийн удирдлагын бизнесийн боломжийг судлах талаар амаар буюу бичгээр илэрхийлсэн зүйлүүдийн талаар хязгаарлагдмал мэдээлэл олгож байгаа юм.

ЭЗБШӨЧТ нь энд агуулсан аливаа мэдээллийг бие даан шалгаагүй буюу аудит хийгээгүй болно.

ЭЗБШӨЧТ буюу тухайн цагт түүний түнш, захирал, төлөөлөгч, албан тушаалтан, ажилтан, зөвлөх буюу зуучлагчаар ажиллаж байсан буюу ажиллаж байгаа аливаа хүмүүс ("Холбогдсон түншүүд")-ийн аль нь ч Меморандумын үнэн зөв буюу бүрэн байдлын талаар аливаа тайлбар буюу батламж гаргахгүй бөгөөд Меморандумд багтсан буюу түүнд орхигдсон аливаа тайлбар буюу мэдэгдэл (шууд илэрхийлсэн буюу үүдэн гарах утга санаа), эсвэл Компанийн үнэлгээ хийж байх үед ЭЗБШӨЧТ-д амаар буюу бичгээр дамжуулсан аливаа мэдээллийн талаар хариуцлага буюу үүргийг хүлээхгүй болно.

Энэхүү Меморандумд Компанийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй холбоотой Компаниас гаргаж өгсөн тодорхой мэдэгдэл, тооцоо болон прогнозыг оруулсан болно. Эдгээр мэдэгдэл, тооцоо болон прогноз нь хүлээгдэж буй үр дүнгийн талаарх олон янзын төсөөллийг илэрхийлж байгаа ба эдгээр төсөөлөл нь зөв буюу буруу байж болох бөгөөд субъектив дүгнэлт агуулсан буюу агуулаагүй байж болно. Эдгээр мэдэгдлийн үнэн зөв байдал буюу эдгээр мэдэгдэл, тооцоо буюу прогнозод хэрхэн хүрэх талаар ямар нэгэн тайлбар гаргаагүй болно.

Хүлээн авагч нь, энэхүү Меморандумыг хүлээж авснаар дараахь зүйлийг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэж байна. Үүнд: (а) энд агуулагдсан бүх мэдээлэл нь Компанид хамаатай гэх мэдээллийн талаар Хүлээн авагч болон ЭЗБШӨЧТ-ийн хооронд байгуулсан Нууцыг хадгалах тухай гэрээнд хамрагдана; (б) энэхүү Меморандумын агуулга болон Хүлээн авагчид олгосон Компанитай холбоотой аливаа бусад мэдээлэл нь зөвхөн Компани болон ЭЗБШӨЧТ (болон түүний аливаа залгамжлагч)-ийн өмч байх бөгөөд уг мэдээллийг Компани болон ЭЗБШӨЧТ-ийн урьдчилсан байдлаар бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр бусдад хувилахгүй, хуулбарлаж өгөхгүй буюу тараахгүй (электрон буюу бусад хэлбэрээр); ба (в) Компани ба ЭЗБШӨЧТ нь Хүлээн авагчийн Компани болон ЭЗБШӨЧТ-өөс авсан Меморандум болон Компанид хамаатай гэх аливаа бусад мэдээллийг Компанийн

өмнөөс эргүүлж өгөх буюу устгах/арилгах (электрон хэлбэрээр дамжуулсан мэдээллийн хувьд)-ыг хэзээ ч шаардаж болно.

Энэхүү Компанийн талаарх аливаа лавлагаа болон Компанийн тухай аливаа мэдээлэл авах тухай хүсэлтийг ЭЗБШӨЧТ-ийн дараахь хаягаар холбоо барьж тавина уу:

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

Таван Богд Плаза, 2-р давхар

Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976 (11) 32 13 75 Факс: +976 (11) 32 78 25

“Дүн шинжилгээний баг”

Брюс Норлунд – Зөвлөх

bnorlund@eprc-chemonics.biz

Дашнямын Ашидмаа

ashidmaa@eprc-chemonics.biz

Балжиннямын Содномпил

sodnompil@eprc-chemonics.biz

Дашцэрэнгийн Цэцэн

Tsetsen@eprc-chemonics.biz

III. КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИ:	Компани No. XX	САЛБАР: XX
	Гудамж Улаанбаатар, Монгол улс	ЛАВЛАГААНЫ ЭХ ҮҮСВЭР: МЭРГЭЖИЛТЭН:
БИЗНЕС:	<p>XX компани Монголын хэвлэлийн болон баглаа боодлын томоохон компаниудын нэг. Компани олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд хэд хэдэн төрлийн үйлчилгээ, үүний дотор график дизайн, хэвлэлтийн өмнөх бэлтгэл, хэвлэх ба баглах (картон, цаас, шошго) үйлчилгээ, сонин хэвлэл (ном, сэтгүүл, таницуулга, брошюр ба сонин) болон туслах үйл ажиллагаа (үдэх, зүсэх, г.м.) зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Компани чанар сайтай бүтээгдэхүүн нийлүүлж чанар сайтай үйлчилгээг цаг хугацаанд нь үзүүлдгээрээ нэрд гарсан.</p> <p>Компани гол бизнесийнхээ хүчин чадлыг өргөтгөх, мөн түүнчлэн хэвлэлийн болон уян хатан баглаа боодлын зах зээлд нэвтрэх зорилгоор хөрөнгө хайж байгаа болно. Одоогоор Компани бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгаа бөгөөд өөрийнхөө XX бүтээгдэхүүн болон үйлчилгээний одоогийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээгээ хангах зорилгоор энэ хүчин чадлаа өргөтгөх хүсэлтэй байгаа болно. Үүнээс гадна Компани уян хатан хэвлэл, баглаа боодлын ихээхэн том зах зээлд нэвтрэн орохоор төлөвлөж байгаа ба энэ нь ойролцоогоор • ам. долларын зах зээл бөгөөд түүний нийт хэрэгцээний 90 хувийг гадаадаас нийлүүлж байна. Компанийн тооцоолж байгаагаар тэрбээр эхний хоёр жилд зах зээлийн 10 хувийг эзэлж чадах бөгөөд дараагийн • жилд нэмэлт 5 хувийг эзэлж чадна гэж үзэж байна.</p>	
ТОНОГ	Компани Улаанбаатар хотын Аж үйлдвэрийн дүүргийн дээр дурьдсан хаягт байрладаг бөгөөд түүний худалдаа, захиргааны үндсэн байр 2,200 м ² талбай эзэлдэг.	
ТӨХӨӨРӨМЖ, БАРИЛГА		
БАЙГУУЛАМЖ:	Үүнээс гадна Компани 1997 оноос хойш Хятад, Орос ба Тайландад зургаан борлуулалтын болон маркетингийн төв ажиллуулж байна:	

Нэр	Эзэмшиж буй хувьцаа	Нийт хувьцаанд эзлэх хувь
XX	XX	XX%
XX	XX	XX%
XX	XX	XX%
XX	XX	XX%
XX	XX	XX%
Нийт	XX	100%

Ажиллагсад: _____-ны байдлаар Компани • ажиллагсадтай байв.
Эдгээрийн аль нь ч үйлдвэрчний эвлэлд нэгдээгүй бөгөөд Компанид бослого буюу ажил хаялт гарч байгаагүй.

Санхүүгийн тоо баримтын нэгтгэл (мянган ам. доллар)									
оны 12-р сарын 31-ний байдлаар									
	2002	2003	2004	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П
Орлого	10,000	20,000	40,000	10,000	12,000	14,400	17,280	20,736	24,883
Нийт ашиг	5,000	10,000	20,000	5,000	6,150	7,556	9,272	11,367	13,921
Үйл ажиллагааны орлого	3,470	8,360	18,240	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270
Цэвэр ашиг	2,520	7,410	17,290	1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220

Т = Төсөвлөсөн
П = Прогноз

IV. ХУРААНГУЙ

А. Ерөнхий байдал

ХХ Компани тус улсын хэвлэлийн болон баглаа боодлын томоохон компаниудын нэг. Компани олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд хэд хэдэн төрлийн үйлчилгээ, үүний дотор график дизайн, хэвлэлтийн өмнөх бэлтгэл, хэвлэлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд мөн туслах үйл ажиллагаа (үдэх, зүсэх, г.м.) явуулдаг. Компани үйл ажиллагаагаа өөрийн төв байр болон зургаан орон нутгийн төвөөр дамжуулан явуулдаг. ХХ Компанийн удирдлагын баг ба Компанийн хэрэглэгчдийн дунд бий болсон нэр хүнд Компанийг өндөр өсөлт, асар их амжилтанд хүргэжээ. Хэдийгээр зах зээл өрсөлдөөн ихтэй, мөн улс орны эдийн засгийн ерөнхий байдал хүнд байсан ч Компани өсөж өндийж амжилтанд хүрсэн нь тодорхой байна.

ХХ Компани Монголд шинээр гарч буй зах зээлийн боломжийг ашиглах боломжтой бат бэх байр сууриа олсон бүтээгдэхүүн болон боловсон хүчинтэй нь харагдаж байна. 1994 онд жижиг бизнесийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан тус компани анх нэг өнгөөр хэвлэдэг (танилцуулга) жижиг хэвлэлийн цех байсан аж. 1995 онд хэвлэлийн шинэ тоног төхөөрөмж худалдаж авах үед ХХ Компани Азид антибиотикийн томоохон үйлдвэрлэгчдийн тоонд орох Антибиотик УБ компанийн баглаа боодлын чухал нийлүүлэгч болсноор үйл ажиллагаа нь өргөжин тэлсэн байна. Мөн 1995 онд тус Компани Улаанбаатарт байрлалтай үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох шөл үйлдвэрлэдэг компанийн гол баглаа боодол нийлүүлэгч нь болсон байна. Компани 1997 оноос хойш бүс нутгийн зургаан салбартай болжээ.

Компани нь байгуулагдсанаасаа хойш чанартай бүтээгдэхүүн нийлүүлдгийн хувьд харьцангуй бат бэх байр суурь эзэлж байсан бөгөөд өөрийн үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээг харгалзан чанартай үйлчилгээ үзүүлэх ба олон төрлийн бүтээгдэхүүн санал болгох талаар ихээхэн чармайлт гаргаж ажиллажээ (хэвлэлтийн төрлөө олшруулсан – өнгийн тоо, товойлгон сийлбэрлэсэн хэвлэл, хөнгөн цагаан хальс ашиглах зэрэг). Салбарт гарч буй өөрчлөлт, мөн бүтээгдэхүүний чанар, хэрэглэгчийн хэрэгцээтэй зэрэгцэн алхах зорилгоор Компани гурван үндсэн хэсгээс бүрдэж байна:

- Эм, эмийн бэлдмэл, чихэр, гоо сайхны бараа, аж үйлдвэрийн барааны картон хайрцаг (чийдэн г.м.);
- Цаасан баглаа боодол ба шошго (гол төлөв хүнсний бүтээгдэхүүн, ундаа г.м.); ба
- Ном, сэтгүүл хэвлэл.

Компанийн удирдлагын баг нь туршлага арвинтай нь харагдаж байна (салбарт ажилласан нийт хугацаа 40 гаруй жил байна). ХХ Компанийн төв болон салбаруудын үйлдвэрлэл, борлуулалт, туслах газар ба захиргаанд үйлдвэрчний эвлэлд нэгдээгүй 216 ажиллагсад ажиллаж байна.

Б. Тусгайлан авч үзэх асуудлууд

Өсөлтийн тоо баримт

Хэдийгээр зах зээл дэх өрсөлдөөн их байсан ч ХХ Компанийн зах зээлд эзлэх хувь өсч чадсан байна (одоогоор зах зээлийн 8 хувийг эзэлж байна). 2001 оны эхний зургаан сарын байдлаар Компанийн үйл ажиллагаа 2000 онтой харьцуулахад • хувиар өссөн бөгөөд жилийн өсөлт нь • хувьд хурэхээр байна.

Эрэлт хэрэгцээ

Компанийн анхдагч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан үзвэл уян хатан хэвлэлтийг нэвтрүүлж үйл ажиллагаагаа өргөтгөх нь Компанийн өсөлтөд ихээхэн нөлөөлөх юм. Компанийн удирдлагын үзэж байгаагаар Компанид цаашид орлогоо нэмэгдүүлэх хангалттай нэр хүнд, туршлага байна.

Бизнесийн хамгийн гол боломж

ХХ Компани нэлээд олон тогтмол үйлчлүүлэгчидтэй болсон бөгөөд зах зээлд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэгч гэсэн нэр хүнд олж авч чаджээ. Компанийн удирдлагын үзэж байгаагаар ХХ Компанийн үндсэн үйлчлүүлэгчид, үйл ажиллагаандаа баримтладаг бодлого болон удирдлагын хүч чадал нь Монголын хэвлэлийн болон баглаа боодлын тэргүүний үйлдвэрлэгч болох хангалттай нөхцөлийг бүрдүүлж байна. Компанийн удирдлага энэхүү стратегийг хэрэгжүүлэх зарим боломж зах зээлд, ялангуяа уян хатан баглаа боодлын салбарт байгаа гэдгийг сайн мэдэж байгаа.

Ашиг олох боломж

ХХ Компани боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлж, нэмүү өртөгт үйлчилгээнийхээ эзлэх хувийг өргөтгөж, үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгосноор 2001 оны эхний зургаан сард Компанийн ашиг үлэмж хэмжээгээр нэмэгджээ. Энэ хугацаанд Компанийн үйл ажиллагааны ашиг нь • хувиар өсч борлуулалт нь • хувиар нэмэгдсэн байна.

Олон төрлийн бүтээгдэхүүн санал болгох нь

ХХ Компани хэрэглэгчиддээ олон төрлийн бүтээгдэхүүн санал болгодог бөгөөд үүнд хэвлэмэл цаас болон картон, хэвлэмэл шошго, танилцуулга, брошюр, плакат, эм, эмийн бэлдмэл, хүнсний бүтээгдэхүүн болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд зориулсан тусгай картон баглаа боодол ордог ба эдгээрийг олон төрлийн цаасаар хийдэг бөгөөд товойлгон сийлбэрлэсэн хэвлэл буюу хөнгөн цагаан хальс дээрх хэвлэл зэрэг тусгай боловсруулалт бас хийдэг. Сайн чанарын бүх цаас, картоныг импортоор авдаг.

Зах зээлийн санхүүжилтийн таатай нөхцөл

ХХ Компани нь ийм хүчин чадал болон нэр хүндийг бий болгож чадсан тул тэрээр нийлүүлэгчдээс худалдаж авдаг бараа материалаа таатай нөхцөлөөр санхүүжүүлэх, мөн банкны эргэлдэх зээлээ хөнгөлттэй нөхцөлөөр авах арга замыг олж чаджээ.

Зах зээл дэх нэр хүнд

ХХ Компани зах зээл дэх хэрэглэгчид болон нийлүүлэгчдийн дунд сайн нэр хүнд олж чадсан. Компанийн үзэж байгаагаар хэрэгдэгчдийн тоо багасахгүй бөгөөд худалдан авалтын давталт мөн цөөрөхгүй байхаар байна.

Тогтмол үйлчлүүлэгчид

ХХ Компани тогтмол бөгөөд нэр хүндтэй олон хэрэглэгчидтэй. Компани ойролцоогоор 28 том бөгөөд идэвхитэй хэрэглэгчидтэй, үүний дотор Монголын тэргүүний хувийн компаниуд, олон улсын байгууллагууд, боловсролын ба засгийн газрын байгууллагууд ордог бөгөөд эдгээрийн олонхи нь сүүлийн дөрөв гаруй жилийн турш Компанийн тогтмол хэрэглэгч байсан байна.

Менежментийн баг

ХХ Компани туршлагатай бөгөөд мэргэжлийн удирдлагын багтай. Компани туршлагатай ажиллагсадтай бөгөөд тус салбарт нийт 40 гаруй жил ажилласан байна. Бүх мэргэжлийн ажилчид, үүний дотор шугам дээр ажилладаг ажилчдыг салбарын мэргэжилтэнгүүд сургасан бөгөөд ихэнх нь гадаадад (Герман, Испани зэрэг улсад) дадлага эзэмшсэн байна. Компани энэхүү баримтанд хавсаргасан төлөвлөгөөг биелүүлэхэд шаардлагатай боловсон хүчнээр хангагдсан гэж Компани үзэж байна.

Зах зээлд нэвтрэхтэй холбоотой хүндрэлүүд

ХХ Компанийн зах зээл дэх нэр хүнд болон цар хүрээ нь түүнд зах зээлд бат бэх байр суурь эзлэх боломж олгож байна. Компанийн үзэж байгаагаар ажиллах хүч, тоног төхөөрөмж, технологи болон нийлүүлэгч, хэрэглэгчидтэй байгуулах харилцаанд оруулах шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байдаг тул зах зээлд шинээр нэвтрэхэд ихээхэн хүндрэлтэй. Тус салбарт их хэмжээний хөрөнгө мөнгө шаардагддаг. Үүнээс гадна үйлчлэгч тус бүрийн эрэлт хэрэгцээ ихээхэн ялгаатай байдаг. Үйлчлүүлэгчид анхны бүтээгдэхүүн буюу үйлчилгээг худалдан авсныхаа дараа сэтгэл нь хангалуун үлдвэл тэд тус Компанийн удаан хугацааны үйлчлүүлэгчээр үлдэх магадлал өндөр байдаг.

Эрсдэлийн хүчин зүйлс

Компани эдийн засгийн хямрал, зах зээлийн өрсөлдөөний хүчин зүйлс, чанартай бүтээгдэхүүний нийлүүлэлт болон ажиллах хүч, бизнесийн төсөв зэрэг олон янзын эрсдэлд орох магадлалтай байдаг. Компанийн үзүүлж буй үйлчилгээний зах зээл өрсөлдөөн ихтэй. Компани гол төлөв өөрийн нэр хүнд, үйлчилгээний төвшин болон шинэчлэл хийж зах зээл дэх өөрийн байр сууриа бататгах ба хадгалах чадварт тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг.

В. Хэлэлцээр хийх шалтгаан ба түүний хүлээгдэж буй хэлбэр

ХХ Компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд гол хувьцаа эзэмшигч ноён Монголд хөгжөөгүй байгаа уян хатан хэвлэл ба баглаа боодлын бизнес рүү орж өөрийн бизнесээ өргөжүүлэхэд түүнд капитал зардалд 2 сая ам. долларын хөрөнгө шаардлагатай байгаа ба тэрээр энэ хөрөнгийг хувийн хөрөнгө оруулалтын зах зээлээс бүрдүүлэх эрмэлзэлтэй байгаа аж. Тус хөрөнгийг зах зээлийг хангахад шаардлагатай байгаа хэвлэл, баглаа боодлын нэмэлт тоног төхөөрөмж худалдаж авахад зарцуулна.

V. САНХҮҮГИЙН ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ

		КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)								
		Төсөвлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан								
		оны 12-р сарын 31-ний байдлаар								
		Бүгд дүн мянган ам. доллараар								
7	ОРЛОГЫН ТАЙЛАН:	2002	2003	2004	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П
9	Орлого	10,000	20,000	40,000	10,000	12,000	14,400	17,280	20,736	24,883
10	Борлуулалтын өртөг	5,000	10,000	20,000	5,000	5,850	6,845	8,008	9,369	10,962
11	Нийт ашиг	5,000	10,000	20,000	5,000	6,150	7,556	9,272	11,367	13,921
13	Борл., ерөнхий ба захиргааны зардал	1,000	1,100	1,200	1,400	1,638	1,916	2,242	2,623	3,069
14	Үйл ажиллагааны бусад зардал	30	40	60	70	82	82	82	82	82
15	ХТЭӨА	3,970	8,860	18,740	3,530	4,430	5,557	6,948	8,661	10,770
17	Элэгдэл ба амортизаци	500	500	500	500	500	500	500	500	500
18	ХТӨА	3,470	8,360	18,240	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270
20	Хүүгийн зардал	700	700	700	700	700	700	700	700	700
21	Үйл ажиллагааны бус орлого (зардал)	50	50	50	50	50	50	50	50	50
22	ТӨА	2,720	7,610	17,490	2,280	3,180	4,307	5,698	7,411	9,520
24	Орлогын татвар	200	200	200	1,280	200	200	200	200	300
25	Цэвэр ашиг/(алдагдал)	2,520	7,410	17,290	1,000	2,980	4,107	5,498	7,211	9,220

		оны 12-р сарын 31-ний байдлаар								
		Бүгд дүн мянган ам. доллараар								
3	ТАЙЛАН ТЭНЦЭЛ	2002	2003	2004	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П
4	ХӨРӨНГӨ									
5	Эргэлтийн хөрөнгө									
6	Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах мөнгөн хөрөнгө									
7	Авлага, цэвэр									
8	Бараа материал									
9	Эргэлтийн бусад хөрөнгө									
10	Нийт эргэлтийн хөрөнгө									
12	Үндсэн хөрөнгө									
13	Эд хөрөнгө, барилга, тоног төхөөрөмж				300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000
14	Эргэлтийн бусад хөрөнгө									
15	Нийт үндсэн хөрөнгө				300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000
17	НИЙТ ХӨРӨНГӨ				300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000
19	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ									

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл

20						
21	Богино хугацаат өр төлбөр					
22	Худалдаа, бусад өр төлбөр					
23	Эргэлтийн ба бусад хуримтлагдсан өр төлбөр					
24	Богино хугацаат зээл					
25	Өр төлбөр, төлбөрийн нөөцийн сан					
26	Нийт богино хугацаат өр төлбөр					
27						
28	Урт хугацаат өр төлбөр					
29	Урт хугацаат өр					
30	Нийт урт хугацаат өр төлбөр					
31						
32	Нийт өр төлбөр					
33						
34	Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц					
35	Энгийн хувьцаа					
36	Нөөц ба сангууд					
37	Хуваарилаагүй ашиг	1,000	2,980	4,107	5,498	7,211
38	Нийт эзэмшигчдийн хөрөнгө ба нөөц	1,000	2,980	4,107	5,498	7,211
39						
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШ. ХӨРӨНГӨ	1,000	2,980	4,107	5,498	7,211
41						
42	Тайлбар:					
43						
44	T- төсөвлөсөн					
45	P - прогноз					

VI. ДҮН ШИНЖИЛГЭЭ

Удирдлагаас олгосон мэдээлэл дээр үндэслэн Дүн шинжилгээний баг.....

А. ЧӨЛӨӨТ МӨНГӨН УРСГАЛ БА ӨХХ

Зээлгүй компанийн чөлөөт мөнгөн урсгалыг
ХТӨА-ийн аргачлалыг ашиглан тооцоолох нь

КОМПАНИЙН НЭРИЙН КОД (дээрээс нь бөглөнө үү)
Төсөвлөсөн санхүүгийн аудитлагдаагүй тайлан


_____ оны 12-р сарын 31-ний байдлаар
Бүгд дүн мянган ам. доллараар

	2005Т	2006П	2007П	2008П	2009П	2010П
ХТӨА	3,030	3,930	5,057	6,448	8,161	10,270
Нэмэх нь: Элэгдэл	500	500	500	500	500	500
Бэлгээр төлсөн татварын төлбөрийг хасах	1,280	200	200	200	200	300
Капиталын цэвэр зардлыг хасах	-300,000	0	0	0	0	0
Шаардлагатай цэвэр эргэлтийн хөрөнгийн өсөлтийг хасах (бууралтыг нэмэх)	0	0	0	0	0	0
Зээлгүй компанийн чөлөөт мөнгөн урсгал	-295,190	4,630	5,757	7,148	8,861	11,070

ӨХХ

Б. САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хувилбар - суурь										
Харьцаанууд :	2002	2003	2004	CAGR1	2005T	2006П	2007П	2008П	2009П	2010П
Ашгийн										
Нийт ашгийн	50%	50%	50%	100%	50%	51%	52%	54%	55%	56%
Үйл ажиллагааны ашгийн	35%	42%	46%		30%	33%	35%	37%	39%	41%
Цэвэр ашгийн	25%	37%	43%		10%	25%	29%	32%	35%	37%
Дюпоны дүн шинжилгээ										
Үйл ажиллагааны ашиг	35%	42%	46%		30%	33%	35%	37%	39%	41%
Хөрөнгийн эргэлт	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0.03	0.04	0.048	0.0576	0.0691	0.0829
Зээл жилт	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		300	100.67	73.044	54.568	41.602	32.539
Хуугийн ачаалал	0.78	0.91	0.96		0.75	0.81	0.85	0.88	0.91	0.93
Татварын ачаалал	0.93	0.97	0.99		0.44	0.94	0.95	0.96	0.97	0.97
ХӨ	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0.01	0.01	0.0169	0.0215	0.0272	0.0342
ӨХӨ	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		1	1	1	1	1	1



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Эргэлтийн харьцаа (эргэлт.хөрөнгө/богино хуг.өр төлбөрийн харьцаа)

#DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0! #DIV/0!

Зээл

Хүүгийн төлбөр	5	11.9	26.1		4.3	5.6	7.2	9.2	11.7	14.7
Өр/нийт хөрөнгө	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0	0	0	0	0	0
Өр/өөрийн хөрөнгө	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!		0	0	0	0	0	0

VII. ТӨСӨӨЛӨЛ

Санхүүгийн тайланд (дээр дурьдсан) хавсаргасан Санхүүгийн таван жилийн прогнозыг Компанийн удирдлага гаргасан бөгөөд энэ нь Компаниас хэрэгжүүлэх гэж буй төлөвлөгөө болон ирээдүйн үйл ажиллагаанд үндэслэн гаргасан тооцооны үр дүн юм.

VIII. ДҮГНЭЛТ

Зураг А. Санхүүгийн прогноз

Зураг Б. Удирдлагын намтар

**ХАВСРАЛТ Е: ХУВИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ
ЯВЦ - СЕМИНАР – ХӨНДСӨН АСУУДЛУУД**

ХАВСРАЛТ Е: ХУВИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ - СЕМИНАР – ХӨНДСӨН АСУУДЛУУД

А. Ач холбогдол

Дүн шинжилгээний үйл явцыг үр дүнтэй болгохын тулд бизнес эрхлэгчдийг сургах талаар ихээхэн чармайлт гаргах шаардлагатай байв. Үүнээс гадна компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хувийн хөрөнгө оруулалт нь ямар үр дагавартай вэ гэдгийн үндсэн ойлголтыг энэхүү дүн шинжилгээнд хамрагдхаар шийдсэн компаниудад ойлгуулах нь чухал байлаа. Зах зээл зөвхөн зээлийн хөрөнгийн талаар мэдлэгтэй байгаа тохиолдолд компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хувийн хөрөнгийн талаар үлгэр домог болон буруу ойлголт тархсан байдаг. Ийм үлгэр домог, буруу ойлголтыг байхгүй болгож бизнес эрхлэлтийн арга барил болон санхүүг боловсронгуй болгох явдлыг өндөр төвшинд хүргэхэд туслалцаа үзүүлэхийн тулд бизнес эрхлэгчдийг сургаж тэдэнд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Б. Компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хувийн хөрөнгийн талаарх семинар

Бизнес эрхлэгчдийн дунд ийм сургалт явуулах хэрэгцээ байсан тул бид хувийн хөрөнгийн зах зээлд хөрөнгө бүрдүүлэх асуудлыг сонирхож байгаа бүх оролцогчдыг оролцуулсан сургалт семинар зохион байгуулах нь зохимжтой гэж үзсэн юм.

2005 оны 2-р сарын 18-ны өдөр Б. Норланд хувийн хөрөнгийн зах зээлээс хөрөнгө бүрдүүлэх талаар 4 цагийн семинар зохион байгуулсан юм. Семинарыг Монголын бизнес эрхлэгчид, банкны ажилтан нар, нягтлан бодогчид, хуульчид, зөвлөхүүд болон зуучлагчдад зориулсан бөгөөд түүний зорилго нь хөрөнгийн эх үүсвэр болох хувийн хөрөнгийн талаарх тэдний мэдлэгийг дээшлүүлж компанийн эзэмшигчийн өмчид хийх хувийн хөрөнгө оруулалтыг татахад бизнесийнхнээс шаарддаг зүйлийг харуулахад оршиж байв.

Семинарын үед дараахь гол сэдвүүдийг хөндсөн болно. Үүнд:

1. **Хөрөнгийн эх үүсвэрийн ертөнц ба хувийн хөрөнгийн зах зээлд гүйцэтгэж байгаа үүрэг** - Олон компанийн хувьд тэдний мэддэг хөрөнгийн ганц эх үүсвэр нь арилжааны банк байдаг. Энэ хэсгийн зорилго нь оролцогчдод бүх төрлийн хөрөнгийн эх үүсвэрийг танилцуулахад оршиж байлаа. Эх үүсвэрийн талаар ярьж эхлэхээсээ өмнө өөрийн үйл ажиллагааг дэмжих техникийн талаар танилцуулж, мөн хөрөнгө бүрдүүлэх асуудлыг аль болох хойш нь тавихын үр дагавар, хөрөнгө оруулагчдын хувьд өөрийн үйл ажиллагааг дэмжихийн ач холбогдолыг танилцуулсан болно. Семинарын үеэр дараахь эх үүсвэрүүдийг хөндсөн болно. Үүнд:
 - а. **Үүсгэн байгуулагч, гэр бүл, найз нөхөд** - Энд нэг чухал асуудал бол аливаа боломжит хөрөнгө оруулагч үүсгэн байгуулагчид эд баялгийнхаа хэдэн хувийг компанидаа оруулсан байгааг сонирхох болно.
 - б. **Бичил зээл** - Бичил зээл олгогчид хөгжиж буй оронд явуулж буй чухал үйл ажиллагааны талаар ярьсан.

- в. **”Тэнгэрийн сахиус” хэмээх ивээн тэтгэгчид** - Өргөнөөр олддог боловч тодорхойлоход хэцүү энэхүү эх үүсвэрийн талаар тодорхой ярьсан болно.
Ийм хөрөнгө оруулагчдаар дамжин жил бүр хийгддэг гүйлгээний тоо, хэмжээний талаар, мөн Монголын компаниудын хувьд эдгээрийн ач холбогдол болон эдгээрийг олохтой холбоотой хүндрэлүүдийг хэлэлцсэн болно.
- г. **Хувийн хөрөнгө оруулалтын сангийн төрөл** - Энд олон төрлийн санг хөндсөн болно. Үүнд:
- i. Аз турших капиталын сан
 - ii. Компанийг худалдан авах сан
 - iii. Худалдааны банкны сан
 - iv. Сангуудын сан
 - v. Дунд шатны санхүүжилтийн сан
- д. **Санхүүгийн бус корпораци** - Энэхүү эх үүсвэрийг төдийлөн анхаардаггүй ч энэ нь эзэмшигчийн өмч болон түүнтэй адилтгах хөрөнгийн санхүүжилтийн чухал эх үүсвэр байж болдог.
- е. **Нийтийн хөрөнгийн зах зээл** - Энэхүү сэдвээр зөвхөн Монголын зах зээл бус, бусад шинээр гарч ирж буй зах зээлд тулгарч буй хүндрэлүүдийн талаар товчхон дурьдсан.
- ё. **Арилжааны банкууд** - Монголын бизнес эрхлэгч бүр өнөөдөр Монголд арилжааны банкнаас зээл авах нь хичнээн хүндрэлтэй байгааг мэдэж байгаа. Бид энд арилжааны банктэй холбоотой зарим нэг асуудлыг товчхон хэлэлцсэн бөгөөд Монгол Улсын хөгжиж буй эдийн засагт хөрөнгийн бусад эх үүсвэр хэрхэн тусалж болох талаар хэлэлцсэн болно.

Мөн хувийн хөрөнгийн зах зээлээс олж болох мөнгөний хэмжээ болон хөрөнгийн өртөг/шаардлагатай өгөөжийн хэмжээг тайлбарлах зорилгоор хөрөнгийн эх үүсвэр тус бүрийн эрсдэл/үр ашгийн ач холбогдлын талаар хэлэлцсэн болно.

2. **Хувийн хөрөнгийн салбарын бүтэц** - Энэхүү сэдэвт мөнгийг ”хаанаас” олдог мөн мөнгө ”ямар амттай” орж ирдгийг хөндсөн болно. Энд олон төрлийн хувийн хөрөнгийн сангийн зах зээлийн талаар хэлэлцсэн бөгөөд мөн сангуудын сан, даатгалын компани, тэтгэврийн сан, сангийн хөрөнгө оруулагч хэн болох, худалдааны банкны салбарууд, корпораци, ”Тэнгэрийн сахиус” хэмээх ивээн тэтгэгч зэрэг сангуудын хөрөнгө оруулагчид нь хэн болох талаар хэлэлцсэн. Мөн Монголын компаниудын хувьд ихээхэн чухал асуудал болох хувийн хөрөнгө оруулагчдыг ХЭРХЭН олох талаар хөндөж ярьсан болно.
3. **Хувийн хөрөнгө оруулалтын сан хэрхэн ажилладаг вэ** - хувийн хөрөнгө оруулалтын сан хэрхэн ажилладаг талаарх үндсэн ойлголтыг харуулсан болно. Үүнд:
- а. Санг байгуулах үндэслэлийг гаргах зорилгоор явуулах хөрөнгө оруулах боломжийн анхны судалгаа - Энэ нь үндсэндээ санг ”яагаад” байгуулах тухай хариулт юм.

- б. Ерөнхий түнш ба хязгаарлагдмал түнш - энд санд оролцож байгаа хүмүүс хэн болох, мөн хэний мөнгө эрсдэлд байгаа талаар хэлэлцсэн болно.
- в. Мөнгө бүрдүүлэх (санд зориулж) - энд Хувьцааг тодорхой байгууллагуудад борлуулах меморандум ("ХТББМ"), хөрөнгийн амлалтын талаар ярьсан болно.
- г. Хөрөнгө оруулалт хийх нь - энэ хэсэгт сангийн хязгаарлалт, бодлого, бүрэн эрх, хэлбэр болон сангийн стратегийг хөндсөн.

4. **Хөрөнгө оруулагчийн шалгуур үзүүлэлтүүд** - Семинарын хамгийн чухал асуудал нь бизнес эрхэлдэг хүмүүст хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийх боломжоос юуг хүлээж байдгийг харуулах явдал байсан болов уу. Дор (мөн семинарын үеэр) дурьдсан жагсаалт иж бүрэн бус хэдий ч эдгээр нь хамгийн чухал шаардлага болно:

- а. **Менежментийн хүчирхэг баг** - Менежментийн "хүчирхэг" баг гэж юуг хэлэх вэ гэдгийг нарийн тайлбарласан болно. Энд менежмент ШУДАРГА бөгөөд ИЛ ТОД байх нь бусдаас хамгийн чухал гэдгийг цохон тэмдэглэсэн юм. Үүнээс гадна, менежмент нь ашигтай ажиллаж буй компани удирдах чиглэлээр арвин туршлагатай байх ёстой бөгөөд хөрөнгө оруулагчидтай нэгдмэл байдлаар харилцан ажиллах эрмэлзэлтэй байх ёстойг тэмдэглэсэн болно.
- б. **Бүтээгдэхүүн ба үйлчилгээний өсч буй том зах зээл - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНДӨР ӨГӨӨЖ** - Энд мөн эрсдэл/үр ашгийн аль алины нь талаар дурьдахдаа хөрөнгө оруулагч эрсдэл хүлээснийхээ хариуд хөрөнгө оруулалтаас "шаардах" үр ашгийн төвшинг онцгойлсон болно.
 - і. Бизнесийн хөгжлийн үе шатнаас хамааран хөрөнгө оруулагчдын хүлээж буй жилийн хуримтлуулсан хувиар тооцох дараахь өгөөжийн хэмжээнд хүргэхийг эрмэлзэнэ:

1. Эхлэлийн үе шат	50%-70%	-Орлого байхгүй
2. 1-р үе шат	40%-60%	-Орлого хуримтлуулж эхлэж буй
3. 2-р үе шат	30%-40%	-Ашиг хуримтлуулж эхлэж буй
4. 3-р үе шат	10%-30%	-Зах зээлд бат бэх байр суурь эзэлж буй - цаашид өргөжин тэлэхэд бэлэн

Эдгээр шаардагдаж буй өгөөжийн хэмжээ нь хөгжиж буй Монгол шиг шинээр гарч ирж буй зах зээлд түгээмэл байдаг валют, хууль эрх зүй, улс төр болон бусад нэмэлт эрсдэлийг бодолцсоны үндсэн дээр нэлээд өндөр байж болох талаар семинарт оролцогчдод сануулж байв.

- в. **Төлөвлөсөн "гарц" (тодорхой)** Хөрөнгө оруулагчийн зүгээс харгалзан үзэх гурав дахь хамгийн чухал шалгуур нь хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийгдсэн компанид эзэмшиж буй өөрийн хувьцаагаа ХЭРХЭН борлуулах юм. Энд хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт хийх хугацааны хязгаарыг хөндөж ярьсан бөгөөд энэ нь гол төлөв 3-аас 7 жил

байдаг (3-5 жил нь илүү түгэмээл). Хөрөнгө оруулагч "яагаад" цаг хугацааны хязгаар тавьдгийг тайлбарлаж (шаардлагатай өгөөжийн хэмжээ болон ашгийг "хэрэгжүүлэх"-тэй холбон) мөн хөрөнгө оруулагч хөрөнгө оруулсан компаниасаа гарах (хөрөнгө оруулсан компанид эзэмшиж буй хувьцаагаа худалдах замаар) ТОДОРХОЙ стратегитай байх нь хамгийн чухал гэдгийг тайлбарласан болно.

Гарцын стратеги болон хөрөнгө оруулагчид Монголд оруулсан хөрөнгө оруулалтаасаа гарахад тулгарах хүндрэлүүдийг хэлэлцсэн болно.

Хөрөнгө оруулагч өөрийн олсон ашгаа хэрхэн гаргадгийг энэ хэсэгт харуулж, мөн хөрөнгө оруулагч мөнгийг "хамгийн оновчтойгоор" хэрхэн хийдгийг үзүүлсэн юм.

- г. **Оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл** - Энэ асуудлын хамгийн гол зүйл бол хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийснээр "бэлэн мөнгө"-нөөс гадна илүү чухал зүйлийг авчирдаг гэдгийг тэмдэглэсэн юм. Тэд их хэмжээний туршлагатай байдаг.
 - д. **Үүсгэн байгуулагчийн зүгээс үргэлжүүлэн үзүүлэх дэмжлэг** - Хөрөнгө оруулагчийн хувьд компанийн үүсгэн байгуулагч компанидаа ҮЛДЭХ нь чухал байдгаас гадна түүнийг тавьсан зорилтонд хүрэх сонирхолтой байлгах нь ихээхэн чухал байдгийг энд тэмдэглэсэн болно. Вестинг зэрэг олон янзын хөшүүргийн механизмыг хэлэлцсэн болно.
 - е. **Сайтар бэлдсэн баримт бичгүүд ба санхүүгийн тайлан** - Энд их хүч чармайлт шаардлагагүй ч энэ нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж болох зүйлүүдийн нэг юм. Сангийн менежерүүд бизнесийн төлөвлөгөө / санал болгох меморандумын зөвхөн 1 хувийг л нарийвчлан судалж үздэг гэдгийг энд тэмдэглэсэн. Энэ нь хөрөнгө оруулалтын бодит боломж байхгүй байсан гэсэн үг бус юм. Ихэнх компани өөрийн мэдээллээ олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хэв маягаар бэлдэж чаддаггүй гэсэн үг юм.
5. **Бизнесийн төлөвлөгөө болон мөнгөн урсгалын төсөвлөлт** - Энэ хэсэгт дараахь гол асуудлуудыг хэлэлцсэн болно:
- а. Бизнес төлөвлөгөөнд ихэнх тохиолдолд анзаарахгүй орхигдуулдаг бүрэлдэхүүн хэсгүүд
 - б. Бизнес төлөвлөгөө ба "санал болгох меморандум"-ын хоорондын ялгаа
 - в. "Чөлөөт мөнгөн урсгал" гэж юүг хэлдэг ба түүнийг юунд хэрэглэдэг
 - г. Бизнесийн стратегийг чөлөөт мөнгөн урсгалд хөрвүүлэх нь
6. **Үнэлгээ** - Энд мэргэжлийн хөрөнгө оруулагчид компанийг "хэрхэн" үнэлдэг мөн компанийн бодит үнэ, түүнтэй харьцуулах хөрөнгийн үнэлгээ буюу бүртгэлийн үнийн хувилбаруудыг хэрхэн гаргаж авдаг талаар тайлбарласан болно. Энэ хүрээнд дараахь асуудлыг хэлэлцсэн:
- а. Үнэлгээ хийх шаардлага
 - б. Үнэлгээний аргууд
 - в. Хөрөнгийн өртөг /Шаардлагатай өгөөжийн хувь хэмжээ
 - г. Үнэлгээний явцад тулгардаг хүндрэлүүд
 - д. Баялаг бий болгох

7. **Хөрөнгө бүрдүүлэх үйл явцын 8 тодорхой алхам** - Хөрөнгө бүрдүүлэх үйл явцын 8 алхам тус бүрийг энд хэлэлцсэн болно, үүнд:

- 1-р алхам - Стратеги
- 2-р алхам - Мэдээлийн меморандумыг бэлдэх
- 3-р алхам - Хөрөнгө оруулагчдыг сонгох
- 4-р алхам - Хөрөнгө оруулагчдад танилцуулах
- 5-р алхам - Хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх
- 6-р алхам - Хэлцлийн бүтцийг тодорхойлох
- 7-р алхам - Хөрөнгө оруулагчийн дүн шинжилгээ
- 8-р алхам - Хаалтын ажиллагаа

8. **Хууль эрх зүйн асуудлууд** - Хууль эрх зүйн дараахь асуудлуудыг хэлэлцсэн болно:

- а. Баримт бичиг
- б. Нээлттэй компанийн асуудлууд
- в. Санхүүгийн туслалцаа болон зохицуулалтын бусад асуудлууд
- г. Мониторинг

9. **Засгийн газрын бодлого** - Хамгийн сүүлд хэлэлцсэн сэдэв бол хөрөнгө оруулагчид засгийн газрын бодлогоос юүг олж харахыг эрмэлздэг талаар байв. Хөрөнгө оруулагчид дараахь шинж чанартай бодлого баримтладаг "бизнесийг дэмжигч" засгийн газартай хамтарч ажиллахыг эрмэлздэг гэдгийг энд тэмдэглэсэн. Үүнд:

- а. Эрх зүйн зохицуулалтын тааламжтай, тогтсон орчинг бий болгосон
- б. Бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлсэн
- в. Хөрөнгө оруулагчдын эрхийг хүндэтгэн баталгаажуулсан
- г. НББОУС болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад хуулийг мөрддөг
- д. Компанийн засаглал
- е. Алсын хараатай байх
- ё. Засгийн газар зохицуулалтыг хэтрүүлэхгүй байх
- ж. Дампуурлын тухай хууль
- з. Улс орны хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлдэг байх
- и. Бизнес эрхлэгчид дэлхий нийтийн эдийн засгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулахад нь бэлтгэх талаар байнга шинэтгэл хийж ажиллах
- к. Татварыг ШУДРАГААР тогтоох
- л. Хүнд суртал багатай
- м. Бизнесийн тусгай зөвшөөрлийг хууль ёсоор олгодог байх
- н. Бизнесийг СОНСДОГ засгийн газар

Эдгээр сэдвүүдийг нарийн хэлэлцэхэд дөрвөн цаг хангалтгүй байсан ч энэ нь Монголын олон бизнес эрхлэгчдийн хувьд шинэ сэдэв болох хөрөнгийн эх үүсвэрийн талаар хангалттай танилцуулга болно гэж найдаж байсан болно. Семинарын үеэр Монголын компаниуд гадаадын хувийн хөрөнгө оруулалтыг татахад тулгардаг зарим хүндрэлүүдийн талаар хөндөж ярьсан болно. Семинарын дараа идэвхтэй асуулт хариулт явагдсан болно. Семинарт ойролцоогоор 100 хүн оролцсон бөгөөд олон хүн ийм төрлийн курс, сургалт семинарыг дахин явуулах хүсэлт гаргаж байв.

**ХАВСРАЛТ Ё: ХУВИЙН КОМПАНИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ ҮЙЛ
ЯВЦ - СЕМИНАР –ИЛТГЭЛ**

Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх буюу аз турших капиталаар компанийн хөрөнгийг бүрдүүлэх нь

Бэлдсэн:

Брюс Норланд

Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл – Chemonics

Монгол Улс, Улаанбаатар хот


Хэлэлцэх асуудлууд

- Хувийн компанийн эзэмшигчийн өмчид оруулах хувийн хөрөнгийн салбарын түүх ба бүтэц
- Аз турших капиталаар санхүүжилт хийх шат дамжлага
- Амжилтанд хүргэхүйц бизнес төлөвлөгөө зохиох
- Мөнгөн урсгалыг таамаглан тооцоолох
- Үнэлгээ
- Хэлцлийн бүтцийг тодорхойлох нь
- Эрх зүй, зохицуулалт ба хяналтын асуудлууд
- Асуулт хариулт

Хувийн компанийн эзэмшигчийн өмчид оруулах хувийн хөрөнгийн салбарын гарал үүсэл, түүх ба ХӨГЖИЛ

- Хувийн “эрсдлийн капитал” нь огт шинэ зүйл биш
 - Эртний Ромын Маркус Крассус
 - Христофор Колумб
- Аз турших капиталын “мэргэжлийн” хөрөнгө оруулалт нь харьцангуй сүүлийн үеийн онцгой үзэгдэл

Орчин үеийн түүх



Өөрийн үйл ажиллагааг дэмжих

- Капитал хайхаас аль болох татгалз
- Техник арга барил:
 - Үйлчлүүлэгчдээс урьдчилан төлсөн лиценз, газрын төлбөр буюу урьдчилгаа
 - Өөр газар ажиллаж байх зуураа бүтээгдэхүүнээ боловсруулах
 - Харилцагчаас санхүүжүүлсэн судалгаа
 - Техник хангамжийг чөлөөтэй эзэмших
 - Бизнесийн холбоод
 - Нөхөн олговрын тогтолцоо

Салбарт оролцогсод




“Тэнгэрийн сахиус” хэмээх хөрөнгө оруулагчид буюу ивээн тэтгэгчид

- Хөрөнгөтэй хувь хүмүүс
- “Бэлэн мөнгө”-тэй бизнес эрхлэгчид
- “Тэнгэрийн сахиус” синдикатууд

Ивээн тэтгэгчид-үргэлжлэл

- Бизнесийг тэтгэдэг хамгийн эртний, хамгийн том болон хамгийн түгээмэл гадаад эх үүсвэр
- Зөвхөн АНУ-д гэхэд 3 сая ивээн тэтгэгч жил бүр 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийдэг
- Албан ёсны аз турших капиталын сантай харьцуулахад 30-40 дахин илүү олон тооны компанийг санхүүжүүлдэг
- Ford, Apple, Amazon.com
- Хөрөнгө оруулалтаараа олон давуу тал авчирдаг
- Олоход хэцүү
- Дараагийн арван жилд зах зээл хоёр дахин өсөх магадлалтай



Аз турших капиталын хөрөнгө оруулагч

- Аз турших капиталын сан
- Даатгалын компани
- Тэтгэврийн сан
- Худалдааны банкны салбар
- Корпораци

Ази дахь АТК

OPIC Asia Fund	Canadian World Fund Limited	Saffron Fund
JP Morgan Partners (Asia Opportunity Fund)	China Fund	Scudder New Asia Fund
H&Q Asia Pacific	Emerging Markets Telecommunication	Templeton China World Fund
HSBC	Gabelli Global Multimedia Trust	Templeton Dragon Fund
Baring Private Equity Asia	Greater China Fund	Templeton Emerging Markets Fund
Olympus Capital	Jardine Fleming China Region Fund	Pantheon Capital (Asia)
Central Asia Small Enterprise Fund	Korea Equity Fund	Carlyle Group
Schroder Capital Partners (Asia) Ltd.	Latin America Equity Fund	Prudential (Asia)
AsiaTech Ventures Ltd	Latin American Discovery Fund	Warburg Pincus
PPM Ventures (Asia) Ltd	Morgan Stanley Asia Pacific Fund	Asia Pacific Fund
Latitude Capital Group	Morgan Stanley Emerging Markets	Asia Tigers Fund

Хөрөнгө оруулагчийн шалгуур үзүүлэлт

- Менежментийн хүчирхэг баг
- Бүтээгдэхүүн ба үйлчилгээний зах зээл том бөгөөд өсч буй– оновчтой САНАЛУУД
- Аз турших хөрөнгө оруулалтын үе шатнаас хамааран хөрөнгө оруулагчид жилийн хуримтлуулсан хувиар тооцвол дараахь өгөөжийн хэмжээнд хүрэхийг эрмэлзэнэ:

<input type="checkbox"/> Эхлэл	50%-70%	- Орлого байхгүй
<input type="checkbox"/> Эхний үе шат	40%-60%	- Орлого хуримтлуулж эхлэж буй
<input type="checkbox"/> Хоёр дахь үе шат	30%-40%	- Ашиг хуримтлуулж эхлэж буй
<input type="checkbox"/> Гурав дахь үе шат	10%-30%	- Зах зээлд бат бэх байр суурь эзэлж буй - цаашид өргөжин тэлэхэд бэлэн
- Оролцоо ба удирдах зөвлөлийн гишүүнчлэл
- Үүсгэн байгуулагчийн байнгын хичээл зүтгэл
- Төлөвлөсөн “гарц” (тодорхой)
- Сайтар бэлдсэн баримт бичгүүд ба санхүүгийн тайлан

Гүйлгээний төрлүүд

- Хэлцлийн “үе шат”-наас хамаарна
- Уламжлалт эхлэл
- Өсөлт - өөрийн хөрөнгө
- Байдлыг эрс өөрчлөх хөрөнгө оруулалт
- Зээлээр буюу менежментээр худалдан авах
- Салбарын нэгдэл
- Гаралт


Аз турших капиталын санхүүжилтийн үе шат

- “Эхлэл” буюу эхний үе шат
- Хөгжих буюу хоёр дахь үе шат
- Өргөжих буюу гурав дахь үе шат
- Өсөлт буюу дөрөв дэх үе шат
- Зээлээр худалдан авах
- Байдал эрс өөрчлөгдөх нөхцөл байдал
- Олон нийтэд санал болгох

“Хувийн компанийн өөрийн хөрөнгө”... нь цаашид өсөх эрмэлзэлтэй байгаа компанийн хувьд бодит сонголт юм

- Хугацаа – гол төлөв 3 – 7 жил
- Хүү төлөгдөхгүй, хөрөнгө оруулагч ноогдол ашиг төлөхгүй байхыг илүүд үзнэ
- Мөнгийг компанид оруулахдаа хувьцаат хөрөнгийг өсгөх хэлбэрээр оруулна
- Шинэ хөрөнгө оруулагч баталгаа буюу барьцаа авдаггүй, харин эрсдэл болон эзэмшлийн шагналаас хуваалцдаг.

ХКӨХ-ийн санхүүжилт хэрхэн явагддаг вэ



Хөрөнгө бүрдүүлэх үйл явц

- 1 дэх алхам – Стратеги
- 2 дахь алхам – Мэдээллийн меморандумыг бэлдэх
- 3 дахь алхам – Хөрөнгө оруулагчдыг сонгох
- 4 дэх алхам – Хөрөнгө оруулагчдад танилцуулах
- 5 дахь алхам – Хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх
- 6 дахь алхам – Хэлцлийн бүтцийг тодорхойлох
- 7 дахь алхам – Хөрөнгө оруулагчийн дүн шинжилгээ
- 8 дахь алхам – Хаалтын ажиллагаа

Амжилтанд хүргэхүйц Бизнес төлөвлөгөө болон Мэдээллийн меморандум бэлдэх

- Менежментийн баг
- Зах зээлийн бололцоо
- Бизнесийн стратеги нь ирээдүйн мөнгөн урсгал болон хөрөнгийн хэрэгцээг тодорхойлно
- Эрсдэл– бодит байдлын шалгуур
- Дүн шинжилгээ – нарийн нямбай бөгөөд бэлтгэл сайтай байх

Мөнгөн урсгалыг таамаглан тооцоолох

- Таамаглал хийхэд баримтлах зарчмууд
- Таамаглал, тооцоо боловсруулах
 - Зах зээлийн судалгаа
 - Зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх өөрийн хүчин чадлаа мэддэг байх
- Зах зээлийн мэдрэмжийн дүн шинжилгээ

Үндсэн дүн шинжилгээ

- Компани болон түүний стратегийн тойм
- Тухайн салбарын бүтцийн үнэлгээг хийх
- Компанийн өнөөгийн эдийн засгийн байдалд үнэлгээ өгөх
- Компанийн ирээдүйн чиглэлийг тааварлах

Үнэлгээ

- Мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох (МУХТ) арга
- Ашигт үндэслэсэн арга (үржигдэхүүн ашиглах)
- Хөрөнгөнд үндэслэсэн арга
- Эдийн засгийн үнийг нэмэгдүүлэх
- Салбарын онцлогоос хамаарах үнэлгээний арга

Компанийн үнэлгээ хийх шаардлага

- Өөрийн хөрөнгөндөө нэмэлт хөрөнгө оруулалт хайж буй компанийн эзэмшигчдэд дэмжлэг үзүүлэх
- Үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагчдад чиг баримжаа өгөх
- Стратегийн худалдан авагчдад чиг баримжаа өгөх
- Компанийн эзэмшигчдэд “бэлэн мөнгө олох” дэмжлэг үзүүлэх

Мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох арга (МУХТ)

- МУХТ арга нь “Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ” зарчим дээр тулгуурлана
- Тус арга компанийн үнэ цэнэ түүний мөнгөн урсгалын хорогдуулсан дүнтэй нягт холбоотой гэсэн түгээмэл баримтан дээр үндэслэгдсэн.
- Капитал зардал зэрэг бүх мөнгөн урсгалыг тодорхой сонгосон хугацаанд хорогдуулан тооцно.

Хорогдуулах арга бөгөөд цаг хугацаагаар тооцогдох мөнгөний үнэ цэнэ

Цаг хугацаагаар тооцогдох мөнгөний үнэ цэнэ

Өнөөдөр \$100-тай байсан дээр үү эсвэл таван жилийн дараа \$100-тай байсан дээр үү

Өнөөдрийн \$100

Яагаад?

- Ирээдүйн урсгал илүү тодорхой бус (эрсдэл)
- Өнөөдрийн худалдан авах чадвар илүү сайн (инфляци)
- Өнөөдөр авсан тохиолдолд одоо хэрэглэх бололцоотой

Хөрөнгө оруулагчид төлбөрийг хойшлуулсныг нөхөх зорилгоор нэмэлт өгөөж шаардана (эрсдэл)

Гол санаа

Өнөөдрийн \$1

≠

Маргаашийн \$1

Өнөөгийн үнэ цэнэ

\$100
1 жил
10%

$x (1+0.1)^n$
хуримтлуулах
(хүүгийн хүүг тооцох)

Ирээдүйн үнэ цэнэ

\$110

Хорогдуулалт
 $x \frac{1}{(1+0.1)^n}$

Хуримтлуулах (хүүгийн хүүг тооцох)

Нэг удаагийн мөнгөн урсгалын ирээдүйн үнэ цэнэ (ИҮЦ)-ийг тооцохын тулд

$$\text{Өнөөгийн үнэ цэнэ } t_0 \times (1 + r)^n = \text{Ирээдүйн үнэ цэнэ } t_n$$

r = шаардагдах өгөөж/мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ /хорогдуулах хувь
 n = өнөөдрөөс эхлэн тооцох хугацааны тоо

Хуримтлуулах коэффициент

ИҮЦ - энгийн жишээ

1-р асуулт

10%-ийн хүүтэйгээр
банкнд
байршуулсан
өнөөдрийн \$1000-ын
ирээдүйн үнэ цэнэ
(ИҮЦ) 3 жилийн
дараа ямар байх вэ?

Эхлээд– Асуултыг дараахь
байдлаар хуваа:

ӨҮЦ = \$1000


Хүү = 10%

Хугацаа = 3 жил


Ирээдүйн үнэ цэнийн хүснэгт

FVF_{in} буюу \$1-ын хүүгийн хүүг тооцсон дүн										
n	1%	2%	3%	4%	5%	6%	7%	8%	9%	10%
1	1.01	1.02	1.03	1.04	1.05	1.06	1.07	1.08	1.09	1.1
2	1.02	1.04	1.061	1.082	1.102	1.124	1.145	1.166	1.188	1.21
3	1.03	1.061	1.093	1.125	1.158	1.191	1.225	1.26	1.295	1.331
4	1.041	1.082	1.126	1.17	1.216	1.262	1.311	1.36	1.412	1.464
5	1.051	1.104	1.159	1.217	1.276	1.338	1.403	1.469	1.539	1.611
6	1.062	1.126	1.194	1.265	1.34	1.419	1.501	1.587	1.677	1.772
7	1.072	1.149	1.23	1.316	1.407	1.504	1.606	1.714	1.828	1.949
8	1.083	1.172	1.267	1.369	1.477	1.594	1.718	1.851	1.993	2.144
9	1.094	1.195	1.305	1.423	1.551	1.689	1.838	1.999	2.172	2.358
10	1.105	1.219	1.344	1.48	1.629	1.791	1.967	2.159	2.367	2.594
11	1.116	1.243	1.384	1.539	1.71	1.898	2.105	2.332	2.58	2.853
12	1.127	1.268	1.426	1.601	1.796	2.012	2.252	2.518	2.813	3.138
13	1.138	1.294	1.469	1.665	1.886	2.133	2.41	2.72	3.066	3.452
14	1.149	1.319	1.513	1.732	1.98	2.261	2.579	2.937	3.342	3.797
15	1.161	1.346	1.558	1.801	2.079	2.397	2.759	3.172	3.642	4.177

Хүүгийн хүү тооцох



Хорогдуулах коэффициент



ӨҮЦ-ийн энгийн жишээ

2-р асуулт

Хорогдуулах хувь 10% байхад 10 жилийн дараа бидэнд төлөх \$100-ын Өнөөгийн үнэ цэнэ (ӨҮЦ) ямар байх вэ?

Эхлээд– Асуултыг дараахь байдлаар хуваа:

ӨҮЦ = \$100
Хүү = 10%
Хугацаа = 10 жил

Өнөөгийн үнэ цэнийн хүүгийн коэффициентын хүснэгт

Хугацаа/ Хүүгийн хувь	1%	2%	3%	4%	5%	6%	7%	8%	9%	10%	11%	12%	13%	14%	15%	16%
1	0.99	0.9803	0.9706	0.9615	0.9523	0.9433	0.9345	0.9259	0.9174	0.909	0.9009	0.8928	0.8849	0.8771	0.8695	0.862
2	0.9802	0.9611	0.9425	0.9245	0.907	0.8899	0.8734	0.8573	0.8416	0.8264	0.8116	0.7971	0.7831	0.7694	0.7561	0.7431
3	0.9705	0.9423	0.9151	0.8889	0.8638	0.8396	0.8162	0.7938	0.7721	0.7513	0.7311	0.7117	0.693	0.6749	0.6575	0.6406
4	0.9609	0.9238	0.8884	0.8548	0.8227	0.792	0.7628	0.735	0.7084	0.683	0.6587	0.6355	0.6133	0.592	0.5717	0.5522
5	0.9514	0.9057	0.8626	0.8219	0.7835	0.7472	0.7129	0.6805	0.6499	0.6209	0.5934	0.5674	0.5427	0.5193	0.4971	0.4761
6	0.942	0.8879	0.8374	0.7903	0.7462	0.7049	0.6663	0.6301	0.5962	0.5644	0.5346	0.5066	0.4803	0.4555	0.4323	0.4104
7	0.9327	0.8705	0.813	0.7599	0.7106	0.665	0.6227	0.5834	0.547	0.5131	0.4816	0.4523	0.425	0.3996	0.3759	0.3538
8	0.9234	0.8534	0.7894	0.7306	0.6768	0.6274	0.582	0.5402	0.5018	0.4665	0.4339	0.4038	0.3761	0.3505	0.3269	0.305
9	0.9143	0.8367	0.7664	0.7025	0.6446	0.5918	0.5439	0.5002	0.4604	0.424	0.3909	0.3606	0.3328	0.3075	0.2842	0.2629
10	0.9052	0.8203	0.744	0.6755	0.6139	0.5583	0.5083	0.4631	0.4224	0.3855	0.3521	0.3219	0.2945	0.2697	0.2471	0.2266
11	0.8963	0.8042	0.7224	0.6495	0.5846	0.5267	0.475	0.4288	0.3875	0.3504	0.3172	0.2874	0.2606	0.2366	0.2149	0.1954
12	0.8874	0.7884	0.7013	0.6245	0.5568	0.4969	0.444	0.3971	0.3555	0.3186	0.2858	0.2566	0.2307	0.2075	0.1869	0.1684
13	0.8786	0.773	0.6809	0.6005	0.5303	0.4688	0.4149	0.3676	0.3261	0.2896	0.2575	0.2291	0.2041	0.182	0.1625	0.1452
14	0.8699	0.7578	0.6611	0.5744	0.505	0.4423	0.3878	0.3404	0.2992	0.2633	0.2319	0.2046	0.1806	0.1597	0.1413	0.1251
15	0.8613	0.743	0.6418	0.5552	0.481	0.4172	0.3624	0.3152	0.2745	0.2393	0.209	0.1826	0.1598	0.14	0.1228	0.1079
16	0.8528	0.7284	0.6231	0.5339	0.4581	0.3936	0.3387	0.2918	0.2518	0.2176	0.1882	0.1631	0.1414	0.1228	0.1068	0.093
17	0.8443	0.7141	0.605	0.5133	0.4362	0.3713	0.3165	0.2702	0.231	0.1978	0.1696	0.1456	0.1252	0.1077	0.0929	0.0802
18	0.836	0.7001	0.5873	0.4936	0.4155	0.3503	0.2958	0.2502	0.2119	0.1798	0.1528	0.13	0.1108	0.0945	0.0806	0.0691
19	0.8277	0.6854	0.5702	0.4746	0.3957	0.3305	0.2765	0.2317	0.1944	0.1635	0.1376	0.1161	0.098	0.0829	0.0702	0.0596
20	0.8195	0.6729	0.5538	0.4553	0.3768	0.3118	0.2584	0.2145	0.1784	0.1485	0.124	0.1036	0.0867	0.0727	0.0611	0.0513
21	0.8114	0.6597	0.5375	0.4388	0.3589	0.2941	0.2415	0.1986	0.1636	0.1351	0.1117	0.0925	0.0767	0.0638	0.0531	0.0442
22	0.8033	0.6468	0.5218	0.4219	0.3418	0.2775	0.2257	0.1839	0.1501	0.1228	0.1006	0.0826	0.0679	0.0559	0.0461	0.0381
23	0.7954	0.6341	0.5066	0.4057	0.3255	0.2617	0.2109	0.1703	0.1377	0.1116	0.0906	0.0737	0.0601	0.0491	0.0401	0.0329
24	0.7875	0.6217	0.4919	0.3901	0.31	0.2469	0.1971	0.1576	0.1264	0.1015	0.0817	0.0658	0.0532	0.043	0.0349	0.0283
25	0.7797	0.6095	0.4776	0.3751	0.2953	0.2329	0.1842	0.146	0.1159	0.0922	0.0736	0.0588	0.0471	0.0377	0.0303	0.0244
26	0.7722	0.5975	0.4638	0.3606	0.2812	0.2198	0.1721	0.1352	0.1063	0.0839	0.0663	0.0525	0.0416	0.0331	0.0264	0.021
27	0.7644	0.5858	0.4501	0.3468	0.2678	0.2073	0.1609	0.1251	0.0976	0.0762	0.0597	0.0468	0.0368	0.029	0.0229	0.0181
28	0.7568	0.5743	0.437	0.3334	0.255	0.1956	0.1504	0.1159	0.0895	0.0693	0.0538	0.0418	0.0326	0.0255	0.0199	0.0156
29	0.7493	0.5631	0.4243	0.3206	0.2429	0.1845	0.1405	0.1073	0.0821	0.063	0.0484	0.0373	0.0288	0.0223	0.0173	0.0135
30	0.7419	0.552	0.4119	0.3083	0.2313	0.1741	0.1313	0.0993	0.0753	0.0573	0.0436	0.0333	0.0255	0.0196	0.0151	0.0116

Өнөөгийн үнэ цэнэ – жишээ /үргэлжлэл/

$$FV \times \frac{1}{(1+r)^n} = PV$$

$$\$100 \times \frac{1}{(1+.10)^{10}} = \$38.60$$


Хорогдуулах коэффициент = 0.386

Дээрх хүснэгтээс харвал 10 жилийн 10% = 0.386

Капиталын өртөг

- Таамаглахад хэцүү
- Бага зэргийн өөрчлөлт ч тооцоолж гаргах үнэ цэнэд их хэмжээгээр нөлөөлж болзошгүй
- Хорогдуулах коэффициент / Шаардагдах өгөөжийн хувь / Хүлээгдэж буй өгөөжийн хувь

МУХТ үнэлгээний онол



Компанийн үнэ

- Аливаа юмны үнэ = Хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн урсгалын ӨҮЦ
- Компани → Чөлөөт мөнгөн урсгалыг ашиглах

Хүү, татварын өмнөх ашиг
+ Элэгдэл
- Татвар
- Δ Цэвэр эргэлтийн хөрөнгө
- Капитал хөрөнгө оруулалт
Чөлөөт мөнгөн урсгал

МУХТ аргын жишээ

- МУХТ аргыг хэрэглэхийн тулд дараах зүйлийг харгалзах нь зүйтэй:
 - Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаарх ойлголт
 - Бизнесийн “чөлөөт мөнгөн урсгал” – зээлдэгч болон хувьцаа эзэмшигчдийг оруулан бүх хөрөнгө оруулагчдад очих, үйл ажиллагаанаас олсон, татвар ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дараах бэлэн мөнгө
 - Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь

МУХТ аргачлалын томъёо

$$PV_0 = \sum_{t=1}^n \left[\frac{E_t(CF_t)}{(1+r_t)^t} + \frac{E_t(TV_T)}{(1+r_T)^T} \right]$$

PV_0 = компанийн 0 цаг үе дэх үнэ

$E_t(*)$ = *-ийн t цаг үе дэх хүлээгдэж буй үр дүн бөгөөд энэ нь t цаг үед байгаа мэдээллээс хамаарна

CF_t = t цаг үед компанийн хувьцаа эзэмшигчдэд тараагдах мөнгөн урсгал

r_t = компанийн өөрийн хөрөнгийн өгөөжийн шаардагдаж буй хувь бөгөөд үүнийг t цаг үеийн мөнгөн урсгалыг 0 цаг үе хүртэл хорогдуулахад ашиглана

Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэлгээг гаргах: Төсөл В

Жил 0	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4	Жил 5
	\$ 150	\$ 300	\$ 450	\$ 600	\$ 1,875
	x	x	x	x	x
	0.909	0.826	0.751	0.683	0.621
\$136.35					
\$247.80					
\$337.95					
\$409.80					
\$1,164.38					
\$2,296.28					

Мөнгөн урсгалын нийт үнэлгээ

МУХТ аргын жишээ (үргэлжлэл)

Жил	Чөлөөт мөнгөн урсгал, сая \$	Хорогдуулах коэффициент, 30%	Өнөөгийн үнэ цэнэ, сая \$
2001	10.0	$1/1.3 = 0.77$	7.70
2002	15.0	$1/(1.3)^2 = 0.59$	8.85
2003	16.0	$1/(1.3)^3 = 0.46$	7.36
2004	16.0	$1/(1.3)^4 = 0.35$	5.60
2005	17.0	$1/(1.3)^5 = 0.27$	4.59
Өнөөгийн цэвэр үнэ			34.1
2005*	$17 \times 1/0.3 = 56.7$	$1/(1.3)^5 = 0.27$	
“Хугацааны эцэс дэх” үнэ			15.3
БИЗНЕСИЙН НИЙТ ҮНЭ			49.4
ӨР			<10.0>
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭ			39.4

*Үндэслэл: бизнес цаанид үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, мөнгөн урсгал нь хэвээр байна

Ашигт үндэслэсэн аргууд

- Үндсэн санаа нь тухайн компанийг үнэлэхдээ бусад компанийн харьцааг хэрэглэхэд оршино.
- Y/A, Y/B, Y/C зэрэг төрөл бүрийн үржигдэхүүнийг ашиглана.
- Ашиг гэдэгт ихэвчлэн хүү, татварын өмнөх ашгийг ойлгодог, гэхдээ хүү, татвар ба элэгдлийн өмнөх ашгийг мөн ашигладаг.
- Утга учиртай болохын тулд хооронд нь харьцуулж болохуйц нягтлан бодох бүртгэлийн бодлого шаардагдана.
- “Харьцуулж болохуйц” үйлдвэрүүдийг олох нь үргэлж субъектив байдаг.

Хөрөнгөнд үндэслэсэн аргууд

- Хөрөнгийн үнэлгээг хийхдээ ерөнхийдөө удирдлагын бий болгосон үнэ эсвэл хөрөнгийг ашиглах үнийг (тухайлбал, бист бус хөрөнгө) тооцдоггүй.
- Ерөнхий үнийг гаргах бөгөөд бусад үнэлгээг түүнтэй харьцуулах.
- Үндсэн 3 арга байдаг. Үүнд:
 - Дансны үнэ – нягтлан бодох бүртгэлийн тоо – банкыг үнэлэхэд хэрэгтэй болдог.
 - Борлуулалтын цэвэр үнэ буюу хөрөнгө тур бүрийг зарах үнэ (хөрөнгийг нэг бүрчлэн худалдах үнэ) – дампуурах тохиолдолд ашиглах бөгөөд энэ нь худалдагчийн хүлээн зөвшөөрөх хамгийн дотоод үнэ болно.
 - Нөхөн солих өртөг – “зах зээлд нэвтрэх” үнийг тооцоолоход хэрэгтэй болдог ба хөрөнгө оруулагчид үнийн ойлголт өгөх эхлэл болно.
- МУХТ, ногдол ангийн өгөөж, ашиг зэрэгт үндэслэсэн бусад аргууд удирдлагын бий болгосон үнийг заавал тооцдог.

Эдийн засгийн үнийг нэмэгдүүх (ЭЗҮН)

- Хувьцаа эзэмшигчийн баялаг дараах тохиолдолд бий болно. Үүнд:

$$(IRR - CC) \times \text{хөрөнгө оруулалт} = NPV > 0$$

Салбарын онцлогоос хамаарах үнэлгээний аргууд

- Эдгээр арга нь ихэвчлэн урьд өмнө үнэ цэнэ бий болгож байсан үзүүлэлтүүдийн хэлбэрээр хэрэглэгддэг.
- Жишээ:
 - Зочид буудал, агаарын тээврийн ашиглалтын хувь
 - Цахилгаан холбоо, кабелийн компани, нийтийн аж ахуйн хувьд холболтын хувь буюу хэрэглэгчдийн тоо

Хийн хангамжийн компани – Үнэлгээний жишээ

- Баруун Европд олон улсын компаниудын хэрэглэгч бүрт төлөх үнэ \$ 1,200
- Худалдан авах чадвар↓ уур амьсгал↑ зэрэгт тохируулга хийх \$ <200>
- Румыны улс орны эрсдэлд тохируулга хийх \$ <300>

- Хэрэглэгч бүрт ногдох үнэлгээний үнэ \$ 700
- Холбогдсон хэрэглэгчдийн тоо 50,000
- Хийн хангамжийн компанийн үнэ \$ 700 x 50,000
\$ 35 сая

Хувийн компанийн өөрийн хөрөнгийг бий болгох процесс

Хувийн компанийн өөрийн хөрөнгийг бий болгох процесс

- Процесс байна!
- Дүрэм журам байна.
- Итгэл бол бүх юм.

1 үе шат - Стратеги

- Сайтар бодож тунгаасан, сайтар танилцуулсан стратегийг боловсруулах.
- Судалгааны мэдээллийг бүрдүүлж, ирээдүйн тооцоо гаргах үндэс болгон ашиглах.
- Янз бүрийн хувилбарыг бэлтгэх.
- Хэтийн харааг бодит байдалтай тэнцвэржүүлэх.
- “Стратегийн төлөвлөгөө” болгон баримтжуулах.

2-р үе шат – Мэдээллийн меморандумыг бэлтгэх

- Хөрөнгө оруулагчдад зориулан бэлтгэсэн гол танилцуулах баримт бичиг юм. Энэ нь бизнесийн төлөвлөгөөтэй адилгүй.
 - Компанийн түүх, стратеги;
 - Зах зээл, салбарын динамик;
 - Санхүүгийн таамаглал ба санхүүжилтын шаардлага;
 - Хөрөнгө оруулалтын боломж ба холбогдох эрсдлүүд;
 - Компанийн зохион байгуулалт, үйл ажиллагаа.
- Мэдээллийн меморандумыг тухайн салбарын хүлээн зөвшөөрөгдсөн загварын дагуу бичнэ.
- Зөвхөн “Нууцыг хадгалах тухай гэрээ”-нд гарын үсэг зурсан хөрөнгө оруулагчдад тараана.

3-р үе шат – Хөрөнгө оруулагчдийг сонгох

- Боломжийн буюу хүсэн хүлээж буй хөрөнгө оруулагчийн төрлийг тодорхойлох:
 - “Санхүүгийн хөрөнгө оруулагч”
 - Тэнгэрийн сахиус хэмээн нэрлэгдэх хөрөнгө оруулагч
 - Аз турших капиталын сангууд
 - Хувийн хөрөнгө оруулалтын сангууд
 - Олон улсын байгууллагууд (ОУСК, ЕСББ, ЕХОБ)
 - “Стратегийн хөрөнгө оруулагч”
 - Цаашид өсч өргөжих сонирхолтой, адил бизнес эрхэлж буй компаниуд.
 - Нэмэлт бизнестэй болох сонирхолтой, ижил төстэй бизнес эрхэлж буй компаниуд.

4-р үе шат – Хөрөнгө оруулагчдад танилцуулах

- Бизнес эрхлэгч дараах зүйл хийх шаардлагатай. Үүнд:
 - Стратегийг маш сайн танилцуулах.
 - Бэлтгэл хийсэн байх; үндсэн баримт, тоо болон бусад мэдээллийг цэвэрлэсэн байх.
 - Санхүүгийн таамаглал ба санхүүжилтын шаардлагыг сайн мэдэж байх.
 - Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын хугацааны эцэст компаниас хэрхэн гарах арга замыг танилцуулах (ОНАСБ, цаг хугацааны явцад компани өөрөө худалдан авах, компанийг стратегийн хөрөнгө оруулагчид худалдах г.м.).
 - Компанийн талаарх байж болох бүх асуултад хариулт өгөхөд бэлэн байх.

5-р үе шат – Хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийх

- Хэлэлцэх гол асуудлууд:
 - Компанийн үнэлгээ
 - Хөрөнгө оруулагч компанийн хэдэн хувийг бэлэн мөнгөөр авах эсэх?
 - Хувьцаа эзэмшигчдийн эрх (ялангуяа цөөнхийн эрх).
 - Үйл ажиллагааны зорилтуудыг үндэслэн удирдлагын зүгээс эзэмшиж буй хувьцааны тоог нэмэгдүүлэх эрмэлзэл.
 - Компанид байх өрийн хэмжээ.

Өрсөлдөөнтэй орчин бүрдүүлэх.

- Сонирхол илэрхийлэх тохиолдолд – хөрөнгө оруулагч “Term Sheet” гаргана.

6-р үе шат – Хэлцлийн бүтцийг тодорхойлох

- Дараах зүйлийг харгалзах нь зүйтэй. Үүнд:
 - Өр, өөрийн хөрөнгийг урт хугацаанд хамгийн тохиромжтой байдлаар хослуулах;
 - Зээлийн хүүгийн өнөөгийн хувь;
 - Шаардагдаж буй хэмжээ;
 - Лизинг байгаа эсэх;
 - Байгаа хөрөнгө, санхүүжилт ба амьдрал дээр харгалзах зүйлүүд.
- Хэлцлийн бүтцийг урьдчилсан байдлаар тодорхойлох.

7-р үе шат – Хөрөнгө оруулагчдын иж бүрэн судалгаа

- Хувийн компанид хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагч барьцаа болон бусад баталгаагүй байдаг тул хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө хамаагүй их хэмжээний “мөрдөн байцаалтын ажил” хийх шаардлагатай болдог.
- Хөрөнгө оруулагч ерөнхийдөө “Таван том” гэж нэрлэгдэх зөвлөгөөний компаниудын аль нэгийг эсвэл томоохон хуулийн нүүсийг гэрээгээр ажиллуулж нарийн судалгаа, тусгай шалгалтын ажлуудыг гүйцэтгүүлдэг.
- Үүнд:
 - Санхүүгийн тайлан тэнцлүүдийг ОУНББС-ын дагуу аудитаар баталгаажуулах.
 - Биет хөрөнгийг шалгах.
 - Хууль эрх зүйн бүх асуудлыг хянан үзэх.

8-р үе шат – Хөрөнгө оруулалтын ажиллагааг дуусгавар болгох

- Төлбөр хийнэ, хувьцааны өмчлөлд өөрчлөлт оруулна, хуульчид эдгээр өөрчлөлт болон ирээдүйн үйл ажиллагааг зохицуулах гэрээний төслийг боловсруулна.
- Дараах түгээмэл гэрээг байгуулна. Үүнд:
 - Хувьцааг худалдан авах гэрээ.
 - Хувьцаа эзэмшигчдийн гэрээ.

Хэлэлцээр урт удаан хугацаанд үргэлжилж болзошгүй! Энэ үе шатанд процессийг хянаж байх нь чухал болно.

Эрх зүй, зохицуулалт ба хяналтын асуудлууд

- Баримт бичиг
- Хувьцаа нь олон нийтэд арилжаалагдаж буй компани
- Санхүүгийн туслалцаа болон зохицуулалтын бусад асуудал
- Хяналт

Хөрөнгө оруулагчийн сэтгэхүй

- Хөрөнгө оруулагч компанийн хувийг эзэмшиж, эрсдлийг хуваалцах тул дараах зүйлийг хүснэ. Үүнд:
 - ИТГЭЛЦЭЛ
 - ИЛ ТОД БАЙДАЛ

“Экономист” сэтгүүл 2001 оны 2-р сарын дугаартаа Оросын компаниудын хувьцаа нь ил тод байдал болон компанийн удирдлагатай холбоотой бусад хүндрэлийн улмаас 58 тэрбум ам. доллараар дутуу үнэлэгдсэн байна гэж мэдээлжээ.”

Хөрөнгө оруулагчдийн зүгээс харгалзан үзэх гол шалгуур:

- Удирдлага.
 - Алсын хараа, зоригтой, шийдэмгий байх.
 - Үүрэг хариуцлагын хуваарилалт тооцоотой, жинхэнэ багийн сэтгэлгээ, идэвхтэй байх.
 - Нээлттэй, ил тод байх
- Цаашид өсч өргөжих ирээдүйтэй байх.
- Их хэмжээний өгөөж олох боломж, “гарц”-ын хувьд сайн төлөвлөгөөтэй байх (жишээлбэл, зах зээлд давамгайлах байр суурьтай болох).
- Сайн бэлтгэгдсэн баримт бичиг, санхүүгийн тайлантай байх.

Хөрөнгө оруулагчид “бизнесийг дэмжигч” засгийн газартай хамтран ажиллах сонирхолтой байдаг

- Эрх зүйн зохицуулалтын тааламжтай, тогтсон орчин
 - Бизнес эрхлэхэд тааламжтай
 - Хөрөнгө оруулагчдын эрхийг хүндэтгэн баталгаажуулсан
 - ОУНББС болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад хуулийг мөрддөг
 - Компанийн удирдлага, ил тод байдлыг хангасан
- Зөвхөн ийм орчин бүрдсэн тохиолдолд л эдийн засгийн өсөлтийн тогтвортой хувь хэмжээнд хүрч чадна.

Засгийн газар /үргэлжлэл/

- Эдийн засаг, эрх зүйн зохицуулалтын шинэтгэл хэзээ ч хялбар байдаггүй –хүсэл эрмэлзэл байна, ахиц гарна гэдэгт хөрөнгө оруулагч итгэлтэй байх шаардлагатай
- Алсын хараатай байх
- Зохицуулалтыг хэтрүүлэхгүй байх
- Дампуурлын хууль
- Улс орны хүний нөөцийг хөгжүүлэх
 - Дэлхий нийтийн эдийн засгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулахад бизнес эрхлэгчдийг бэлтгэх талаар байнга шинэтгэл хийж ажиллах
 - Сургалт

Засгийн газар /үргэлжлэл/

- Татвар
- Хүнд суртал
- “Stampole Hell” (байнга тамга шаардах хүнд суртлыг хэлнэ)
- Бизнесийн лицензи
- Харилцаа холбоо
 - Менежментийн өртгийг бууруулах үүднээс э-засаглалыг нэвтрүүлэх
 - “Leapfrog” арга (нэг юмнаас нөгөө юм руу үсрэхийг хэлнэ)

Засгийн газар /үргэлжлэл/

- Хөрөнгө оруулагчдад “дэлхий нийтийн” сэтгэхүйтэй гэдгээ харуулах
- АМЖИЛТ гаргах
- АМЖИЛТ АМЖИЛТ-анд хүргэдэг!

ХАВСРАЛТ Ж: ҮГСИЙН ТҮҮВЭР

ХАВСРАЛТ Ж: ҮГСИЙН ТҮҮВЭР

А

"А" үе шат - урьд өмнө үүсгэн байгуулагч болон / буюу ивээн тэтгэгчдээс санхүүжиж байсан, эрчимтэй өсч буй компанид азаа туршиж буй хөрөнгө оруулагчид оролцож эхлэх санхүүжилтийн үе шат.

Бусад төрлийн хөрөнгийн ангилал - нийтэд арилжаалагдаж буй үнэт цаасыг оруулахгүйгээр хувийн компанийн эзэмшигчийн өмч, үл хөдлөх хөрөнгө, газрын тос ба байгалийн хий зэргийг багтаасан хөрөнгө оруулалтын ангилал. Тэтгэврийн сан, дээд сургуулиудын тусламжийн сан болон бусад харьцангуй том байгууллагын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтынхаа багцыг төрөлжүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын тодорхой хувийг бусад төрлийн хөрөнгөд ихэвчлэн оруулдаг юм.

Ивээн тэтгэгч - дөнгөж үүсгэн байгуулагдаж буй компанид хөрөнгө оруулдаг этгээд. Ивээн тэтгэгчид шинээр байгуулагдаж буй нэг компанид ихэвчлэн саяаас доош хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг. Ивээн тэтгэгчээс санхүүжүүлэх шинээр байгуулагдаж буй компани нь ерөнхийдөө төслийн эсвэл бүтээгдэхүүнээ зохион бүтээх шатанд байдаг.

Хувьцааны тоог нэмэгдүүлэхийн эсрэг заалт - гэж компани нэмэлт хувьцаа гаргаж бусад аж ахуйн нэгжид тараасны улмаас хөрөнгө оруулагчийн тухайн компанид эзэмшиж буй хувь их хэмжээгээр буурах явдлаас хөрөнгө оруулагчийг хамгаалах гэрээний заалтыг хэлнэ. Тохируулга хийх механизмыг "ratchet" гэж нэрлэдэг.

В

"Б" үе шат – "А" үе шатны санхүүжилтийн дараа мэргэжлийн хөрөнгө оруулагчид, түүнчлэн азаа туршиж буй хөрөнгөтнүүд тухайн компанид нэмэлт хөрөнгө оруулалт хийхийн тулд хангалттай сонирхол илэрхийлж эхлэх санхүүжилтийн үе шат. Дараахь үе шатуудыг "В", "Г" гэх мэтчилэн нэрлэдэг.

Дээд зэргийн хүчин чармайлт - хөрөнгө оруулалтын банкуудын синдикатын зүгээс компаниас санал болгож буй үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад багтай борлуулах талаар дээд зэргийн хүчин чармайлт гаргах хүсэл эрмэлзэл. Дээд зэргийн хүчин чармайлт гаргах хүсэл эрмэлзэлтэй байгаа синдикат хувьцаа эсвэл бондын тодорхой тоо хэмжээний хувьд ямар нэгэн хатуу амлалт гаргахаас зайлсхийдэг.

Бета - зах зээл дээр албан ёсоор гаргахаас өмнө ирээдүйн худалдан авагчдаар туршуулж буй бүтээгдэхүүн.

Компанид эзэмших хувийг бууруулах санхүүжилтийн үе шат - шинээр үүсгэн байгуулагдаж буй компаниас өмнөх хөрөнгө оруулагчдийн эзэмшиж буй хувийг их хэмжээгээр бууруулах ("шингэлэх")-ад хангалттай тооны шинэ хувьцаа гаргах бодит нөхцөл бүрдүүлэх заалтыг их хэмжээний хөрөнгөтэй шинэ хөрөнгө оруулагчид гэрээнд шаардаж оруулах боломжийг хангасан санхүүжилтийн үйл явдал.

Удирдах зөвлөл - гэж компанийн амжилт болон зохистой удирдлагыг хангах төлөөллийн хариуцлага хүлээсэн бүлэг хувь хүмүүсийг хэлэх бөгөөд энэ бүлэгт ихэвчлэн захирлууд, хөрөнгө оруулагчид ба шинжээчид багтдаг. Удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчид сонгодог.

Бархаг - компанийн өсөлтөд саад учруулж буй этгээд, төсөл эсвэл үйл ажиллагаа.

Дансны бүртгэл - Хувьцааг тодорхой байгууллагуудад борлуулах меморандумын тодорхойлолтыг харна уу.

Өөрөө өөрийгөө тэтгэх - гэж шинээр үүсгэн байгуулагдаж буй компанийн зүгээс зардлаа багасгаж, мөнгөн хуримтлал бий болгож, улмаар гаднаас хөрөнгө оруулах хэрэгцээг бууруулах буюу арилгахад чиглэгдсэн арга хэмжээ авах явдлыг хэлнэ.

"Гүүр" санхүүжилт - гэж түр зуурын санхүүжилтийг хэлэх бөгөөд үүнийг цаашид компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагч ба зээлдүүлэгчдээс авах байнгын санхүүжилтээр солино. Аз турших буюу эрсдэлтэй хөрөнгийн хувьд цаашид давуу эрхтэй хувьцаанд хөрвөх 6-гаас 12 сарын богино хугацаатай үнэт цаас ихэвчлэн "гүүр" болно. Ихэнх тохиолдолд "гүүр" олгож буй этгээд үнэт цаасыг давуу эрхтэй хувьцааны санхүүжилтийн дараах үе шатны үнээс 20 хувиар доогуур үнээр давуу эрхтэй хувьцаанд шилжүүлэх эрхтэй байдаг.

Шаталтын хувь - бага орлоготой буюу орлогүй байгаа шинээр үүсгэн байгуулагдаж буй компани мөнгөн хадгаламжаараа зардлаа нөхөж буй хувь хэмжээ. Энэ хувь хэмжээг ихэвчлэн сар эсвэл долоо хоног бүр илэрхийлдэг.

Бизнесийн төлөвлөгөө - бизнесийн боломжийн шинэ үзэл баримтлалыг тодорхойлж буй баримт бичиг. Бизнесийн төлөвлөгөө нь ерөнхийдөө хураангуй, зах зээлийн хэрэгцээ, шийдэл, технологи, өрсөлдөөн, маркетинг, удирдлага, үйл ажиллагаа болон санхүүгийн дүн шинжилгээ зэрэг бүлгээс бүрддэг.

Компанийг худалдан авах явдал - гэж хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх салбарын нэг хэсгийг хэлнэ. Үүнээс гадна компанийн хяналтын багцыг гадны хөрөнгө оруулагч (зээлээр санхүүжих худалдан авалт) эсвэл удирдлагын баг (удирдлагын худалдан авалт) худалдан авах явдлыг хэлнэ.

Худалдан авах-худалдах гэрээ - гэж хувьцаа эзэмшигчээс хувьцаагаа компаниас гадуурх бусад аж ахуйн нэгжид санал болгохоосоо өмнө компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгохыг шаардсан нөхцлийг тусгасан гэрээг хэлнэ.

С

Хөрөнгө гаргах шаардлага - гэж компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сангийн менежер (ихэнх тохиолдолд түншлэлийн ерөнхий түнш) санд оролцож буй хөрөнгө оруулагчаас (хязгаарлагдмал хариуцлагатай түнш) нэмэлт хөрөнгө гаргахыг шаардах явдлыг хэлнэ. Хязгаарлагдмал хариуцлагатай түнш ихэвчлэн хөрөнгө оруулалтынхаа дээд хэмжээг тодорхойлдог. Ерөнхий түнш компани шинээр байгуулах эсвэл худалдаж авахад санхүүжилт хийх боломж гарах үед хязгаарлагдмал хариуцлагатай түншид хөрөнгө гаргах шаардлага тавьдаг.

Хөрөнгөжүүлэлтийн хүснэгт - гэж компанийн хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшиж буй хувь хэмжээг харуулсан хүснэгтийг хэлнэ. Үүнээс гадна уг хүснэгтээр энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа, баталгаа, "опцион" зэрэг өмчлөлийн хэлбэрийг харуулдаг.

Олз - хөрөнгө худалдан авах буюу худалдахад үнийн зөрүүгээс олох хөрөнгө оруулалтын ашгийн татварын ангилал. Ихэнх тохиолдолд хөрөнгө оруулагч хөрөнгө

оруулалтын ашгийг урт хугацааны олз гэж ангилахыг хүсдэг. Учир нь ердийн орлоготой харьцуулбал олзод илүү бага хувиар татвар ногдуулдаг.

Хувьцаат хөрөнгө - хувьцааны зөвхөн нэг ангилал байх тохиолдолд хэрэглэх хувьцааны тодорхойлолт. Энэ ангилалыг энгийн хувьцаа гэж нэрлэдэг.

Хуримтлагдсан хүү - гэж компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сангийн ашгаас хүртэх хувийг хэлнэ. Ерөнхий түнш сангийн ашгаас хүртэхээс өмнө сан хязгаарлагдмал хариуцлагатай түншүүдийн оруулсан хөрөнгийг буцааж өгөх шаардлагатай. Дараа нь ерөнхий түнш 20 хувийн хуримтлагдсан хүү авдаг. Амжилттай үйл ажиллагаа явуулж буй зарим пүүсүүд 25%-30%-ийг авдаг. Мөн "хуримтлуулах" эсвэл "дэмжих" гэж нэрлэдэг.

Гүйцээж авах - компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сангийн ерөнхий түнш болон хязгаарлагдмал хариуцлагатай түншийн хооронд байгуулах гэрээний заалт. Хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд хүлээгдэж байсан өгөөжийнхөө ихэнх хэсгийг авсны дараагаар ерөнхий түнш урьд өмнө харилцан тохиролцсон ашгийн хуваарилалтын хэмжээг хүртэл ашгийн ихэнх хувийг авч болно.

Хяналтын эрх солигдсоны шагнал - компанийг тогтоосон үнээс дээгүүр үнээр худалдахаар амжилттай хэлэлцээр хийж чадвал компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийсэн этгээдүүдээс удирдлагын багын гишүүдэд бэлэн мөнгөөр эсвэл хувьцаагаар өгөх шагнал.

Эргүүлж авах - компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх сангийн ерөнхий түнш болон хязгаарлагдмал хариуцлагатай түншийн хооронд байгуулах гэрээний заалт. Энэ заалтын дагуу хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд хөрөнгө оруулалтын багц дахь урьд өмнөх хөрөнгө оруулалтын их хэмжээний алдагдлыг үндэслэн ерөнхий түншид ногдох хуваарилалтаас тодорхой хэсгийг ашигтай хөрөнгө оруулалтад зориулан эргүүлж авах эрх эдэлнэ.

Дуусгавар болгох - гэж шаардлагатай бүх эрх зүйн баримт бичигт гарын үсэг зурж, хөрөнгийг шилжүүлж, санхүүжилтийн үе шатыг дуусгавар болгохыг хэлнэ.

Барьцаа - зээлийг гүйцэд төлж барагдуулах хүртэл зээлдүүлэгчийн эрх мэдэлд байх зээлдэгчийн үл хөдлөх хөрөнгө буюу тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгө.

Амлалт - хязгаарлагдмал хариуцлагатай түншийн зүгээс санд оруулах хөрөнгийн дээд хэмжээ.

Энгийн хувьцаа - компанийн хувь хөрөнгийг эзэмших эрхийг илэрхийлэх үнэт цаасны төрөл. Ихэнх тохиолдолд компанийн үүсгэн байгуулагчид, удирдлагын гишүүд болон ажилтнууд энгийн хувьцаа эзэмшдэг харин хөрөнгө оруулагчид давуу эрхтэй хувьцаа эзэмшдэг юм. Компанийг татан буулгах тохиолдолд баталгаатай ба баталгаагүй зээлдүүлэгч, бонд эзэмшигч болон давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэхэмжлийг энгийн хувьцаа эзэмшигчийнхээс өмнө эхэлж барагдуулна.

Харьцуулахуйц компани - гэж үнэлэгдэж буй хувийн компанитай ижил төстэй үзүүлэлттэй нийтэд арилжаалагдаж буй компанийг хэлнэ. Жишээлбэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг, орлогоосоо 2 дахин их зах зээлийн үнэлгээтэй компанийг тухайн салбарт шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж буй ижил төстэй харьцангуй шинэ компанийн үнийг тодорхойлоход ашиглаж болох юм. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хямдралын тодорхойлолтыг харна уу.

Хяналтын эрх - гэж компанийн өөрийн хөрөнгийн 50-иас дээш хувийг эсвэл бусад хувьцаа эзэмшигчидтэй харьцуулбал хамгийн том багц хувьцааг эзэмшиж буй хувь хүн буюу хуулийн этгээдийн эрх мэдлийг хэлнэ.

Нэгтгэл - Rollup-ын тодорхойлолтыг харна уу.

Шилжих эрх - эзэмшиж буй давуу эрхтэй хувьцаагаа эсвэл олгосон зээлээ урьдчилан тохирсон шилжүүлэх харьцаагаар энгийн хувьцаагаар солих шаардлагыг компанид тавих хөрөнгө оруулагчийн буюу зээлдүүлэгчийн эрх.

Шилжих өр - зээлдэгч зээлийн өрийг урьдчилан тохирсон харьцаагаар компанийн энгийн хувьцаанд шилжүүлж болох нөхцөлтэй зээл.

Давуу эрхтэй шилжих хувьцаа - энгийн хувьцаанд шилжүүлэх эрх эзэмшигчид олгох хувьцааны төрөл. Давуу эрхтэй хувьцаа нь шийдвэр гаргах эрхтэй удирдлагын хяналт, хөрөнгө оруулалтын баталгаатай өгөөж, компанийг татан буулгах эсвэл худалдахаас олох орлогыг нэн тэргүүнд авах эрх зэрэг энгийн хувьцаанд байхгүй зарим эрх эдэлнэ. Давуу эрхтэй шилжих хувьцаа ерөнхийдөө компани хувьцаагаа нийтэд анх санал болгох үед шууд энгийн хувьцаанд шилждэг. Давуу эрхтэй шилжих хувьцаа нь хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалт хийх хамгийн түгээмэл хэрэгсэл юм.

Шилжих үнэт цаас - гэж урьдчилан тогтоосон харьцаагаар үнэт цаасыг компанийн энгийн хувьцаанд шилжүүлэх эрхийг эзэмшигчид олгож буй үнэт цаасыг хэлэх бөгөөд энэ нь ихэвчлэн давуу эрхтэй хувьцаа, баталгаа эсвэл өр байдаг.

Борлуулалтын өртөг - гэж компанийн үндсэн үйл ажиллагаанаас гарах зардлыг хэлнэ.

Эрх зүйн амлалт - аль нэг зүйлийг хийх эсвэл хийхгүй байх талаар гаргасан эрх зүйн амлалт. Жишээлбэл, санхүүжилтийн нөхцлийг тохиролцохдоо компанийн удирдлага нэмж зээл авахгүй байх талаар амлалт гаргадаг. Эрх зүйн заалтыг зөрчсөн тохиолдолд алдааг засч залруулахаас эхлээд компанийн хяналтыг алдах хүртэл шийтгэл хүлээдэг.

Доош нь дарах үе шат - Компанид эзэмших хувийг бууруулах санхүүжилтийн үе шатны тодорхойлолтыг харна уу.

Хуримтлагдсан ногдол ашиг - Давуу эрхтэй, хуримтлагдсан ногдол ашиг авах хувьцааны эзэмшигч нь аливаа бусад ангилалын хувьцаанд ногдол ашиг төлөгдөхөөс өмнө хуримтлагдсан (урьд өмнө төлөгдөөгүй) ногдол ашиг авах эрхтэй болно.

Эргэлтийн хөрөнгийн харьцаа - гэж эргэлтийн хөрөнгийг богино хугацаат өр төлбөртэй харьцуулсан харьцааг хэлнэ.

D

Судалгаанд хамрагдах компани - хөрөнгө оруулалтын сангийн тодорхой нэг хугацаанд судлаж үзэх хөрөнгө оруулалтын тоо хэмжээг илэрхийлэх хэмжүүр.

Өр барагдуулалт - зээлийн төлбөрийн хэмжээг тодорхой хугацаанд олсон мөнгөн гүйлгээтэй харьцуулсан харьцаа. Компани өр барагдуулалтын харьцааг тодорхой түвшинд хадгалж байх талаар зээлдүүлэгчийн зүгээс шаардлага тавьдаг. Зөрчсөн тохиолдолд компани зээлийг нэн даруй бүхэлд нь төлөх шийтгэл хүлээдэг.

Дефолт - гэж компани санхүүжилтийн гэрээний нөхцөл, болзлыг биелүүлэх чадваргүй болохыг хэлнэ.

Шаардлага тавих эрх - бүртгэлийн эрхийн нэг төрөл. Шинээр байгуулагдаж буй компанид хувьцаагаа ҮЦХ-нд бүртгүүлж, хувьцаагаа олон нийтэд санал болгох ажиллагаанд бэлтгэх шаардлага тавих эрхийг хөрөнгө оруулагчид олгодог.

Хувьцааны тоог нэмэгдүүлэх - гэж шинэ хөрөнгө оруулагчид шинэ хувьцаа гаргаж арилжаалсны улмаас өнөөгийн хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагч болон ажилтнуудын эзэмшиж буй хувь хэмжээ буурахыг хэлнэ.

Хувьцааны тоог нэмэгдүүлэхээс хамгаалах заалт - хувьцааны тоог нэмэгдүүлэхийн эсрэг заалт ба ратчетын тодорхойлолтыг харна уу.

Шууд зардал - борлуулалтын өртгийн тодорхойлолтыг харна уу.

Зарцуулалт - сангаас компанид оруулах хөрөнгө оруулалт.

Хорогдуулах хувь - ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход ашиглах хүүгийн хувь хэмжээ.

Хорогдуулсан мөнгөн гүйлгээ (ХМГ) - компанийн ирээдүйд олохоор төлөвлөж буй бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцох үнэлгээний аргачлал.

Хуваарилалт - гэж ерөнхий түншийн хөрөнгө оруулалт хийсэн багц компаниудын нэг буюу түүнээс олон компанийг худалдах, татан буулгах эсвэл хувьцааг нь нийтэд санал болгосны улмаас хязгаарлагдмал хариуцлагатай түншид үнэт цаас буюу бэлэн мөнгийг шилжүүлэхийг хэлнэ.

Ногдол ашиг - гэж компаниас үнэт цаас эзэмшигчдэд тогтмол төлөх төлбөрийг хэлнэ. Ногдол ашгийг ихэвчлэн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд улирал бүр төлдөг.

Буурах үе шат - өмнөх үе шатанд хөрөнгө оруулагчдийн тодорхойлсон үнээс компанийн өнөөгийн үнэлгээ доогуур байх санхүүжилтийн үе шат.

Шахан шаардах эрх - компанийн нэг хөрөнгө оруулагч бусад хөрөнгө оруулагчдийг тодорхой нэг арга хэмжээ авах, тухайлбал компанийг худалдах талаар шахаж шаардах гэрээгээр олгосон эрх.

Явуулын аз турших хөрөнгөтөн - гэж хөрөнгө оруулалтын багцад байгаа компанийн зөвхөн Удирдах зөвлөлийн хуралд оролцдог гэхдээ компанийн удирдлагад байнга оролцдоггүй аз турших хөрөнгө оруулагчийг хэлнэ.

Иж бүрэн судалгаа - гэж компанид оруулах хөрөнгө оруулалтын амьдрах чадварыг үнэлэх, тухайн компаниас өгсөн мэдээллийн үнэн зөвийг шалгах зорилгоор хөрөнгө оруулагчдийн зүгээх хийх судалгааны ажлыг хэлнэ.

Е

Түрүү үе шат - компанийн үрийн (үүсгэн байгуулалтын) үе шатны дараах гэхдээ дунд (орлого олж эхлэх) үе шатны өмнөх нөхцөл байдал. Ихэнх тохиолдолд хөгжлийн түрүү үе шатанд байгаа компани нь удирдлагын үндсэн баг болон батлагдсан үзэл баримтлал буюу бүтээгдэхүүнтэй боловч мөнгөн гүйлгээгүй байдаг.

Хүү болон татварын өмнөх ашиг (ХТӨА) - гэж компанийн үйл ажиллагааны ашгийг хэмжих хэлбэр. Үнэлгээний нэг аргачлалаар хувийн болон төрийн өмчийн компаниудын үнийг харьцуулах үндсэн дээр ХТӨА-ийн коэффициентыг тодорхойлдог.

Хүү, татвар, элэгдэл ба хорогдлын өмнөх ашиг (ХТЭХӨА) - компанийн мөнгөн гүйлгээг хэмжих хэлбэр. Үнэлгээний нэг аргачлалаар хувийн болон төрийн өмчийн компаниудын үнийг харьцуулах үндсэн дээр ХТЭХӨА-ийн коэффициентыг тодорхойлдог.

Цахилгаан шатанд явах хугацаанд багтах танилцуулга - бизнес эрхлэгч хөрөнгө оруулалтын боломжийн талаар ирээдүйн хөрөнгө оруулагчид зориулан хийх хэдхэн минут (цахилгаан шатаар явах хугацаанд) үргэлжлэх товч танилцуулга.

Компанийн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр (АХЭТ) - ажилтнуудад урт хугацааны урамшууллын нөхөн олговор олгох зорилгоор хувьцааг нөөцлөх компанийн төлөвлөгөө.

Өөрийн хөрөнгө - энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа буюу нэгж хувь хөрөнгөөр илэрхийлэгдэх компанийн өмчлөлийн бүтэц.

Өөрийн хөрөнгө = Хөрөнгө - Өр төлбөр

Мөнх ногоон сан - ирээдүйд хийх хөрөнгө оруулалтын хөрөнгийн эх үүсвэрийг хангах зорилгоор ашгаараа эргүүлж хөрөнгө оруулалт хийдэг сан.

Гарцын стратеги - компанийн эзэмшигч болон хөрөнгө оруулагчид ашиг оруулах төлөвлөгөө. Үүнд нэгдэх, зарагдах эсвэл хувьцааг нийтэд санал болгох зэрэг багтана.

Өргөжилтын үр шат - компани удирдлагын багаа бүрдүүлээд, орлогоо нилээд их хэмжээгээр нэмэгдүүлэн өргөжиж эхлэх үе шат.

F

Үнэн зөвийн талаарх санал - компанитай нэгдэх эсвэл компанийг худалдах хэлцэлд хэлэлцэж буй үнийн үнэн зөв шударга эсэхийг үнэ төлбөртэй үнэлдэг хөрөнгө оруулалтын банкнаас гаргасан захидал.

Хатуу амлалт - компанийн нийтэд худалдахаар санал болгож буй бүх хувьцааг худалдаж авах хөрөнгө оруулалтын банкуудын синдикатын амлалт. Синдикат дараа нь хувьцааг хөрөнгө оруулагчдад худалддаг.

Эргүүлэх - хувьцааг нийтэд анх санал болгосны дараа шууд худалдах явдал. Шинээр гаргаж буй хувьцааны арилжааг баталгаажуулдаг хөрөнгө оруулалтын банкууд хувьцааг нилээд хэдэн сарын туршид эзэмших хүсэлт илэрхийлсэн шинэ хөрөнгө оруулагчдад борлуулахыг эрмэлздэг. Ихэнх тохиолдолд нийтэд анх санал болгосон хувьцааг "зогсоох хугацаа" (ихэвчлэн 6-гаас 12 сар) дуусахаас өмнө зарахыг удирдлага болон азаа туршиж буй хөрөнгө оруулагчдад хориглодог.

Үүсгэн байгуулагч - компани байгуулах явцад оролцож буй этгээд. Ихэнх тохиолдолд үүсгэн байгуулагчид мэргэжлийн менежерүүдийг хөлслөхөд хангалттай хөрөнгө хуримтлуулах хүртлээ өөрсдөө компанийг удирддаг.

Найз, гэр бүлийн гишүүдийн санхүүжилт - хөгжлийн эртний үе шатанд байгаа компанийн үүсгэн байгуулагчдын найз нөхөд, гэр бүлийн гишүүдээс олгосон хөрөнгө.

Үүсгэн байгуулагчид компани амжилт олж эхлэх шатанд мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулахад саад учруулах өмчлөлийн бүтэц бий болгохгүй байх талаар анхаарах нь зүйтэй.

Бүрэн ратчет - гэж өмчлөлийн хувь хэмжээ буурахаас эсрэг хамгаалах хамгаалалтын механизмыг хэлэх бөгөөд түүний дагуу шинэ Б хөрөнгө оруулагчид шинэ давуу эрхтэй хувьцааг А хөрөнгө оруулагчид анх санал болгосон үнээс доогуур үнээр гаргасны улмаас А хөрөнгө оруулагчийн давуу эрхтэй хувьцааны үнийг бууруулах тохируулга хийдэг. А хөрөнгө оруулагчийн давуу эрхтэй хувьцааны үнийг Б хөрөнгө оруулагчийн давуу эрхтэй хувьцааны үнийн түвшинд хүргэхийн тулд дахин тогтоодог. Ратчет хэрэгжүүлсний үр дун энгийн хувьцааны тодорхой хувийг эзэмшиж буй удирдлагын гишүүд болон ажилтнуудын өмчлөлийн хувь нилээд хэмжээгээр буурдаг. Нарийн үндэслэлтэй жигнэсэн дундаж ратчет ба өргөн үндэслэлтэй жигнэсэн дундаж ратчетын тодорхойлолтыг харна уу.

Бүрэн шингэлсэн үндсэн дээр - гэж нэгж хувьцаанд ногдох харьцааг тооцох аргачлалыг хэлнэ. Үүнд компанийн (бүх баталгаа болон опционыг хэрэгжүүлсэн гэдэг үндсэн дээр) гаргасан нийт хувьцаа болон давуу эрхтэй хувьцаа нь хуваарь болдог.

Сангийн сан - компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх санд хөрөнгө оруулалт хийхээр байгуулагдсан санг хэлнэ. Ихэнх хувь хүмүүс болон харьцангуй бага байгууллагын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцынхаа удирдлагын зардлыг багасгах үүднээс сангийн санд оролцдог.

G

Ерөнхий түнш (ЕТ) - түншлэлд оролцож буй түншийн ангилалыг хэлнэ. Ерөнхий түнш нь түншлэлийн үйл ажиллагааны хариуцлагыг хүлээдэг. Хувийн хөрөнгө оруулалтын ертөнцөд ерөнхий түнш нь сангийн удирдагч болдог харин байгууллагын болон их хөрөнгөтэй хувийн хөрөнгө оруулагчид нь түншлэлийн хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд болдог. Ерөнхий түнш нь удирдлагын шимтгэл болон ашгийн тодорхой хувийг авдаг (хуримтлагдсан хүүгийн тодорхойлолтыг харна уу).

ЕТ - Ерөнхий түншийн тодорхойлолтыг харна уу.

Нэмэгдүүлэх - тодорхой цаг хугацааны дараа компанийн удирдлага болон ажилтнуудад очих хувьцааны тоог нэмэгдүүлэх тохируулга. Нэг буюу түүнээс олон тооны хөрөнгө оруулагчид компанийн харьцангуй их хувийг худалдан авсны дараа уг тохируулгыг хийдэг. Тохируулга хийхгүй бол компанийн удирдлага болон ажилтнууд нь хувьцааны тоог нэмэгдүүлж тэдгээрийн өмчлөлийн хувь хэмжээг бууруулснаас санхүүгийн ба сэтгэл зүйн дарамтанд орж, энэ нь компанийн ерөнхий үйл ажиллагаанд нөлөөлдөг.

Өсөлтийн үе шат - гэж нэг буюу түүнээс олон үе шатны санхүүжилт авч, бүтээгдэхүүн буюу үйлчилгээнээсээ орлого олж эхлэх үе шатыг хэлнэ. Мөн "дунд үе шат" гэж нэрлэдэг.

H

Ургац хураах - гэж хувийн компанийн эзэмшигчийн өмчид оруулсан хөрөнгө оруулалтын багц дахь компанийг худалдах эсвэл хувьцааг нь нийтэд анх санал болгох ажиллагаанаас бэлэн мөнгө буюу хувьцаа олохыг хэлнэ.

Хоккейны мод - гэж ирээдүйн аль нэг цэгт огцом өсөх орлого, худалдан авагчид, бэлэн мөнгө, буюу бусад зарим нэг санхүүгийн буюу үйл ажиллагааны хэмжүүрийг харуулсан графикийн ерөнхий хэлбэрийг хэлнэ. Ирээдүйн хөрөнгө оруулагчдийг татахын тулд бизнес эрхлэгчид "хоккейны мод" графиктай бизнесийн төлөвлөгөө боловсруулдаг.

Хорогдуулах хувь - хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын хийхээсээ өмнө шаардах өгөөжийн хамгийн доод хувь хэмжээ.

I

Инкубатор - шинээр үүсгэн байгуулагдаж буй компаниудад дэмжлэг үзүүлэх компани буюу байгууламжийг хэлнэ. Инкубатор нь харилцаа холбооны сүлжээгээр хангаж, үйл ажиллагааны хэрэгслэлийг хамтран ашиглах боломжоор хангах замаар өртөг зардлыг хянаж шинээр үүсгэн байгуулагдаж буй компаниудад туслалцаа үзүүлдэг.

Хувьцааг нийтэд анх санал болгох (ХНАСБ) - компанийн хувьцааг анх нийтэд санал болгох ажиллагаа. Олон нийтэд анх санал болгож буй хувьцааг Үнэт цаасны хороонд бүртгүүлэх шаардлагатай. Тодорхой амжилтанд хүрсэн шинээр үүсгэн байгуулагдсан компанийн хувьд цаашид өсөхийн тулд нэмэлт хөрөнгө татах аргуудын нэг болно.

Дотоод санхүүжилтийн үе - санхүүжилтийн өмнөх үе шатны хөрөнгө оруулагчид хэвээр үлдэж байгаа санхүүжилтийн үе шатыг хэлнэ. Энэ үе шатанд компанийн үнэлгээг гаднаас орж ирж буй шинэ хөрөнгө оруулагч буюу гуравдагч этгээдийн зүгээс шалгадаггүй учраас хариуцлагатай холбоотой асуудлууд гарч ирдэг. Үүнээс гадна инсайд раундын нөхцөл, болзлууд нь хувьцаа эзэмшигчдийн аль нэг бүлэглэлд дарамттай байх эсвэл хөрөнгө оруулагчид өөрсөддөө нэмэлт давуу эрх олгох тохиолдолд тэдгээрийг хувийн эрх ашигт зориулагдсан байна гэж үзэж болох юм.

Байгууллагын хөрөнгө оруулагч - компани болон хувь хүний өмнөөс хөрөнгө оруулалт хийдэг мэргэжлийн байгууллагыг хэлнэ. Жишээлбэл тэтгэврийн сан, даатгалын компани болон дээд сургуулиудын тусламжийн сан зэргийг дурьдаж болно.

Өгөөжийн хувь хэмжээ (ӨХХ) - ирээдүйд тодорхой үнэ цэнэд хүргэхийн өнөөдөр хийх хөрөнгө оруулалтаас олох хүүгийн хувь. Ихэвчлэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөнд ашигладаг. Ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн цэвэр үнэ цэнийг "0"-тэй тэнцүүлдэг хүүгийн хувь юм.

Хөрөнгө оруулалтын санаа / гүн ухаан - хөрөнгө оруулалтын сан санхүүгийн зорилтууддаа хүргэхийн тулд ямар төрлийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай вэ гэдгийг тодорхойлдог үндсэн санаанууд.

ХНАСБ - Хувьцааг нийтэд анх санал болгох ажиллагааны тодорхойлолтыг харна уу.

ӨХХ - өгөөжийн хувь хэмжээний тодорхойлолтыг харна уу.

Хувьцаа гаргагч - хувьцааныхаа тодорхой хэсгийн нийтэд тараахаар шийдсэн компани.

J

Хоёр дах шатны өр - компанийг татан буулгах тохиолдолд төлөгдөх дэс дарааллын хувьд үндсэн буюу "ахмад" зээлийн дараа орох зээл. Уг зээлийг мөн "хоёрдогч өглөг" гэж нэрлэдэг.

L

Хожуу үе шат - компани үзэл баримтлалаа батлаад, өрсөлдөгчидтэй харьцуулбал нилээд их хэмжээний орлого олоод, хөрөнгө оруулалтаа нөхөөд цэвэр ашиг олж эхлэж байгаа үе шат. Ихэнх тохиолдолд хожуу үе шатанд байгаа компани 6-гаас 12 сарын дараагаар хувьцаагаа нийтэд санал болгох эсвэл худалдагдах замаар бэлэн мөнгөний орлого авчирдаг. Хожуу үе шатны, эрсдэл багатай компаниудад хөрөнгө оруулалт хийж буй азаа турших хөрөнгөтнүүдийн өгөөжийн хувь хэмжээ нь түрүү шатны компанид хөрөнгө оруулсан этгээдийн олох хувь хэмжээнээс доогуур байдаг.

ЗХА - Зээлээр худалдан авахын тодорхойлолтыг харна уу.

Тэргүүлэх хөрөнгө оруулагч - аль нэг санхүүжилтийн үе шатанд хамгийн их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, тухайн үе шатны баримт баримт, дуусгавар болгох ажиллагааг хариуцдаг хөрөнгө оруулагч. Тэргүүлэх хөрөнгө оруулагч тухайн санхүүжилтийн үе шатны нэгж хувьцааны үнийг тогтоож улмаар компанийн үнэлгээг тодорхойлдог.

Ойлголцлын захидал - компанийн санхүүжилтийн үе шатанд оролцох хөрөнгө оруулагчийн хүсэлтийг баталгаажуулсан баримт бичиг. Уг баримт бичигт гарын үсэг зурснаар тухайн компани эрх зүйн дүн шинжилгээ болон иж бүрэн судалгааг хэлцлийг дуусгавар болгохоос өмнө эхлүүлэх үүрэг хүлээдэг. Мөн "нөхцөлтэй хуудас" гэж нэрлэгддэг.

Зээлээр дэмжих - хөрөнгө худалдан авах, үйл ажиллагааг тогтворжуулах ба орлогыг нэмэгдүүлэхэд зээл аван ашиглах явдал. Компани зээл авснаар зөвхөн үйл ажиллагааныхаа мөнгөн гүйлгээг ашигласнаас илүү богино хугацаанд үр дүнд хүрэх боломжтой болдог. Гэхдээ хөрөнгө ба орлогыг нэмэгдүүлсэн хэдий ч зээлийн хүүг төлөхөд хангалттай цэвэр ашиг болон мөнгөн гүйлгээг бий болгож чадахгүй байх эрсдэл гарч болзошгүй.

Зээлээр худалдан авах (ЗХА) - компани буюу түүний бизнесийн нэг хэсгийг гадны хөрөнгө оруулагч зээлийн хөрөнгөөр худалдан авах явдал.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) - үүсгэн байгуулагчид компанийн алдагдлыг зөвхөн оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцах өмчлөлийн бүтэц. ХХК татвар төлдөггүй харин өмчлөгчид нь ногдох ашигтаа хүн амын орлогын татварын хувь хэмжээгээр татвар төлдөг.

Хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл - ерөнхий түнш болон хэд хэдэн хязгаарлагдмал хариуцлагатай түншээс бүрдсэн хуулийн этгээд. Ерөнхий түнш хөрөнгө оруулалтыг удирдаж, түншлэлийн үйл ажиллагааны хариуцлагыг хүлээдэг харин хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд нь анх оруулсан хөрөнгө оруулалтаас

давсан хэмжээний алдагдал болон эрх зүйн арга хэмжээ хариуцдаггүй. Ерөнхий түнш удирдлагын шимтгэл, ашгийн тодорхой хувийг авдаг (хуримтлагдсан хүүгийн тодорхойлолтыг харна уу), харин хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд ашиг, олз, татварын хөнгөлөлт авдаг.

Хязгаарлагдмал хариуцлагатай түнш (ХХТ) - хязгаарлагдмал хариуцлагатай түншлэл оролцож буй хөрөнгө оруулагч. Ерөнхий түнш нь түншлэлийн үйл ажиллагааны хариуцлагыг хүлээдэг харин хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд ерөнхийдөө аливаа алдагдал, эрх зүйн арга хэмжээг зөвхөн өөрсдийн анх оруулсан хөрөнгийн хэмжээгээр хариуцдаг. Хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд орлого, олз болон татварын хөнгөлөлтийг авдаг.

Татан буулгах - компанийн үйл ажиллагааг бүрэн зогсохоос өмнө бүх хөрөнгийг нь худалдахыг хэлнэ. Татан буулгах арга замыг сонгосон компаниуд 7р бүлгийн дагуу дампуурлыг зарладаг. Татан буулгах тохиолдолд баталгаатай болон баталгаагүй зээлдүүлэгч, бонд эзэмшигч ба давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлийг энгийн хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлээс өмнө барагдуулдаг.

Татан буулгалтын давуу эрх - компанийг татан буулгахаас олох орлогыг нэн тэргүүний ээлжинд авах хөрөнгө оруулагчийн гэрээнд заасан эрх. Тухайлбал, "2х-тэй татан буулгалтын давуу эрх"-тэй аз турших хөрөнгө оруулагч компанийг татан буулгах тохиолдолд анх оруулсан хөрөнгөөс хоёр дахин нэмэгдүүлж авдаг.

Татан буулгалтын хямдрал - ижил төстэй боловч нийтэд арилжаалагдаж буй компанийн үнэтэй харьцуулбал хувийн компанийн үнэ буурах явдал. Хувийн компанид хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа бэлнээр худалдаж чадахгүй учраас хувийн компанийн хувьцаа нь нийтэд арилжаалагдаж буй ижил төстэй компанитай харьцуулбал доогуур үнэлэгдэх ёстой.

Бэлэн мөнгө болгох үйл явдал - хувийн компанийн хувьцааны нилээд их хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хувьцаагаа бэлэн мөнгөөр зарах эсвэл өөр, илүү том компанийн хувьцаагаар солих хэлцэл. Жишээлбэл үүнд хувьцааг нийтэд санал болгох ажиллагаа багтана.

Түгжих гэрээ - хөрөнгө оруулагч, компанийн удирдлага болон ажилтнууд хувьцааг нийтэд санал болгосны дараа тодорхой хугацаанд, жишээлбэл 6-гаас 12 сарын туршид эргүүлж зарахгүй байх үүрэг хүлээдэг. Хувьцаагаа их хэмжээгээр худалдахаас зайлсхийх явцад компани ирээдүйн худалдан авагчдын дунд сонирхол бий болгох цаг хугацаа хождог.

ХХТ - хязгаарлагдмал хариуцлагатай түншийн тодорхойлолтыг харна уу.

М

Компанийн удирдлага худалдан авах (УХА) - компанийн буюу түүний хэлтсийн удирдлагын багын гишүүд зээлээр худалдан авах явдал.

Удирдлагын шимтгэл - сангийн ерөнхий түнш хязгаарлагдмал хариуцлагатай түншүүдээс авах шимтгэл. Сангийн төрөл болон хэмжээнээс шалтгаалан хувийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын шимтгэл нь ихэвчлэн сангийн удирдаж буй хөрөнгийн 0.75-аас 3 хувьтай тэнцдэг.

Удирдлагын эрх - компанид хөрөнгө оруулалт хийх гэрээний нэг хэсэг болгон азаа туршиж буй хөрөнгө оруулагчийн зүгээс шаардах эрх. Азаа туршиж буй хөрөнгө оруулагч компанийн үйл ажиллагааны асуудлаар удирдлагатай зөвлөлдөх, удирдах зөвлөлийн хуралд оролцох, компанийн санхүүгийн байдалтай танилцах эрхтэй.

Зах зээлийн хөрөнжүүлэлт - нийт гаргасан хувьцааны тоог нэгж хувьцааны өнөөгийн үнээр үржүүлэх замаар тодорхойлох нийтэд арилжаалагдаж буй компанийн үнэ.

УХА - компанийн удирдлага худалдан авах.

Дунд шатны санхүүжилт - компанийн хөрөнгийн бүтцэд дэс дарааллын хувьд нэн даруй хэрэгжих санхүүжилтийн үе шат. Жишээлбэл дунд шатны өр төлөгдөх дэс дараалаллын хувьд "ахмад" зээлээс доогуур ордог боловч илүү өндөр хүүтэй, ихэнх тохиолдолд баталгаатай байдаг. Аз турших буюу эрсдэлтэй хөрөнгийн хувьд дунд шатны санхүүжилт нь компанид хувьцаагаа нийтэд санал болгох түвшинд хүрэхэд хангалттай хөрөнгөтэй болоход нь туслах зорилготой санхүүжилтийн үе шат юм.

Дунд үе шат - компани нэг буюу түүнээс олон үе шатны санхүүжилт аваад бүтээгдэхүүн буюу үйлчилгээнээсээ орлого олж эхэлж байгаа үе шат. Мөн "өсөлтийн үе шат" гэж нэрлэгддэг.

Үржүүлэгч - хувийн болон нийтэд арилжаалагдаж буй компаниудыг үнэ болон орлого буюу цэвэр ашиг зэрэг үйл ажиллагааны үзүүлэлтийн харьцаагаар хооронд нь харьцуулдаг үнэлгээний аргачлал. Жишээлбэл, компьютерийн програм хангамж үйлдвэрлэдэг, нийтэд арилжаалагддаг хэд хэдэн компани орлогоосоо 2 ойролцоогоор дахин ихээр үнэлэгдэж байгаа бол компьютерийн програм хангамжийн шинээр үүсгэн байгуулагдаж буй эрчимтэй өсч байгаа компани нь орлогоосоо 2 дахин ихээр (бэлэн мөнгөөр авах хямдралыг хасаад эсвэл хяналтын шагналыг нэмээд) үнэлэгдэх боломжтой юм..

N

МЗБ - мэдээллийг задруулахгүй байх тухай гэрээний тодорхойлолтыг харна уу.

Өрсөлдөхгүй байх тухай заалт - хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосны дараа тодорхой хугацаанд өрсөлдөгч компанид ажиллахгүй эсвэл шинэ өрсөлдөгч компани байгуулахгүй байх талаар компанийн удирдлага болон ажиллагсадтай байгуулах гэрээ.

Хуримлагддаггүй ногдол ашиг - компанийн бүх зардлыг төлж дууссаны дараа хангалттай мөнгө гүйлгээ үлдэх тохиолдолд тодорхой цаг хугацаанд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашиг. Хэрэв мөнгөн гүйлгээ хангалтгүй байвал давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид тухайн хугацааны ногдол ашиг авахгүйгээр дараагийн ээлжийн ногдол ашиг шийдвэр удирдах зөвлөлөөс гаргах хүртэл хүлээх болдог.

Оролцохгүй байх тухай заалт - хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосны дараа тодорхой хугацаанд тухайн компанийн ажилтан, худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгч болон дэд гүйцэтгэгчидтэй харьцах харилцаанд оролцохгүй байх талаар компанийн удирдлага болон ажиллагсадтай байгуулах гэрээ.

Туслалцаа хүсэхгүй байх - ажлын байрны талаар компанийн ажилтнуудаас тусламж хүсэхгүй байх талаар компанийн удирдлага болон ажиллагсадтай байгуулах гэрээ.

Мэдээллийг задруулахгүй байх тухай гэрээ (МЗБ) - бизнесийн санааг гуравдагч этгээдэд дэлгэн тавих тохиолдолд уг санааны нууцлалыг хадгалах тухай бизнес эрхлэгчийн шаардах гэрээ.

О

Санал болгох меморандум - ирээдүйн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын талаар нарийвчилсан мэдээлэл өгөх эрх зүйн баримт бичгийг хэлнэ. Уг баримт бичгийг мөн тодорхой байгууллагуудад санал болгох меморандум ба мэдээллийн меморандум гэж нэрлэдэг.

Танилцуулах арга - үзэл баримтлалыг танилцуулах арга. Заримдаа бизнес эрхлэгчдийн танилцуулга нь танилцуулах аргаараа сайн боловч агуулгаараа сул байдаг.

Опцион - хувьцааны опционы тодорхойлолтын харна уу.

Бүлэг опцион - компанийн удирдлага болон ажилтнуудад урт хугацааны, үе шаттай нөхөн олговор өгөхөд зориулсан бүлэг опционыг хэлнэ.

Өнчин компани - азаа туршиж буй хөрөнгө оруулагчийн оролцоогүй шинээр үүсгэн байгуулагдаж буй компани.

Нийт гаргасан хувьцаа - гэж компанийн гаргасан нийт энгийн хувьцааг хэлэх бөгөөд үүнд засгийн газрын үнэт цаас, давуу эрхтэй шилжих хувьцаа, баталгаа, опцион орохгүй.

Эрэлт хэрэгцээнээс давах - нийтэд санал болгож буй хувьцаа буюу тодорхой байгууллагуудын эрэлт хэрэгцээ нийлүүлэлтээс давах явдал.

Р

Төлөх эсвэл тоглох - санхүүжилтийн дараах үе шатанд оролцохгүй хөрөнгө оруулагч эзэмшиж буй хувь хөрөнгөө бусад хөрөнгө оруулагчдийг бодвол илүү ихээр буурахыг хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээх санхүүжилтийн гэрээний заалт. Төлөх эсвэл тоглох заалтын хамгийн дарамттай хувилбар нь энгийн хувьцаанд шууд шилжүүлэх явдал юм. Ингэснээр хөрөнгө оруулагч удирдлагын шийдвэрт оролцох буюу нөлөөлөх эрх зэрэг давуу эрхүүдээ алддаг.

”Пари пассу” - гэрээний хоёр буюу түүнээс олон талыг адил эрхээр хангах эрх зүйн нэр томъёо. Жишээлбэл, азаа туршиж буй хөрөнгө оруулагч санхүүжилтийн үе шатанд оролцож буй бусад хөрөнгө оруулагчидтай бүртгэлийн адил буюу ”пари пассу” эрх эдлэхийг хүлээн зөвшөөрч болох юм.

Оролцож буй ногдол ашиг - давуу эрхтэй зарим хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг авах ба бэлэн мөнгө, хувьцаа болон бусад хөрөнгийн нэмэлт хуваарилалтанд оролцох эрх.

Оролцож буй давуу эрхтэй хувьцаа - энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцаанаас бүрдсэн өмчлөлийн нэгж. Компанийг худалдах эсвэл хувьцааг нийтэд санал болгох тохиолдолд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид урьдчилан тодорхойлсон хэмжээний бэлэн мөнгө (ихэнх тохиолдолд анх оруулсан хөрөнгө оруулалт ба хуримтлагдсан ногдол ашиг) авах эрх олгодог. Энгийн хувьцаа компанид үргэлжлүүлэн эзэмших

нэмэлт өмчлөлийг илэрхийлнэ. Оролцож буй давуу эрхтэй хувьцааг бялууг аваад түүнийг идэх эрхтэй байхтай адилтгаж болох юм.

ҮА харьцаа - Үнэ, ашгийн харьцааг харна уу.

Хувьцаагаа өөр компанийн бүртгэлд оруулах эрх - шинээр үүсгэн байгуулагдсан компанийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагаанд бэлтгэх явцад хөрөнгө оруулагч хувьцаагаа компанийн бүртгэлд оруулах эрх.

НАКЭӨХХОХ - нийтэд арилжаалагдаж буй компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийхийн тодорхойлолтыг харна уу.

Борлуулах агент - хувийн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх хүсэл эрмэлзэлтэй ба чадвартай байгууллагын хөрөнгө оруулагчдийг олох чиглэлээр мэргэжсэн компани. Зарим тохиолдолд сангийн түншүүдэд хөрөнгө татан төвлөрүүлэхийн оронд компаниудад хөрөнгө оруулалт хийж удирдахад анхаарлаа төвлөрүүлэх боломж олгохын тулд хувийн хөрөнгө оруулалтын сан нь зуучлагч хөлсөлж ажиллуулдаг.

Багц дахь компани - хувийн хөрөнгө оруулалтын сангаас хөрөнгө оруулалт авсан компани.

Санхүүжилтийн дараах үнэлгээ - компанийн тухайн үе шатны санхүүжилтийг багтаасан үнэлгээ. Жишээлбэл азаа туршиж буй хөрөнгө оруулагч "санхүүжилтийн өмнөх" (хөрөнгө оруулалт хийхээс өмнө) үнэлгээгээр 2 сая ам. доллараар үнэлэгдэж байсан компанид 5 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн шинээр үүсгэн байгуулагдаж буй компанийн "санхүүжилтийн дараах" үнэлгээ нь 7 сая ам. доллар болно.

ХТББМ - Хувьцааг тодорхой байгууллагуудад борлуулах меморандумын тодорхойлолтыг харна уу.

Давуу эрх - компанийг худалдах эсвэл татан буулгах тохиолдолд ногдол ашиг болон орлого авах дэс дараалалд дээгүүр орох явдал.

Давуу эрхтэй хувьцаа - энгийн хувьцаанд байхгүй зарим эрх эдэлдэг хувьцааны төрөл. Эдгээр тусгай эрхэд ногдол ашиг авах, оролцох, бэлэн мөнгө болгох үеийн давуу эрх, эзэмшиж буй хувь хэмжээ буурахаас хамгаалах заалт, хориг тавих заалт болон бусад эрх багтдаг. Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийж буй хөрөнгө оруулагчид давуу эрхтэй хувьцааг худалдан авдаг.

Санхүүжилтийн өмнөх үнэлгээ - санхүүжилтийн өнөөгийн үе шатнаас өмнөх компанийн үнэлгээ. Жишээлбэл санхүүжилтийн өмнөх үнэлгээгээр 2 сая ам. доллараар үнэлэгдсэн компанид азаа туршиж буй хөрөнгө оруулагч 1 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийж болох юм. Ингэсний үр дүнд шинээр үүсгэн байгуулагдаж буй энэ компанийн "санхүүжилтийн дараах" үнэлгээ нь 3 сая ам. доллар болно.

Үнэ, ашгийг харьцаа (ҮА харьцаа) - нийтэд арилжаалагдаж буй компанийн нэгж хувьцааны үнэ болон нэгж хувьцаанд ногдох татварын дараахь цэвэр ашгийн харьцаа.

Хувийн компанийн эзэмшигчийн өмч - олон нийтэд арилжаалагддаггүй компаниудын эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх явдлыг хэлнэ.

Олон нийтэд арилжаалагдаж буй компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх явдал (НАКЭӨХХОХ) - хувийн хөрөнгө оруулалтын сангаас олон нийтэд арилжаалагдаж буй компанийн хувьцааг хямдралттайгаар худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх явдлыг хэлнэ.

Хувьцааг тодорхой байгууллагуудад борлуулах - үнэт цаасыг цөөн тооны байгууллагын болон шаардлага хангаж буй хувийн хөрөнгө оруулагчдад шууд борлуулах явдал. Бүтцийн хувьд зөв зохион байгуулбал, а тодорхой байгууллагуудад борлуулагдаж буй үнэт цаасыг Үнэт цаасны хороонд бүртгүүлэх шаардлагагүй байдаг.

Хувьцааг тодорхой байгууллагуудад борлуулах меморандум (ХТББМ) - ирээдүйн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын талаар нарийвчилсан мэдээлэл өгч буй баримт бичиг. Тухайлбал, байгууллагын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татах тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтын сан ХТББМ гаргана. Өсөлтийн хөрөнгө шаардагдах тохиолдолд шинээр үүсгэн байгуулагдаж буй компани мөн ХТББМ гаргаж болох юм. Уг баримт бичгийг мөн "Санал болгох меморандум" эсвэл "Мэдээллийн меморандум" гэж нэрлэдэг.

Хувийн үнэт цаас - Үнэт цаасны хороонд бүртгэгдээгүй, аливаа хөрөнгийн бирж дээр арилжаалагддаггүй үнэт цаас. Нэгж хувьцааны үнийг худалдагч (the "хувьцаа гаргагч") болон худалдан авагч хоорондоо тохиролцдог.

Дэмжих - хуримтлагдсан хүүгийн тодорхойлолтыг харна уу.

Проспект - ирээдүйн хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад нь туслах зорилгоор бизнесийн боломжийн талаар хангалттай нарийвчилсан мэдээлэл агуулсан албан ёсны баримт бичиг. Уг баримт бичигт аливаа материаллаг нөлөө үзүүлэхүйц эрсдлийг дэлгэн тавих шаардлагатай бөгөөд түүнийг Үнэт цаасны хооронд бүртгүүлдэг.

Болгоомжтой хүний дүрэм - мөнгөний мэргэжлийн удирдлагад зориулсан үндсэн зарчим. Уг зарчим Болгоомжтой хөрөнгө оруулагчийн актын үндэс болдог. Уг зарчим нь Самуэль Патнам шүүгчийн 1830 онд "бусдын өмнөөс хөрөнгө оруулалт хийх хариуцлага хүлээсэн этгээд болгоомжтой, хариуцлагатай, ухаалаг, хөрөнгө болон орлогын аюулгүй байдлыг хангасан үйл ажиллагаа явуулах ёстой" гэж хэлсэн үгэн дээр үндэслэдэг.

Q

Дөрөвний нэг - мэдээллийн багц дахь мэдээллийн цэгүүдийн дөрөвний нэг. Компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийсэн этгээдийг хөрөнгөө оруулалтаас нь тодорхой хугацаанд гарсан үр дүнгээр хэмжидэг. Байгууллагын хөрөнгө оруулагчид тууштай үр дүн үзүүлж буй сангуудад хөрөнгө оруулалт хийх эрмэлзэлтэй байдаг. Эдгээр сангийн үр дүн нь бүх сангийн хөрөнгө оруулалтын үр дүнгийн дээд талын дөрөвний нэгт багтдаг.

R

Ратчет - эзэмшиж буй хувь хэмжээг бууруулахаас урьдчилан сэргийлэх механизм. Компани нэмэлт хувьцаа гаргаж бусад аж ахуйн нэгжид тараасны улмаас хөрөнгө

оруулагчийн тухайн компанид эзэмшиж буй хувь их хэмжээгээр буурах явдлаас хөрөнгө оруулагчийг хамгаалах гэрээний заалтыг хэлнэ.

Хуваарилалтын харьцаа - хуваарилагдахаар хуримтлагдсан хөрөнгө болон төлөгдсөн хөрөнгийн харьцаа. Удирдаж буй хөрөнгөтэй харьцуулбал компанийн эзэмшигчийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх түншлэлийн хөрөнгө оруулалтын үр дүнгээс хийх хуваарилалтын хэмжүүр болгон ашигладаг.

Дахин хөрөнгөжүүлэлт - гэж компанийг хөрөнгийн бүтцийг өөрчлөн зохион байгуулах явдлыг хэлнэ.

”Улаан май загас” - нийтэд санал болгож буй хувьцааны талаар нарийвчилсан мэдээлэл агуулсан, Үнэ цаасны хороонд бүртгүүлсэн урьдчилсан баримт бичиг. Ирээдүйн хөрөнгө оруулагчдийг холбогдох эрсдлийн талаар сануулах зорилгоор уг баримт бичгийн нүүр хуудас дээр улаан үсгээр сануулга бичсэн байдаг учраас ингэж нэрлэдэг.

Бэлэн мөнгөөр солих боломжтой давуу эрхтэй хувьцаа - тодорхой хэмжээний бэлэн мөнгөөр солих боломж эзэмшигчид (ихэнх тохиолдолд азаа туршиж буй хөрөнгө оруулагч) олгодог давуу эрхтэй хувьцаа.

Бэлэн мөнгөөр солих эрх - хөрөнгө оруулалтын үр дүнд гаргасан хувьцааг шинээр үүсгэн байгуулагдсан компаниар эргүүлж худалдан авуулах шаардлага тавих хөрөнгө оруулагчийн эрх. Хөрөнгө оруулагч өөрийнхөө хөрөнгө оруулалтыг эргүүлж авах эрхтэйгээс гадна анх оруулсан хөрөнгө оруулалтаасаа давсан хэмжээний нэмэлт мөнгө авах талаар хэлэлцээр хийх эрхтэй.

Бүртгэл - гэж компанийн хувьцааг нийтэд санал болгоход бэлтгэхдээ 1933 оны Үнэт цаасны тухай хуулиар Үнэт цаасны хороонд бүртгүүлэх үйл ажиллагаа.

Бүртгэлийн эрх - хөрөнгө оруулагчийн шинээр үүсгэн байгуулагдсан компанийн хувьцааны тодорхой хэсгийг нийтэд санал болгохоор бүртгүүлэхтэй холбоотой эрх. **Piggyback rights** хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа бүртгэлд оруулах эрх олгодог. Шаардлага тавих эрх нь хувьцаа эзэмшигчдэд компанийн хувьцааг нийтэд санал болгохоор бүртгүүлэх талаар удирдлагыг шахан шаардах эрх олгодог. Азаа туршиж буй хөрөнгө оруулагчид бүртгэлийн эрхийг санхүүжилтийн хэд хэдэн үе шатны туршид хэлэлцдэг.

Хязгаарлалттай хувьцаа - гэж зах зээл дээр олон нийтэд арилжаалагдах эрхгүй хувьцааг хэлнэ.

Хөрөнгө оруулалтын өгөөж (ХОӨ) - гэж хөрөнгө оруулалтаас тодорхой хугацаанд олох ашгийг хэлэх бөгөөд үүнийг анх оруулсан хөрөнгөтэй харьцуулсан хувиар илэрхийлнэ. Үүнийг мөн татварын дараах цэвэр ашгийг нийт дундаж хөрөнгөөр хувааж илэрхийлж болно.

Эрх олгох - гэж шинээр гаргасан хувьцааг ихэвчлэн хямдруулсан үнээр худалдаж авах эрх олгох замаар хувьцааг компанийн өнөөгийн хувьцаа эзэмшигчдэд санал болгох явдлыг хэлнэ.

Үүсгэн байгуулагчтай хамт худалдах эрх - шинээр үүсгэн байгуулагдсан компанийн үүсгэн байгуулагчид хувьцаагаа худалдах шийдвэр гаргахад аз турших сан мөн хувьцаагаа худалдах эрхтэй байх тухай аз турших буюу эрсдэлтэй хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан заалт.

”Эхэлж татгалзах эрх” - гэрээгээр олгосон хэлцэлд оролцох эрх. Жишээлбэл, азаа туршиж буй хөрөнгө оруулагч шинээр байгуулагдаж буй компанид хөрөнгө оруулалт хийх нэгдүгээр үе шатанд оролцож, харин хөрөнгө оруулалтын дараагийн үе шатуудад ”эхэлж татгалзах эрх” хүсч болох юм.

Танилцуулах аялал - ирээдүйн хөрөнгө оруулагч болон бусад сонирхож буй талуудад зориулан хэд хэдэн хотод хийх танилцуулга. Тухайлбал, компани хувьцаагаа олон нийтэд санал болгохоосоо өмнө байгууллагын хөрөнгө оруулагчдын дунд сонирхол бий болгохын тулд ”танилцуулах аялал” зохион байгуулдаг.

ХОӨ - хөрөнгө оруулалтын өгөөжийн тодорхойлолтыг харна уу.

Том компани жижгийг худалдан авах - гэж аль нэг салбарын харьцангуй жижиг компаниудыг тухайн салбарын хурдан өсч өргөжиж буй компани худалдан авах явдлыг хэлнэ. Зардлыг бууруулах стратеги юм.

Үе шат - хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх хэд хэдэн хөрөнгө оруулагчдийг оролцуулсан санхүүжилтийн үе шат.

S

Жижиг бизнесийн хөрөнгө оруулалтын компани (ЖБХОК) - гэж аз турших хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглах хөрөнгө бий болгохын тулд засгийн газрын хямдралттай зээл авах эрхийг Жижиг бизнесийн байгууллагаас авсан компанийг хэлнэ.

Огцом өсөх шинж чанар -зохион байгуулалт болон зардал харьцангуй удаан өсч байхад борлуулалт ба түүний орлого илүү хурдан өсөх нөхцлийг тусгасан бизнесийн шинэ үзэл баримтлалын онцлог шинж чанар. Азаа туршиж буй хөрөнгө оруулагчид санхүүжүүлэхээр сонгосон шинээр үүсгэн байгуулагдсан компанид энэ шинж чанарыг хайдаг.

Огцом өсөх - компани үйл ажиллагаа болон санхүүгийн хяналтаа нэг түвшинд хадгалахын зэрэгцээ хурдан өсөх явдал.

ҮЦХ - Үнэт цаасны хорооны тодорхойлолтыг харна уу.

Хоёрдогч зах зээл - гэж хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх сангуудад эзэмшиж буй хувийг худалдах зах зээлийг хэлнэ. Заримдаа хязгаарлагдмал хариуцлагатай түншүүд бэлэн мөнгө олох зорилгоор эсвэл ”хөрөнгө үе шаттай” хуваарийн дагуу хөрөнгө оруулалт хийх үүргээ гүйцэтгэж чадахгүй болсны улмаас түншлэлд эзэмшиж буй хувь хөрөнгөө худалддаг. Зарим хөрөнгө оруулалтын компаниуд эдгээр хувь хөрөнгийг хямдруулсан үнээр худалдаж авах чиглэлээр мэргэждэг.

Үнэт цаас - гэж компанид эзэмшиж буй хувь хөрөнгийг илэрхийлэх баримт бичгийг хэлнэ. Хувьцаа, өрийн бичиг ба бонд зэрэг нь үнэт цаасны жишээ юм.

Үнэт цаасны хороо - гэж үнэт цаасны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй зохицуулалтын байгууллагыг нэрлэнэ.

Үрийн хөрөнгө - гэж шинэ компанийн үүсгэн байгуулагчдад үрийн үе шатанд ивээн тэтгэгч, найз, гэр бүлийн гишүүдээс олгох хөрөнгө оруулалтыг хэлнэ.

Үрийн үе шат - компани дөнгөж байгуулагдаад, үүсгэн байгуулагчид нь бүтээгдэхүүн буюу үйлчилгээг хөгжүүлж байх үе шат.

"Ахмад" өр - гэж компанийг татан буулгах тохиолдолд төлөгдөх дэс дарааллын хувьд дээгүүр орох зээлийг хэлнэ.

Тэргүүлэх - гэж дэс дарааллын хувьд дээгүүр орох буюу нэн тэргүүнд байх явдлыг хэлнэ.

"А" цувралын давуу эрхтэй хувьцаа - гэж хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийн "А" үе шатанд авах хөрөнгө оруулалтын оронд хурдан өсч өргөжиж буй компаниас гаргах давуу эрхтэй хувьцааг хэлнэ. Компанийг худалдах эсвэл хувьцааг нь олон нийтэд санал болгох үед давуу эрхтэй хувьцааг ихэнх тохиолдолд энгийн хувьцаанд хөрвүүлдэг.

Бие даах - гэж үйл ажиллагаа нь тогтворжсон компанийн салбар бие даасан аж ахуйн нэгж болох явдлыг хэлнэ.

Хувьцаа - гэж компанийг өмчлөх хувийг хэлнэ.

Хувьцааны опцион - гэж хувьцааг тодорхой хугацаанд тодорхой үнээр худалдах эсвэл худалдан авах эрхийг хэлнэ. Хувьцааг худалдаж авах опцион нь хурдан өсч өргөжиж буй компанийн удирдлага, ажилтнуудад урт хугацааны урамшуулалын нөхөн олговор болон түгээмлээр ашиглагддаг.

Стратегийн хөрөнгө оруулагч - гэж proprietary технологи, бүтээгдэхүүн буюу үйлчилгээг хүртэх зорилгоор шинэ компанид хөрөнгө оруулалт хийж, стратегийн зорилгодоо хүрдэг харьцангуй том корпорацийг хэлнэ.

Хоёрдогч өглөг - гэж компанийг татан буулгах тохиолдолд үндсэн зээлийг бодвол дэс дарааллын хувьд доогуур орох зээлийг хэлнэ. Уг зээлийг мөн "хоёр дах шатны өр" гэж нэрлэдэг.

Хөлсөөр бий болгосон эзэмшигчийн өмч - гэж хөрөнгө оруулахын оронд ажиллаж бий болгосон хувьцаа өмчлөлийг хэлнэ.

Синдикат - гэж компанийг санхүүжүүлэх аль нэг үе шатанд оролцох бүлэг хөрөнгө оруулагчдыг хэлнэ. Үүнээс гадна синдикат гэдэгт анх хувьцааг олон нийтэд санал болгох ажиллагааны нэг хэсэг болгон хувьцааг олон нийтэд борлуулах үйл явцад оролцох хөрөнгө оруулалтын банкуудын бүлгийг ойлгож болох юм.

Синдикац - гэж синдикат байгуулах ажиллагааг хэлнэ.

Т

Адил эрх - гэж хөрөнгө оруулагч компанийн хувьцааны ихэнх хувийг эзэмшиж буй өмчлөгчидтэй адил эрх авах явдлыг хэлнэ. Тухайлбал, компанийн ихэнх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч компанид эзэмшиж буй өөрийнхөө хувийг худалдах тохиолдолд компанийн цөөн хувийг эзэмшиж байгаа гэхдээ "адил эрхтэй" хөрөнгө оруулагч өөрийнхөө хувийг худалдах адил эрхтэй болно.

Хөрөнгийг үе шаттай гаргах - амласан хөрөнгийг гаргахдаа үе шаттай шилжүүлэх хуваарь. Хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх сангийн

ерөнхий түнш хязгаарлагдмал хариуцлагатай түншүүдээсээ хөрөнгө шилжүүлэн авах төлөвлөгөөг гаргахдаа "takedown" ашигладаг.

Хяналт шилжих - гэж компанийн хяналтыг шилжүүлэх явдлыг хэлнэ.

10 дахин - гэж анх оруулсан хөрөнгийг 10 дахин өсгөх боломжтой хөрөнгө оруулалтыг хэлнэ.

Нөхцөлтэй хуудас - хөрөнгө оруулагч компанийн санхүүжилтийн аль нэг үе шатанд оролцох хүсэлтэй байгааг баталгаажуулсан баримт бичиг. Энэхүү баримт бичигт гарын үсэг зурснаар тухайн компани хэлцлийг дуусгавар болгохоос өмнөх эрх зүйн дүн шинжилгээ болон иж бүрэн судалгааны ажлыг эхлэх үүрэг хүлээнэ. Уг баримт бичгийг мөн "Ойлголцлын захидал" гэж нэрлэнэ.

Эргүүлэх - компанийн орлого, ашиг ба нэр хүнд нилээд ихээр нэмэгдүүлэх ажиллагаа.

Хоёр х - гэж анх оруулсан хэмжээнээс хоёр дахин ихийг авахыг хэлнэ. Жишээлбэл, давуу эрхтэй хувьцаа нь татан буугдах тохиолдолд "хоёр х" гэсэн давуу эрхтэй байж болох бөгөөд компанийг татан буулгахад давуу эрхтэй хувьцаанд хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагч анх оруулсан хөрөнгөсөө хоёр дахин ихийг авна гэсэн үг юм.

U

Андерайгэр - шинээр гаргаж буй үнэт цаасыг олон нийтэд арилжаалах ажиллагааг хариуцах үүрэг хүлээсэн хөрөнгө оруулалтын банк. Үнэт цаасны хуваарилалт арилжааг аль болох нэмэгдүүлэхийн тулд андерайгтер хөрөнгө оруулалтын банкуудын синдикаттай хамтран ажилладаг.

V

Аз турших капитал - гэж хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийх салбарын өсөлтийн өндөр хувьтай шинэ компаниудад хөрөнгө оруулалт хийх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг хэсгийг хэлнэ.

Эрсдэлтэй капиталын аргачлал - компанийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохдоо компанийн ирээдүйн үнийн баримжааг тодорхой нэг хүүгийн хувиар хорогдуулж, ирээдүйд гарч болзошгүй шингэлэх явдлын тохируулга хийх үнэлгээний аргачлал. Ихэнх тохиолдолд эрсдэлтэй капиталын аргачлалын хорогдуулах хувь нь олон нийтэд арилжаалагдаж буй хувьцааны өгөөжийн хувиас нилээд өндөр байдаг ба аз туршиж буй хөрөнгө оруулагчид батлагдаагүй компаниудыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдлээ нөхөхийн тулд хөрөнгө оруулалтаасаа нилээд их хэмжээний өгөөж шаардлагийг илэрхийлдэг юм.

Эхлэлийн хугацаа - хувийн компанийн эзэмшигчийн өмчид хөрөнгө оруулалт хийдэг сан шинэ хөрөнгө оруулагчдийг элсүүлэх явдлыг зогсоож тэдгээрийн өмнө хөрөнгө оруулалт хийж эхлэх жил.

Санал өгөх эрх - гэж компанийн давуу эрхтэй болон энгийн хувьцаа эзэмшигчдийн компанид нөлөөлөх зарим асуудлаар санал өгөх эрхийг хэлнэ. Эдгээр асуудалд ногдол ашгийн төлөлт, шинэ ангилалын хувьцаа гаргах, нэгдэх ба татан буулгахтай холбоотой асуудлууд багтаж болох юм.

W

Баталгаа - эзэмшигчдээ компанийн хувьцааг урьдчилан тохиролцсон үнээр худалдаж авах эрх олгож буй үнэ цаас. Варрант нь хэдэн жил буюу хязгаарлалтгүй хугацаанд хүчинтэй урт хугацаатай опцион юм. Ирээдүйн хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд варрантыг ихэвчлэн давуу эрхтэй хувьцаа буюу бондтой нэг зэрэг гаргадаг.

Угаагдах үе шат - компанид урьд өмнө хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчид, үүсгэн байгуулагчид болон удирдлагын эзэмшиж буй хувь хэмжээ нь нилээд их хэмжээгээр шингэлэгдэх санхүүжилтийн үе шат. Ихэнх тохиолдолд washout үе шатны үр дүнд шинэ хөрөнгө оруулагч компанийн хяналт ба ихэнх хувийн өмчлөлийг авдаг.

Жигнэсэн дундаж "ратчет" - гэж компанийн хувьцааны тоо нэмэгдсний улмаас хөрөнгө оруулагчид учрах алдагдлыг багасгах зорилгоор давуу эрхтэй хувьцааны хөрвөх хувьд тохируулга хийх хувьцааны тоог нэмэгдүүлэхийн эсрэг хамгаалалтын механизмыг хэлнэ. Ратчетгүйгээр хөрөнгө оруулагчид эзэмшиж буй хувь хэмжээг нь шингэлэх явдлаас хохирол учирна. Жигнэсэн дундаж ратчетыг хэрэгжүүлсний үр дүнд тодорхой тоо ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг компанийн удирдлага болон ажилтнуудын эзэмшиж буй хувь нь нилээд хэмжээгээр багасдаг боловч энэ нь бүтэн ратчетэй харьцуулбал тийм ихээр биш юм.

Арчигдах үе шат - угаагдах үе шат гэдгийг харна уу.

"Гүүр" санхүүжилтийн хэлбэр - компани тодорхой цаг хугацаанд урт хугацааны нэмэлт санхүүжилт олж чадаагүй тохиолдолд "гүүр" олгосон хөрөнгө оруулагч нь компанийг өмчлөх хяналтын эрхийг авах тухай ярвигтай нөхцөлтэй заалт тусгасан богино хугацаатай санхүүжилтийн хэлбэр. Мөн "гүүр" санхүүжилт гэдгийг харна уу.

Бууруулах бичилт - гэж компани буюу хөрөнгийн бүртгэлийн үнэ буурахыг хэлнэ.

Хасах бичилт - гэж компани буюу хөрөнгийн бүртгэлийн үнэ "0" хүртэл буурахыг хэлнэ.

Нэмэгдүүлэх бичилт - гэж компани буюу хөрөнгийн бүртгэлийн үнэ нэмэгдэхийг хэлнэ.

Z

Зомби - гэж хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалт авсан боловч цаашид өсөхгүйгээр зөвхөн үйл ажиллагааныхаа зардлыг нөхөх хэмжээний орлого болон мөнгөн гүйлгээ бий болгож буй компанийг хэлнэ. Азаа туршиж буй хөрөнгө оруулагч зомбийг татан буулгах уу эсвэл түүнд оруулах хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлж түүнийг ялагч болно гэдэгт найдах уу гэдэг талаар хэцүү шийдвэр гаргах хэрэгтэй болдог.